

**АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ "БҮТЭЭЛЧ АРВАЙХЭЭР"  
ХӨТӨЛБӨРИЙН 2018 ОНЫ ХЭРЭГЖИЛТ**

2018.12.05

Арвайхээр

№	Бодлогын зорилт, арга хэмжээ	Биелэлт	Үнэлгээ		
			2018	2020	
<b>Нэгдүгээр бүлэг. Нийгмийн бодлого зохицуулалт</b>					
<b>1.1 Эрүүл мэндийн үйлчилгээ</b>					
1.	1.1.1. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ӨЭМТөв, багийн Засаг даргын хамтын ажиллагааг эрчимжүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад олон улсын болон иргэний нийгмийн байгууллага, иргэд, гэр бүл, хамт олны үр дүнтэй бүтээлч харилцаа, түншлэлийг дэмжин ажиллана.	<p>1. Сумын нийт хүн амд үзүүлэх эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг жил бүр зохион байгуулж, нийт хүн амын 50-иас доошгүй хувийг хамруулах</p> <p>2. ӨЭМТөвүүдийн дэргэдэх Нийгмийн эрүүл мэндийн кабинетыг түшиглэн ӨЭМТөв, багийн Засаг даргын хамтын ажиллагааны хүрээнд эрүүл зан үйл төлөвшүүлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулах</p>	<p>Сумын дүнгээр 17837 иргэн буюу нийт хүн амын 58 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж, урьд оны мөн үеэс 5 хувиар өссөн. 2018 онд “Уян сэтгэл” өрхийн эрүүл мэндийн төв 20649 иргэнд эрүүл мэндийн үзлэг хийснээс урьдчилан сэргийлэх үзлэгт 5991 иргэн, “Түшиг дөлгөөн” өрхийн эрүүл мэндийн төв 18815 иргэнд эрүүл мэндийн үзлэг хийснээс урьдчилан сэргийлэх үзлэгт 5007 иргэн, “Нарны дөш” өрхийн эрүүл мэндийн төв 20649 иргэнд эрүүл мэндийн үзлэг хийхнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 5991 иргэн нийт дүнгээр эрүүл мэндийн үзлэгт 54874 иргэн урьдчилан сэргийлэх үзлэгт 16589 иргэн хамруулсан нь нийт иргэдийн 53,7 хувийг хамруулсан нь урьд оноос 1.7 хувиар өссөн байна.</p> <p>Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд Нийгмийн эрүүл мэндийн кабинетийн үйл ажиллагаа тогтмолжиж, дараах сургалт мэдээлийн ажлыг эрүүл мэндийн Нийгмийн ажилтан, ерөнхий боловсролын сургуулийн эмч болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эмч нар хамтран халдварт бус өвчний чиглэлээр 75 удаагийн сургалтад давхардсан тоогоор 8738 иргэн, халдварт өвчний чиглэлээр 52 удаагийн сургалтад 7799 иргэн, эх хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр 41 удаагийн сургалтад 1431 иргэн, архи тамхи мансууруулах бодисын хор хөнөөлийн талаар 18 удаагийн сургалтад 782 нийт дүнгээр 201 удаагийн сургалтад 18816 иргэнийг хамрууллаа. “Эрүүл хот хөтөлбөрийг чадавхжуулах төв” төрийн бус байгууллагаас зохион байгуулсан сургалтад Засаг даргын орлогч хотын захирагчийн албаны мэргэжилтний хамт хамрагдан хөрсний бохирдол, тамхидалтын эсрэг хувьсгал компанит ажлыг төрийн болон төрийн бус томоохон аж ахуйн нэгж 65 байгууллага, 2600 ажилтан, ахлах дунд ангийн 3060 сурагч, 13 багийн 1300 иргэнд сургалт, мэдээллийн ажлыг хийсэн. Түгийн овооны хогийн цэгт техникийн нөхөн сэргээлтийг аймгийн орон нутгийн төсвийн 89.4</p>	100	70
			100	70	

			сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Элемент ХХКомпани” хийж гүйцэтгэсэн нь сумын нутаг дэвсгэрийн хөрс агаарын бохирдлыг бууруулж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлсэн.		
		3. Сумын Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг жил бүр төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, үр дүнг тооцох	Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн ажлын нэгдсэн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 12 зорилт, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, биелэлт 11 сарын дүнгээр 90 хувийн хэрэгжилттэй байгаа нь урьд оноос 15 хувиар ахисан байна.	100	70
		4. Байгууллага, иргэд, гэр бүл, хамт олны хүрээнд нарны гүйлт, дасгал хөдөлгөөнийг хэвшүүлэх ажлыг зохион байгуулж, дадал хэвшил болгох	ЕБСургууль, цэцэрлэгүүд багш, сурагчид өдөр бүр их завсарлагаагаар тогтсон цаг хуваарийн дагуу ажлын байрны дасгал хөдөлгөөн, хөгжимт дасгалыг хийж хэвшсэн. Багуудад өглөөний нарны гүйлт, биеийн чийрэгжүүлэх дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж хэвшсэн иргэдийн тоо нэмэгдэж, чийрэгжүүлэлт фитнес клубээр хичээллэгсдийн эрс нэмэгдсэн. 1, 9, 12 багууд багийн төвтэй спорт зал, багийн нэгдсэн төвийн дэргэд спорт зал 2, 7 дугаар багуудын дэргэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар спорт зал баригдаж ашиглалтад орж эхэлж байгаа нь иргэд, байгууллага хамт олон спортоор хичээллэж, эрүүл зөв амьдрах дадал хэвшлийг тогтмолжуулах нөхцөл бүрдлээ.	70	70
2.	1.1.2 Иргэдийг жил бүр зонхилох өвчлөлийн чиглэлээр урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг тогтмолжуулж, онош тодруулах шаардлагатай иргэдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулна.	5. Иргэдийг жил бүр зонхилох өвчлөлөөс /цусны даралт ихсэх өвчин, чихрийн шижин, элэгний В, С вирусын халдвар/ урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах	2018 онд В, С вирусын эрт илрүүлгийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд 15-39 насны хамрагдвал зохих 8569 иргэнээс 4449 иргэн буюу 51,9 хувийг хамрууллаа. 40-65, 65-аас дээш насны 293 иргэнийг 2018 онд шинжилгээнд хамруулсан. Урьд онд оношлогдсон иргэдээс 280 иргэн эмчилгээнд хамрагдсан байна. 2018 онд цусны даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн үзлэгт 40-65 насны 5220 иргэн хамрагдсан нь хамрагдвал зохих иргэдийн 72,2 хувь, чихрийн шижин хэв шинжийн эрт илрүүлгийн үзлэгт 4979 иргэн, 2018 онд 40-65 насны 5284 иргэн хамрагдсан нь хамрагдвал зохих иргэдийн 71.4 хувийг хамрууллаа.	70	70
		6. Онош тодруулах шаардлагатай иргэдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд жил бүр	15-39 насны элэгний В, С вирусын эрт илрүүлгийн шинжилгээнд хамрагдаж В вирус эерэг 279, С вирус эерэг 79 иргэнээс илэрсэн нь вирусын ачаалал тодорхойлох шинжилгээгээр оношлогдсон. Эмчилгээнд хамруулах ажлыг иргэд харъяа Өрхийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношлогоо эмчилгээний төв хамтран зохион	100	70

		хамруулж, хяналтанд авч эмчлэн эрүүлжүүлэх	байгуулж байна. 2017 онд онош тодруулах шаардлагатай 988 иргэнийг БОЭТөвийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулснаас цусны даралт ихсэх өвчнөөр 47, чихрийн шижин өвчнөөр 3, элэгний В вирустай 300, С вирустай 638 иргэн, 2018 онд цусны даралт ихсэх өвчнөөр 50, чихрийн шижин өвчнөөр 4, элэгний В вирустай 279, С вирустай 79 эрт илрүүлгийн үзлэгүүдээр онош тодорсон иргэдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулж, Өрхийн эрүүл мэндийн төвийн болон нарийн мэргэжлийн хяналтанд эмчлэн эрүүлжүүлэх ажил тухай бүр хийгдэж байна.		
3.	1.1.3 Халдварын бус өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эрүүл зан үйлийг төлөвшүүлэн, эрүүлмэндийн сайн дурын бүлэг, ажилтнуудыг чадавхижуулж, санхүүгийн хөшүүргийг нэмэгдүүлэх замаар бүх нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж, “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	7.Халдварын бус өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг ТББайгууллага, эрүүл мэндийн сайн дурын бүлэг, ажилтнуудаар гүйцэтгүүлэх ажлыг эхлүүлж, үр дүнг тооцох	Халдварын бус өвчлөл 2018 онд 3164 бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 14,1 хувиар буурсан. 2018 онд халдварын бус өвчний чиглэлээр Өрхийн эрүүл мэндийн төвүүд ДЗОУБайгууллага, эмийн сангууд, УЗНийгэмлэг, АА бүлэг, орон нутгийн телевизүүд зэрэг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж 75 удаагийн сургалтад 8738 иргэнийг эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад хамруулж, мэдээлэл сурталчилгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Ерөнхий боловсролын сургуулиудад залуу эмч клуб 7 ажиллаж түүнийг түшиглэн нийт 85 сурагч, сургуулийн өмнөх 11 багш, багийн 11 нийгмийн ажилтан, өрхийн эрүүл мэндийн төвийг түшиглэн 80 гаруй эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн эрүүл мэндийн сайн дурын сургагч багшаар бэлтгэгдэн эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаанд хамтран ажиллаж байна.	70	70
		8.Архи, тамхи, мансууруулах бодисын хор хөнөөлийн талаарх мэдээллийг иргэд олон нийт ялангуяа өсвөр насны хүүхдүүдэд түгээх, сэрэмжлүүлэх ажлыг зохион байгуулах	Хорт зуршлаас татгалзах, аддиктологийн багаар хамтран ажиллаж архи хэтрүүлэн хэрэглэгчдэд уулзалт, ярилцлага зохион байгуулж, АА бүлгийн гишүүдээр зөвлөгөө мэдээллийг өгч байна. Тус суманд АА-гийн 3 бүлэг тогмол үйл ажиллагаа явуулж байна. Тус бүлэг хэсгийн байцаагч нартай хамтран архи хэтрүүлэн хэрэглэсний улмаас баривчлагдсан, саатуулагдсан иргэд болон тэдгээрийн ар гэрт зөвлөгөө мэдээллүүдийг хүргэн ажилласан. 2017 онд тамхи татахгүй дэлхийн өдрөөр “Тамхинд үгүй гэж хэлье” сэдэвт өдөрлөгийн арга хэмжээ зохион байгуулж 900 ширхэг гарын авлагыг тарааж, тамхины хор уршгийн талаар мэдээлэл сурталчилгаа хийн өртөө ажиллуулсан бол 2018 онд “Ажлын байрны агаар цэвэр байх ёстой, тамхидалтын эсрэг хувьсгал компани ажил”-ыг хүрээнд төрийн болон хувийн	40	70

			хэвшлийн нийт 65 байгууллагад сургалт мэдээллийг өгч тухайн байгууллагадтай хамтран байгууллага бүр төлөвлөгөө гарган ажиллаж байна. 2018 онд өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нийт дүнгээр архи, тамхи, мансууруулах бодисын хор хөнөөлийн талаарх мэдээлэл нөлөөлийн ажлыг 18 удаа хийж, давхардсан тоогоор 782 иргэнийг хамрууллаа.		
		9. Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгааг аян, өдөрлөг, уралдаан тэмцээний хэлбэрээр зохион байгуулах	ЕБСургуулийн бага ангийн сурагчдыг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд аюулгүй оролцуулах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр “Гэрэл ойлгогч цацруулагч тууз”-аар хангах ажлыг удирдамжийн дагуу 1-5 дугаар ангийн 119 бүлгийн 4350 сурагч, ЕБ-ын 2 дугаар сургуулийн тусгай бүлгийн 35 сурагчдыг гэрэл ойлгогч цацруулагчтай туузаар хангасан. Гэрэл ойлгогч цацруулагчийн санхүүжилтэд шаардлагатай 2850900 төгрөгийг аймгийн Засаг дарга шийдвэрлэж өглөө. Боловсролын байгууллагууд эмч болон бусад ажилчдаас хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэргэшсэн албан хаагчийг бэлтгэн ажиллуулж, сургууль цэцэрлэгийн гадна дотно орчин болон эцэг, эхчүүдэд хүүхдээ ахуйн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл сургалт, сурталчилгааны ажлыг хийж эхлүүлээд байна. 2018 оны дүнгээр бүртгэгдсэн ахуйн осол 27 тохиолдол байгаа нь өмнөх оноос 7 буюу 20,6 хувиар буурсан. Ахуйн ослын дийлэнх хувийг түлэгдэлт эзэлж байгаа бөгөөд энэ чиглэлээр ӨЭМТөв, ЕБСургууль, СӨББайгууллагууд эцэг, эх, асран хамгаалагч нарт мэдээлэл нөлөөллийн ажил хийгдэж байна.	70	70

		10. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	“Элэг бүтэн-Монгол” хөтөлбөрийн хүрээнд 2017 онд сумын дүнгээр 40-65 насны хамрагдвал зохих 7321 иргэнээс 3504 иргэн буюу 47.9 хувийг үзлэг шинжилгээнд хамруулж, 317 иргэн В вирус, 685 иргэн С вирус илэрсэн иргэд вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээнд хуваарийн дагуу хамрагдсан. 2018 онд В, С вирусын эрт илрүүлгийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд 15-39 насны хамрагдвал зохих 8569 иргэнээс 4449 иргэн буюу 51,9 хувийг хамрууллаа. 40-65, 65-аас дээш насны 293 иргэнийг 2018 онд шинжилгээнд хамруулсан. Урьд онд оношлогдсон иргэдээс 280 иргэн эмчилгээнд хамрагдсан байна. 15-39 насны хамрагдсан иргэдээс элэгний В вирус эерэг 279, С вирус эерэг 79 иргэн эрт илрүүлгийн үзлэгүүдээр онош тодорсон иргэдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулж, өрхийн эрүүл мэндийн төвийн болон нарийн мэргэжлийн хяналтад эмчлэн эрүүлжүүлэх ажил тухай бүр хийгдэж байна.	70	70
4.	1.1.4 Халдварт өвчин, ялангуяа бэлгийн замаар дамжих халдварт /ХДХВ/ДОХ/БЗДХ/ өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах замаар өвчлөлийг бууруулна.	11. Томуу томуу төст өвчин, салхин цэцэг, улаан бурхан, сүрьеэ гэх мэт зонхилон тохиолдох халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд тархалтыг зогсоох арга хэмжээг тухай бүр авч ажиллах	Халдварт өвчний тандалт судалгааг тухай бүр хийж, урьдчилан сэргийлэх, дэгдэлтийн үед авах арга хэмжээний төлөвлөгөөг өрхийн эрүүл мэндийн төв, сургууль, цэцэрлэгүүд боловсруулан хэрэгжүүлж байна. 2018 онд томуу томуу төст өвчнөөр 1214 иргэн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 2,1 хувиар буурсан. Халдварт өвчин: <ul style="list-style-type: none"> <li>✓ Салхин цэцэг 2017 онд 265 байсан бол 2018 онд 77 гарч буурсан,</li> <li>✓ Улаан бурхан 2017 онд 1, 2018 онд гараагүй</li> <li>✓ Гар хөл амны өвчнөөр 2017 онд 18 тохиолдол, 2018 онд 82 тохиодол,</li> <li>✓ Гэдэсний халдварт өвчнөөр 2017 онд 92, 2018 онд 138</li> <li>✓ Сүрьеэгээр 2017 онд 23, 2018 онд 21</li> <li>✓ БЗДХалдварт өвчнөөр 2017 онд 129, 2018 онд 173</li> </ul>	70	70
		12. ЕБ-ын сургуулийн ахлах ангийн сурагчдыг бэлгийн замын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг холбогдох	2017-2018 оны хичээлийн жилд аймгийн ЭМГазар, ӨЭМТөв, сургуулиудын эмч нар хамтран МСҮТөв, ЕБ-ын сургуулиудын ахлах ангийн нийт 922 охидыг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж, өвчлөлтэй гарсан 8 охидыг эмчлэн эрүүлжүүлсэн. 2018-2019 оны хичээлийн жилд охидын урьдчилан сэргийлэх үзлэгт МСҮТөвийн болон ЕБСургуулийн 9-12 дугаар 954 охид хамрагдахаас 934 буюу 98 хувьтай хамруулж, сургалт	100	70

		байгууллагуудтай хамтран жил бүр зохион байгуулж, үр дүнг тооцох	мэдээллийн ажлыг өсвөр насны охидын нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр хийлээ.		
		13. Цэргийн насны залуучуудыг бэлгийн замаар дамжих халдварт /ХДХВ/ДОХ/БЗДХ/ өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг жил бүр зохион байгуулж, үр дүнг тооцох	2018 оны ээлжит цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгт 18-25 насны 789 залуучууд хамрагдснаас бэлгийн замаар дамжих халдварт /ХДХВ/ДОХ/БЗДХ/ өвчний өвчлөлтэй 35 тохиолдол гарсныг БОЭТөвийн ДОХ/БЗДХКабинетад эмчлэн эрүүлжүүлж, тус иргэдийг бүрэн эдгэрэх хүртэлх хугацаанд эмчийн хяналтад байлгах чиглэлээр сумын цэрэг татлагын комисс, ӨЭМТөв, багийн Засаг даргын ажлын албан хамтран ажиллалаа. 2018 оны цэргийн үзлэгээр илэрсэн өвчлөл нь урьд оноос 5 тохиолдлоор нэмэгдсэн байна.	70	70
5.	1.1.5 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг засаг захиргааны болон эрүүл мэндийн салбарын хосолмол удирдлагатай болгож, түр оршин суугчид болон 180 хоногоос дээш хугацаагаар оршин суудаг иргэдийн зардлыг өрхийн эмнэлгүүдэд шилжүүлэн олгох тогтолцоог бий болгоно.	14. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн засаг захиргааны болон эрүүл мэндийн салбарын хосолмол удирдлагыг бэхжүүлж, гурвалсан гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллах 15. Холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран түр оршин суугчид болон 180 хоногоос дээш хугацаагаар оршин суудаг иргэдийн зардлыг өрхийн эмнэлгүүдэд шилжүүлэн олгох тогтолцоог бий болгох асуудлыг судлан шийдвэрлэх	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нартай БОЭТөв, ЭМГазар, сумын Засаг даргатай нартай гурвалсан гэрээ байгуулж үр дүнг хагас бүтэн жилээр дүгнэж, зөвлөн туслах чиглэл өгч ажилласан.2018 оны 05 дугаар сард аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран Уян сэтгэл өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээг хамтран үзүүлж, ажил сайжруулах үүрэг чиглэлийг өгсний дагуу гүйцэтгэлийн үнэлгээг хийсэн. 2018 онд түр оршин суугч, эрүүл мэндийн үйлчилгээ авдаг 0-5 насны хүүхэд 356, 6-15 насны хүүхэд 633, 16-49 насны эмэгтэйчүүд 1207, 60-аас дээш настай өндөр настан 376, бусад насны эрүүл мэндийн үйлчилгээ авсан иргэн 799 нийт 3371 иргэн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг авч байгаа боловч тус иргэдийн эрүүл мэндийн зардал иргэдийн үндсэн харъяалалтай сумандаа байгаа тул тус үйлчилгээ авч байгаа ӨЭМТөвүүдэд санхүүжилт олгох хүсэлтийг аймгийн Эрүүл мэндийн газарт тавьсан. Эдгээр иргэдийн зардлыг олгуулах талаар аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга нарт хүсэлт шийдвэрлэгдээгүй болно.	100	70
				Үнэлэх боломжгүй	

6.	1.1.6 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг магадлан итгэмжлэлд оруулж, өдрийн болон гэрийн эмчилгээ, асаргаа сувилгаа, сэргээн засах, хөнгөвчлөх үйлчилгээний төрлүүдийг бий болгож, эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх боломжийг бүрдүүлнэ.	16. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг магадлан итгэмжлэлд оруулах нөхцлийг бүрдүүлж, хамруулах	“Түшиг дөлгөөн”, “Нарны дөш” Өрхийн эрүүл мэндийн төвүүд магадлан итгэмжлэлд орох бэлтгэлийг хангаж, хүсэлтийг холбогдох газарт уламжилсан.		
		17. Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд өдрийн болон гэрийн эмчилгээ, асаргаа сувилгаа, сэргээн засах, хөнгөвчлөх үйлчилгээний төрлүүдийг бий болгож, эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх	ӨЭМТөвүүдэд кварцын гэрэл, автоклав, ургийн зүрхний цохилт тоологч, УВЧ аппарат, искра, зүрхний цахилгаан бичлэгийн аппаратыг өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж өдрийн эмчилгээ үйлчилгээ үзүүлэх, хөнгөвчлөх үйлчилгээг гэрээр үзүүлж гэрийн идэвхтэй хяналтыг давхардсан тоогоор 9212 иргэнд үзүүллээ.	70	70
7.	1.1.7 Хүүхдийн эмнэлэг шинээр барих, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг эх барих-эмэгтэйчүүд, хүүхдийн мэргэжлийн эмчтэй болгох асуудлыг судалж, шийдвэрлүүлэх замаар нөхөн	18. 90 ортой хүүхдийн эмнэлэг шинээр барих асуудлыг судалж, шийдвэрлүүлэх	Үнэлэх боломжгүй.	-	-
		19. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг эх барих-эмэгтэйчүүд, хүүхдийн мэргэжлийн эмчтэй болох асуудлыг судалж, шийдвэрлүүлэх	Үнэлэх боломжгүй.	-	-

	үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжинд ахиц гарган жирэмсэний эрт үеийн хяналтыг 90 хувьд хүргэж, эх, хүүхдийн эндэгдлийг бууруулна	20. Төрөх насны эмэгтэйчүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулж, жирэмсний эрт үеийн хяналтын хувийг нэмэгдүүлж, эх хүүхдийн эндэгдлийг бууруулах	Сумын дүнгээр нөхөн үржихүйн 20-35 насны 4199 эмэгтэйгээс эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 3149 эмэгтэй буюу 75 хувийг хамрууллаа. 2018 онд шинээр 662 жирэмсэн эмэгтэйг хяналтанд авсан нь урьд оны мөн үеэс жирэмслэлт 9,4 хувиар нэмэгдсэн. Эрт үеийн хяналтын хувь 85 хувьтай байгаа бөгөөд өрхийн эрүүл мэндийн төв жирэмсний хугацаанд 6-8 удаа, нарийн мэргэжлийн эмчид 4 ба түүнээс дээш удаа хянуулж, 2-3 удаа шинжигээнд хамрагдаж байна. 2018 оны 11 сарын дүнгээр 583 эх төрсөн, нярайн эндэгдэл 7, 0-5 насны эх хүүхдийн эндэгдэл 12 гарсан.	40	70
8.	1.1.8 Хүн амын дунд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийг эмчийн жороор олгох соёлыг бүрдүүлж, эмийн сангуудын үйл ажиллагаанд тавих хяналтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	21. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх мэдээлэл сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах	Иргэдэд эмийн зохистой хэрэглээ, эмийг эмчийн жороор авч хэрэглэж хэвших чиглэлээр мэдээлэл сургалт сурталчилгааны ажлын хүрээнд “Мон ургамал”, Монгол эм”, “Аура” “Эм гоо” “Монос” зэрэг эмийн сангуудтай өрхийн эрүүл мэндийн төвүүд жил бүр хамтран үйл ажиллагаа зохион байгуулж, давхардсан тоогоор 14729 иргэнд мэдээлэл хийж, гарын авлага, материал тараан иргэдийг мэдээллээр ханган ажиллалаа. Үүнд: ӨЭМТөвүүдийн НЭМАжилтан эмийн жорын маягтын хэрэглээнд судалгаа хийж, сард хэрэглэгдэх жорын маягтын тооцоог гарган хагас жилийн хэрэгцээгээр татан авч хэрэглэж бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Ингэснээр эмч мэргэжилтнүүд эрүүл мэндийн даатгалтай болон даатгалд ордоггүй бүх эмийг үйлчлүүлэгчдэд жороор бичин өгч зөвлөх боломж нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. “Антибиотик эмийг зөвхөн эмчийн жороор авч хэвшье” сэдэвт аяны хүрээнд гаргасан уриалга, ханын сонинг мэдээллийн самбарт байршуулан иргэдэд мэдээлэл сургалт сурталчилгаа хийж, дэлгэцийн шторкоор мэдээлэл түгээсэн. Мөн бага насны хүүхэдтэй эцэг эхчүүд болон жирэмсэн эхчүүдэд 41 удаагийн сургалт хийж нийт 1431 эхийг хамрууллаа. Эмийн зохистой хэрэглээ, антибиотик эмийг зөв хэрэглэх тухай гарын авлагыг олшруулан үйлчлүүлэгч иргэдэд тараасан, фэйсбүүк хуудсанд шторк байрлуулан мэдээлэл түгээсэн байна.	100	70
		22. Эмийн сангуудын үйл ажиллагаа болон антибиотикийг эмчийн жороор олгоход тавих хяналтыг мэргэжлийн	2018 оны 05 дугаар сард эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй үнээр үйлчилдэг эмийн сангийн удирдлагуудтай ажил хэргийн уулзалт зохион байгуулсан. Арвайхээр сумын хэмжээнд нийт 12 эмийн сан тус үйлчилгээг хүргэн ажиллаж, нийт дүнгээр жилдээ 280 сая төгрөгийн хөнгөлөлтийг иргэдэд хүргэн ажиллаж байна.	100	70



		байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх	Жор бичилтийн хувьд цахим хэлбэрт 100 хувь шилжсэн. Сумын дүнгээр амбулаториор үйлчлүүлсэн 14729 иргэнд Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар жор бичиж, эмийн сангууд жороор олгох ажлыг хэвшүүлээд байна.		
9.	1.1.9 Боловсролын байгууллагуудын эмчийн ажлын чиг үүргийг оновчтой тодорхойлж, сурагч, эцэг, эхчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг идэвхижүүлж, шүд цоорох өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажилд ахиц гаргана.	23. ЕБ-ын сургууль, цэцэрлэгийн эмчийн ажлын байрны нийтлэг тодорхойлолтыг боловсруулан мөрдүүлэх	ЕБСургуулиуд, СӨББайгууллагын цэцэрлэг хариуцсан эмч нарын ажлын байрны тодорхойлолтыг 2017 онд шинэчлэн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нар баталгаажуулан үр дүнгийн гэрээг жил бүр шинэчлэн байгуулж байна. 2018 онд Мэргэд лаборатори сургууль, Цэцэрлэг бага сургуулийн цогцолбор сургууль, шинэ 10, 11, 12 дугаар цэцэрлэгүүд нийт дүнгээр сургууль, цэцэрлэгийн эмчийн орон тоог шинээр 5-ыг нэмэгдүүлэн ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан хамтран мөрдүүлэн ажилласны үр дүнд Аймгийн БСУГазар, БОЭТөвөөс зохион байгуулсан ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эмч нарын “Ур чадвар”-ын уралдаанд сургууль, цэцэрлэгийн эмч нар оролцсоноос ЕБ-ын 1 дүгээр сургуулийн эмч н.Цогзолмаа Тэргүүн байр, 9 дүгээр цэцэрлэг эмч Л.Сэрчмаа 2 дугаар байр, 4 дүгээр сургуулийн эмч Д.Нармандах тусгай байр эзэллээ. Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль, Мэргэд лаборатори сургуулийн эмч нар мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж, ур чадвараа нэмэгдүүлсэн. Цэцэрлэгийн эмч нарыг нийт 1.380.000 төгрөгийн багаж хэрэгслээр хангасан. 1 дүгээр сургуулийн эмчийг жин өндөр хэмжигч, пульсоксиметр, духны гэрэл, халуун хэмжигч багаж хэрэгслээр, Мэргэд лаборатори сургууль “Эм гоо” эмийн санд сургуулийн эмчийн ажлын хэрэгцээний багаж хэрэгслээр хангах хүсэлт илгээсний үр дүнд тус эмийн сангаас нийт 200.000 төгрөгийн багаж хэрэгслээр хангасан.	100	100
		24. Эцэг, эхчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааг идэвхижүүлж, бага насны хүүхдийн шүд цоорох өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх ажилд	2017-2018 оны хичээлийн жилд цэцэрлэгийн хүүхдийн амны хөндийн эрүүл мэнд буюу шүдний үзлэгт нийт 2205 хүүхэд хамрагдаж, шүд эрүүл хүүхэд 935 буюу 42.4 хувь, шүд цооролттой хүүхэд нийт 985 буюу 44.6 хувь нь шүд цооролттой гарсан. Гантиг, Эльда-Дент хувийн хэвшлийн эмнэлгүүдтэй хамтран 50 хувийн шүдний үнэ болох хөнгөлөлтийн гэрээ байгуулан эрүүлжүүлэх болон урьдчилан сэргийлэх ажил хийгдэж үүнээс спириад \түрхлэг\, ломбо тавьж эмчлэгдсэн нийт 485 хүүхэд буюу 21.9 хувь басан бол 2018-2019 оны хичээлийн жилийн 2 дугаар улирлын дүнгээр сургуулийн өмнөх	100	70

		ахиц гаргаж, үр дүнг тооцох	боловсролын байгууллагууд амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдвал зохих 3050 хүүхдээс 1970 буюу 65 хувийг хамруулж дүгнэлт хийхэд 1056 буюу 53.8 хувь нь шүдний өвчлөлтэй бөгөөд урьд онтой харьцуулахад 9.2 хувиар өвчлөл нэмэгдсэн. Цэцэрлэгийн захиргаа, эцэг эхчүүдтэй хамтран сүүлийн 3 жил тасралтгүй БОЭТөв, Эльдадент, Гантиг, Цахиур шүдний эмнэлэгтэй хамтран хүүхдийн шүдний өвчлөлийг эрт илрүүлэн, эмчлэн эрүүлжүүлэх ажлуудыг зохион байгуулж байна. ЕБ-ын сургуулийн сурагчдын “Үдийн цай” хөтөлбөрийн бүтээгдэхүүний 60-аас доошгүй хувьд сүү, сүүн бүтээгдэхүүнийг нийлүүлж, хүүхдийн эрүүл мэндийг дэмжсэн бүтээгдэхүүнээр хангаж байна.		
		25. ЕБ-ын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдад бэлгийн боловсрол олгох, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг жил бүр зохион байгуулж, үр дүнг тооцох	2018-2019 оны хичээлийн жилд охидын урьдчилан сэргийлэх үзлэгт ЕБСургуулийн 9-12 дугаар ангийн эмэгтэй сурагчид болон МСҮТөвийн нийт 954 охид хамрагдахаас 934 буюу 98 хувьтай хамруулж, сургалт мэдээллийн ажлыг өсвөр насны охидын нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр хийлээ. Ахлах дунд ангийн 1895 хөвгүүдэд бэлгийн боловсрол, хөвгүүдийн ариун цэвэр, эрүүл ахуйн чиглэлээр сургалт мэдээллийг ЭМГазар, Ирээдүйн босго төв хамтран зохион байгууллаа. 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн Эрүүл мэндийн боловсрол олгох хичээлийн хөтөлбөр хэрэгжиж байна.	100	70
<b>Салбарын дундаж үнэлгээ</b>				<b>81.4</b>	<b>71.4</b>
<b>1.2 Боловсролын үйлчилгээ</b>					
10.	1.2.1 ЕБСургууль, СӨББайгууллагын анги дүүргэлтийн коэффициентийг бууруулах зорилгоор сургууль, цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөх засварлах замаар ЕБСургуулийн суудлын тоог 928-аар	26. Мэргэд лаборатори сургуулийн шинэ хичээлийн байрыг ашиглалтанд оруулах	Мэргэд лаборатори сургуулийн шинэ хичээлийн байрыг улсын төсвийн нийт 3,8 сая төгрөгний хөрөнгө оруулалттайгаар “Аж констракшн” ХХКомпани гүйцэтгэгчээр ажиллаж, барилгын ажлын явц 90 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд 2018-2019 оны хичээлийн жилийн 3 дугаар улиралд ашиглалтад орох бэлтгэл хангагдсан.	100	100
		27. 150-200 хүүхдийн хүчин чадалтай 2 цэцэрлэгийн барилгыг барьж, ашиглалтанд оруулах	2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалт 831 сая төгрөгөөр тус сумын 5 дугаар багт 150 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгын ажлыг “СИЗУ” ХХКомпани барилгын ажлыг хийж гүйцэтгэн 10 дугаар цэцэрлэгийг үүсгэн байгуулж, ашиглалтанд оруулсан. 2018 онд 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг “Ган Нэгдэл” ХХКомпани 814 сая	100	100

	нэмэгдүүлж, хамран сургалтыг 100 хувьд, СӨББайгууллагын суудлыг тоог 500-аар нэмэгдүүлж, СӨБ-ын хамран сургалтыг 95 хувьд хүргэнэ.		төгрөгийн төсөвт өртөгтэйгээр хийж гүйцэтгэн ашиглалтад орууллаа. Тус 12 дугаар цэцэрлэгт 1, 9, 12 дугаар багийн 2-5 насны хүүхдүүдийг хүлээн авч сургалт хүмүүжлийн ажлыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг бүрэн хангаад байна.		
		28. ЕБ-ын 4 дүгээр сургуульд номын сан, урлаг заал бүхий өргөтгөл шинээр барих	4-р сургуулийн барилгын гадна засварыг улсын төсвийн 60 сая төгрөгийн санхүүжилтээр "Чусан" ХХКомпани гүйцэтгэлээ.	70	40
11.	1.2.2 ЕБ-ын 2 дугаар сургуулийн хичээлийн байр, Цэцэрлэг, бага сургуулийн цогцолборын спорт заал, 1, 5, 6, 7 дугаар цэцэрлэгүүдэд их засвар хийж, төрөлжсөн кабинет, биеийн тамирын зал, тоглоомын талбайн орчин нөхцлийг сайжруулан, "Хүүхдэд ээлтэй сургууль", "Дотуур байр" хөтөлбөрийг хэрэгжүүлэн, дотуур байрны хүчин чадлыг 300-аар нэмэгдүүлнэ.	29. ЕБ-ын 1 дүгээр сургуульд спорт заалны барилга шинээр барих	Улсын төсвийн 1 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтаар гадна талдаа сагсан бөмбөг, хөл бөмбөгийн ногоон талбай, тоглоомын талбайтай стандартын спорт зал баригдаж эхэлсэн бөгөөд 2018-2019 оны хичээлийн жилд багтаж бүрэн ашиглалтанд орно.	100	100
		30. ЕБ-ын 2 дугаар сургуулийн хичээлийн байр, Цэцэрлэг, бага сургуулийн цогцолбор сургуулийн спорт зааланд их засвар хийх	Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2 дугаар байр буюу бага ангийн сурагчдын хичээлийн байранд улсын төсвийн 107,5 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар их засварыг "Девсофт" ХХК, Цэцэрлэг бага сургуулийн цогцолборын спорт заалны их засварыг улсын төсвийн 34 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар хийж, ашиглалтад өгснөөр сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл бүрдсэн.	100	100
		31. Хүүхдийн 1, 5, 6, 7 дугаар цэцэрлэгүүдэд их засвар хийх	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1 дүгээр цэцэрлэгийн барилгын их засварт 30 сая төгрөгийн ажлыг "Вертекс талст" ХХКомпани, 5 дугаар цэцэрлэгт улсын төсвийн 50 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Ганцаг" ХХКомпани их засвар, 6 цэцэрлэг 44 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр "ӨВ-ОД барилга" ХХК, 7 дугаар цэцэрлэгийн барилгад 83 сая төгрөгийн өртөгтэй их засварыг "Сод-Ээл" ХХКомпани хийж ашиглалтад тус тус өгч үйлчилгээний орчин нөхцөл сайжирсан.	100	100
		32. 300 хүүхдийн хүчин чадалтай дотуур байрны барилга шинээр барьж, ашиглалтад оруулах	Дээд шатны байгууллага албан тушаалтанд дотуур байртай болох хүсэлтийг уламжилсан боловч аймгийн төвийн сургууль дотуур байртай байх шаардлага байхгүй талаар хариу мэдэгдсэн.	-	-
		33. Сургууль, цэцэрлэгүүдийн цахилгаан, дулаан хангамж, цэвэр, бохир	2017-2018 оны хичээлийн жилд ЕБоловсролын 2 дугаар сургуулийн хичээлийн байранд нийт 17 сая төгрөгийн /хичээлийн төв байр болон өргөтгөлийн дээвэр, төв байрны тамбар, сантехник/ урсгал засвар хийгдсэн. Улсын төсвийн хөрөнгө	100	100

		усны дэд бүтцийг үе шаттайгаар шинэчлэх ажлыг шийдвэрлүүлэх	<p>оруулалтаар 1 дүгээр цэцэрлэгийн барилгын их засварт 30 сая төгрөгийн ажлыг “Вертекс талст” ХХК гүйцэтгэснээр үйлчилгээний орчин нөхцөл сайжирсан. 2016-2017 оны хичээлийн жилд ЕБ-ын 1 дүгээр сургууль орон нутгийн 60 сая, ДЗОУБайгууллагын 90 сая нийт 150 сая, ЕБ-ын 4 дүгээр сургууль орон нутгийн 12.5 сая, ДЗОУБайгууллагын 97.5 сая нийт 110 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжийг шинээр ашиглалтад оруулсан.</p> <p>2017-2018 оны хичээлийн жилд Мэргэд лаборатори сургууль ДЗОУБайгууллагын 36 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар стандартын шаардлага хангасан эрүүл ахуй, ариун цэврийн байгууламжтай боллоо. ДЗОУБайгууллага СӨБ-ын 7 гэр цэцэрлэгт 6.9 сая төгрөгийн био суултуур өгч, 5, 8 дугаар цэцэрлэгийн стандартад нийцсэн ариун цэврийн өрөөнд 616.4 мянган төгрөгийн сантехникийн засвар, 6 дугаар цэцэрлэгийн Б байранд 15 мкв бохирын шугамыг 1.6 сая төгрөгөөр шинэчлэн, нийт 2.2 сая төгрөгийн сантехникийн ажил хийгдлээ.</p> <p>Мөн 1 дүгээр сургууль 460.000 төгрөгийн урсгал засвар /цонхны дулаалга, сантехник/, 4 дүгээр сургууль 563.700 төгрөгийн засвар /цонхны дулаалга, пар/, Мэргэд лаборатори сургууль 7 сая төгрөгийн урсгал засвар /сургуулийн дээвэр, зааланд бүтэн будаг хийсэн, цонхны дулаалга, сантехник/, ЦБСЦогцолбор 1.082.000 төгрөгийн засвар / сантехник, цонх, хаалганы дулаалга, парны сет нэмсэн/ тус тус хийгдсэн</p>		
12.	1.2.3 Хувийн хэвшлийн цэцэрлэгийн үйл ажиллагааг дэмжиж, цэцэрлэгүүдэд 24 цагийн үйл ажиллагаатай бүлэг бий болгох ажлыг эхлүүлэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч хөгжих нөхцлийг сайжруулах замаар сувиллын	34. Зарим цэцэрлэгийг 24 цагийн үйл ажиллагаатай бүлэгтэй бий болгох асуудлыг шийдвэрлүүлэх	Цэцэрлэгт 24 цагийн үйл ажиллагаатай бүлэг бий болгох чиглэлээр иргэдээс ирүүлсэн хүсэлт, санал гараагүй байгаа тул эрэлт хэрэгцээ, байхгүй байна.	-	-
		35. Зарим цэцэрлэгүүдэд зуны цэцэрлэгийн бүлэг ажиллуулах	2016-2017 оны хичээлийн жилд 7 дугаар цэцэрлэг нь 6 дугаар сард нэг сарын хугацаатай зуны 7 бүлэгт 2-5 насны нийт 243, 2017-2018 оны хичээлийн жилд зуны цэцэрлэгийг 1 дүгээр цэцэрлэгийг түшиглэн 5 бүлэгт нийт 130 хүүхдийг хамрууллаа.	100	100
		36. Хувийн хэвшлийн цэцэрлэгийн үйл ажиллагаа, хүүхэд харах үйлчилгээг	2018-2019 оны "ЛБ", "Жаргалант", "Оюуны-Ундараа" хувийн хэвшлийн нийт 3 цэцэрлэгт 1-5 насны 9 хүүхэд хамрагдаж эрүүл аюулгүй орчинд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байна. Хувийн хэвшлийн цэцэрлэгүүд 2017-2018 оны хичээлийн жилд	100	100

	болон тусгай бүлгийн тоог нэмэгдүүлнэ.	дэмжин ажиллах	2.8 сая төгрөгийн урсгал засварыг өөрийн хөрөнгөөр хийж сургалтын орчинг сайжруулав. Улсын төсвөөс 2018 онд 62.1 сая төгрөг, санхүүгийн дэмжлэгийг олгосон. “Хүүхэд харах үйлчилгээний тухай” хуулийн хүрээнд сумын хэмжээнд үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг 2018 онд 24 хүүхэд харагч, 112 хүүхдэд үйлчилгээний зардалд улсын төсвөөс 138.416.сая төгрөг олгосон.		
		37. СӨБоловсролын байгууллагын сувиллын болон тусгай бүлгийн тоог нэмэгдүүлэх	Тус суманд тусгай хэрэгцээт 11 дүгээр цэцэрлэг байгуулагдан нийт 3 бүлэг, 34 хүүхэд хамрагдаж, асаргаа сувилгааны үйлчилгээ болон хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа тогтмолжсон.	100	100
13.	1.2.4 “Оюунлаг Өвөрхангай”, “Шатар” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжилтийн хүрээнд суралцагчдыг сэтгэн бодох, техникийн сэтгэлгээг хөгжүүлэх шинэ дэвшилтэт техник технологиор хангах ажлыг эрчимжүүлнэ.	38. “Оюунлаг Өвөрхангай” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Үнэлэх боломжгүй.	-	-
		39. Шатрын спортыг хөгжүүлэх чиглэлээр олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, “Шатар” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	“Шатар” дэд хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсролын 5 сургууль, 10 цэцэрлэг нийт 15 байгууллага үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд “Шатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлуудыг тусган ажиллаж байна. 2018 оны 1 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд аймгийн шатрын аварга шалгаруулах тэмцээн болж, 18 сургууль, 4 цэцэрлэгийн 271 өсвөрийн шатарчид оролцлоо. Шатарчид 6 насанд 12 ангилалаар өрсөлдсөнөөс багийн дүнгээр Даржаа ахлагчтай Мэргэд сургууль 4 алт, 3 хүрэл медаль хүртэж тэргүүн байр эзэлсэн. Хөтөлбөрийн хүрээнд “Цодгор хүү” Улсын аварга шалгаруулах тэмцээн, “Унагалдай-2” аймгийн аварга шалгаруулах тэмцээн, Их мастер Б.Гүндоваагийн нэрэмжит “Нээлттэй тэмцээн”, Ж.Жанцандоржийн нэрэмжит “Аймгийн аварга шалгаруулах” тэмцээн, Багийн аварга шалгаруулах тэмцээн, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцангийн нэрэмжит “Хангайн болон говийн бүсийн өсвөрийн шатарчдын тэмцээн”, Хүүхдийн спортын 5 дугаар их наадмын шатрын тэмцээн зэрэг тэмцээнүүдэд сумын иргэд, хүүхэд залуучуудын төлөөлөл, баг тамирчид амжилттай оролцсон. 2018 онд зохион байгуулагдсан дээрх тэмцээнүүдэд нийт 400 гаруй хүн хамрагдсан.	100	70

14.	1.2.5 Багшийн ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх, багшлах боловсон хүчний нийгмийн хамгааллыг сайжруулах, тэдний эрүүл мэнд, хөдөлмөрийн үнэлэмж, орон байрны нөхцлийг сайжруулан багш нарын арга зүйн хөгжлийг дэмжиж, тэргүүн туршлага, ур чадвараа түгээн дэлгэрүүлэх боломжийг нэмэгдүүлж, “Багшийн хөгжил” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	40. Сургууль, цэцэрлэг бүр сумын “Угтах үдэх үйлчилгээний нийтлэг журам”-ыг хэрэгжүүлэх замаар угтах, үдэх үйлчилгээний соёлыг бий болгож, ёс зүйн хувийн хэргийг хөтлөх ажлыг хэвшүүлэх	Сумын “Угтах, үдэх үйлчилгээний нийтлэг журам”-ын дагуу угтах, үдэх үйлчилгээний соёлыг бий болгон сургууль, цэцэрлэг, өрхийн эрүүл мэндийн төв хэрэгжүүлж хэвшсэн. Сургуулийн орчинд сурагчдыг өглөө ирэхэд нь угтаж аван мэндлэх, үдэх, эцэг эх, иргэдийг угтан авч, сургуулийн орчинд соёлтой үйлчлэх зорилгоор ахлах ангийн сурагчид “Хөтөч сурагч”-аар ажиллан угтах үдэх үйлчилгээг үзүүлж байна. Сургуулийн жижүүрүүдэд тогтмол харилцаа хандлага, хүүхэдтэй хэрхэн харилцах талаар яриа таниулгыг хийж, хувцаслалтад нь анхаарч, энгэрийн тэмдэгтэй болгосон. СӨББайгууллагуудад бие даасан жижүүртэй 3 цэцэрлэг байдаг ба бусад 8 цэцэрлэг нь жижүүр багшийг ажиллуулж, орой угтах үдэх үйл ажиллагааг зохион байгуулж, иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, сэтгэл ханамжийн судалгааны тайланг улирал бүр Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн Угтах үйлчилгээний ажилтанд хүргүүлж хэвшлээ.	100	100
		41. Шинэ зуун бүсийн төвөөс бүсийн хэмжээнд жил бүр нэрэмжит болон бусад тэмцээн уралдаан, олимпиадыг зохион байгуулах, “Багшийн хөгжил” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Шинэ зуун бүсийн төвөөс “Тоо бодож, оюунаа хөгжүүлье” “Эх хэл-эрдмийн түлхүүр” “Гадаад хэл- хөгжлийн түлхүүр” “Эх түүхээ эрхэмлэн дээдэлье” зэрэг олимпиадыг бүсийн хэмжээнд зохион байгуулж 1 дүгээр байранд шалгарсан ангийг аймгийн олимпиадад оролцох батламж олголоо. 2017-2018 оны хичээлийн жилд сумын дүнгээр 82 багш, ажилчдыг гадаадад мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах, туршлага судлах, аялах зэргээр явуулсан. 2018-2019 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын 5 сургуульд 353 багш ажиллаж байгаагийн 95 буюу 26,9 хувь нь “Заах аргач”, 67 буюу 18,9 хувь нь “Тэргүүлэх”, 5 буюу 1,5 хувь “Зөвлөх” нийт багшийн 47.3 хувь нь мэргэжлийн зэрэгтэй багш нар боловсролын үйлчилгээг хүргэж байна. Боловсролын байгууллагад мэргэжлийн багшийн хангалт 100 хувь, ЕБСургуулийн нийт багшийн 284 буюу 80.4 хувь эмэгтэй, 69 буюу 19,6 хувь эрэгтэй багш эзэлж байна. Сургууль, цэцэрлэгүүдийн “Багшийн ёс зүйн зөвлөл”-ийн үйл ажиллагаа тогтмолжиж, ЕБ-ын сургууль, цэцэрлэг бүр багш, ажиллагсдын харилцаа, хандлага, ёс зүй, хариуцлагыг сайжруулах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, багш, албан хаагч бүрд ёс зүйн хувийн хэргийг хөтөлж хэвшсэн. ЕБ-ийн сургуулийн нийт 353 багш, СӨБ-ын 109	100	100

			багшид ёс зүйн хувийн хэргийг хөтөлж байна. ЕБ-ын 1 дүгээр сургуулийг түшиглэсэн “Шинэ зуун” бүсийн төвийн кабинетын үйл ажиллагаа тогтмолжсон.		
		42. Шинэ зуун бүсийн хэмжээнд мэргэжлийн багш нарыг солилцоогоор ажиллуулах	Багш нарын мэргэжлийн ур чадварыг сайжруулах харилцан туршлага судлахад 6 цэцэрлэгийн нийт 62 арга зүйч, багш, туслах багш Улаанбаатар хот, Баянхонгор аймаг, Нарийнтээл сум, Жаргалант баг, Уянга сумын цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцан, Улсын тэргүүний 2, 4 дүгээр цэцэрлэгийн багш нарын тэргүүн туршлагыг 21 залуу багш нарт түгээн дэлгэрүүлэн үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан. Бага, дунд, ахлах ангийн цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн ажлын үр дүнгээр “Сайн хичээл” цахим хичээлийн санд 36 багш үйл ажиллагааг тэргүүн туршлагаар түгээн дэлгэрүүлж байна.	100	100
		43. Багш нарын нийгмийн баталгааг дэмжих чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Боловсролын байгууллагын багш нарт хуулийн дагуу олгогдох 5 жилийн тэтгэмжинд 190 багшид 653.1 сая төгрөгийг олгосон байна. “Өвөрхангай аймгийн ерөнхий боловсролын сургуулийн багш нарын амжилтыг үнэлэх урамшуулал олгох журам”-ын дагуу шалгуур үзүүлэлтийг хангасан 5 багш нийт 10 сая төгрөгийн мөнгөн урамшууллаар шагнагдсан.	100	100
15.	1.2.6 Боловсролын байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах орчин нөхцөл, дэд бүтцийг стандартын түвшинд бүрдүүлэн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалах” аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.	44. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалах” аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Сумын ерөнхий боловсролын сургуулуудад 2017-2018, 2018-2019 оны хичээлийн жилд хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 171 сурагч, СӨББайгууллагын энгийн цэцэрлэгт 7, 11 дүгээр тусгай цэцэрлэгт 34 хүүхэд, тус тус хамрагдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалах” аймгийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн “Адил боломж” аймгийн дэд хөтөлбөрийн 3 зорилтын хүрээнд хэрэгжилтийн явц 90 хувьтай байна.	100	70
		45. Сургууль, цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах орчин нөхцөл, дэд бүтцийг сайжруулах	ЕБоловсролын сургуулиуд, СӨББайгууллагууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бариул, чиглүүлэгч зэргийг байршуулсан. СӨББайгууллагын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд 450 мянган төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоомжуулалт хийгдсэн. Улсын төсвийн 19 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан 40 хүүхдийн хүчин чадалтай 11 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн ажлыг 81,8 сая төгрөгний санхүүжилтээр ашиглалтанд орсон. 2018 оноос 3 жилийн хугацаанд Японы хүүхэд ивээх сангийн “Хүүхдийг боловсролд	100	70

			тэгш хамруулах нөхцөлийг дэмжих нь төсөл"-ийг хэрэгжүүлэхээр ерөнхий боловсролын 2 дугаар сургууль, сумын Насан туршийн боловсролын нэгж сонгогдон хэрэгжилтийн үйл ажиллагааны мэдээлэл танилцуулага, хийгдэж, санамж бичгийн гэрээ байгууллаа.		
16.	1.2.7 Иргэдийг насан туршийн боловсрол эзэмших, амьдрах, аж төрөх ухаанд суралцуулах чиглэлээр бие даасан төвийн үйл ажиллагааг дэмжиж, сургуулиас гадуурх сургалтын байгууллагаар дамжуулан хүүхэд, залуучууд насанд хүрэгчдийг тохиромжтой хэлбэрээр суралцах хүрээг өргөжүүлэх, ном сурах бичгээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	46. Сумын Насан туршийн боловсролын нэгжийн сургалт үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтанд шаардлагатай ном сурах бичгийг захиалан авч ашиглах	Сумын НТБ-ын нэгжийн 2018 оны сургалт мэдээллийн ажлын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан 6 чиглэлийн 11 төрлийн 63 сургалт мэдээллийн сумын ЗДТГазрын сургалтын баг, төрийн бус байгууллагууд, Дэлхийн зөн ОУБайгууллагатай хамтран зохион байгуулж, давхардсан тоогоор 7320 гаруй иргэдийг хамруулан төлөвлөгөөний биелэлт 95 хувьтай хэрэгжлээ. Аймгийн Боловсрол урлагийн газрын дүйцсэн хөтөлбөрийн бага боловсролын сургалтанд ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн сурах бичиг 60 ширхэгийг, Японы хүүхэд ивээх сангийн төслийн хүрээнд 30 хүүхдэд сургалтын гарын авлага, хэрэглэгдэхүүн захиалан авч суралцагч, эцэг эхийн гарын авлагатай болсон.	100	100
		47. Иргэдийг тусгайлсан хөтөлбөрийн дагуу тохиромжтой хэлбэрээр иргэний боловсрол олгох ажлыг зохион байгуулах	Аймгийн НТБТөвийн "Тогтвортой хөгжлийн боловсрол"-ын үндэсний сургагч багш нартай хамтран тогтвортой хөгжлийн боловсролын хүрээнд нэгдсэн ойлголт мэдээлэл олгох, амьдралын хэв маяг, ногоон хөгжил, ногоон ирээдүй гэсэн чиглэлийн сургалтанд багийн ажлын албаны албан хаагчид, ЕБСургуулийн Нийгмийн ажилтан, ӨЭМТөвийн эмч, ХӨУБ-ын гишүүд, зорилтот өрхийн гишүүд гэсэн бүлгүүдэд 8 удаагийн сургалт хичээлээр 380 гаруй хүнийг хамруулан, байгаль орчинтой зүй зохистой харьцахад амьдралын зарим хэвшлээ өөрчлөх, байгалиа хайрлан хамгаалах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй хөгжлийн тухай мэдлэгтэй болж амьдралын зохисгүй дадал хэвшлээ өөрчлөх, ногоон хөгжилд оруулах хувь хүний болон айл өрх бүрийн хувь нэмрийг нэмэгдүүлэх, байгуулага бүр ногоон орчин ногоон хөгжилтийг дэмжсэн ажлыг зохион байгуулах санаачлага өрнүүлж ажиллалаа.	100	70



		48. Мэдээллийн технологийн дэвшилд тулгуурлан залуучуудыг насан туршдаа суралцах боломжийг нэмэгдүүлэх	Мэдээллийн цахим хэрэглээний зохистой хэрэглээ, эдийн засгийн анхан шатны мэдлэг олгох, бичиг үсгийн чадвар дээшлүүлэх, компьютер хэрэглээний праграмм дээр ажиллаж сургах, амьдрах арга ухаан сургах, өөрөө өөртөө ажлын байр бий болгох, юмхнаар юм хийх, хоёрдогч түүхий эдийг ашиглан хэрэглээ болгох зэрэг сургалтын хөтөлбөрийг төрийн болон төрийн бус байгууллага, сургалтын байгууллагатай хамтран 16 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1820 иргэн хамрагдсан байна.	100	70
<b>Салбарын дундаж үнэлгээ</b>				<b>98.5</b>	<b>88.0</b>
<b>1.3 Соёл, урлаг, спорт, нийтийн биеийн тамир</b>					
17.	1.3.1 Соёлын биет болон биет бус өвийг сурталчлах, түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулахадтөр, иргэн, олон нийтийн хяналт оролцоог нэмэгдүүлнэ.	49. Сумын нутаг дэвсгэрт орших түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг эд хөрөнгийн эрхийн болон газрын кадастрын улсын бүртгэлд бүртгүүлэх	Сумын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй.	-	-
		50. Сумын хамгаалалттай түүх соёлын үл хөдлөх дурсгалуудын жагсаалт, хилийн зааг, хамгаалалтын дэглэмийг аймгийн ИТХурлаар батлуулах	Түүх соёлын үл хөдлөх дурсгалын хамгаалалтыг батлах, хилийн зааг, хамгаалалтын дэглэм тогтоох тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 08/07 тогтоолоор түүх соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийг тодотгосныг БСШУСайдын 2010 оны 541 дугаар тушаалаар батлагдсан бүртгэлийн маягт, зааврын дагуу сумын зэрэглэлтэй түүх соёлын дурсгалыг 2018 онд тодотгон 14-ийг бүртгэл мэдээллийн санд орууллаа.	100	100
		51. Түүх соёлын үл хөдлөх хөшөө дурсгалыг сэргээн засварлах, хамгаалах ажлыг үе шаттайгаар хийх	Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн хиргисүүрийг 3,6 сая төгрөгөөр хайсжуулах ажлыг “Эргэн дэнж ХХК” хийж гүйцэтгэлээ. Буга согоотын хадны сүг зургийг зөөвөрлөх зөвшөөрлийг Боловсрол соёл, шинжлэх ухааны яамны сайдын 2018 оны а/599 дүгээр тушаалаар авч, сумын Засаг даргын 2018 оны а/292 дугаар захирамжаар 11 дүгээр сард улсын Соёлын өвийн төв, аймгийн Музейтэй хамтран зөөвөрлөх ажлыг зохион байгуулж, аймгийн Музейн хамгаалалтанд өглөө. Тус ажлын зардалд нийт 763700 төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцууллаа.	100	100

		52. Олон нийтэд сумын хамгаалалттай түүх соёлын үл хөдлөх дурсгалууд, соёлын биет болон биет бус өвийг сурталчлах, таниулах ажлыг зохион байгуулах	Сумын вэб сайтад болон Иргэний танхимд ТСДЗүйлсийн мэдээллийн буланг тус тус байршуулж, олон нийтэд сурталчилж байна. Биет бус соёлын хүрээнд 6 төрөлд 29 биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэлийг хөтөлж, баримтжуулсан. Багуудад өөрсдийн харъяа нутаг дэвсгэрт орших ТЗДЗүйлсийн мэдээлэл, бүртгэл холбогдох бичиг баримт, үндэсний хөтөлбөр, албан даалгаврын хувийн хэргийг хөтлүүлж, хууль, тогтоомж, судалгаа, мэдээллийг өгч ажиллаж байна. Соёлын биет бус өвийн аймгийн наадамд Арвайхээр сумаас нийт 20 ардын авъяастан, гар урлаач оролцсноос улсын уралдаанд ардын билгээ, ардын бүжиг төрөл улсын уралдаанд оролцох эрх авсан	70	70
18.	1.3.2 Кино театр шинээр барьж, Занабазар музейн барилгын их засвар хийх, томоохон байгууллага, аж ахуй нэгжүүд ажиллагсадыг чийрэгжүүлэх танхимтай болгох ажлыг хэрэгжүүлнэ.	53. Кино театр шинээр барьж, Занабазар музейн барилгын их засвар хийх	Занабазар музейн засварын ажлыг 2017 онд "Тахидаг Овоо" ХХК 17 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гадна пасадыг шинэчилж, дээврийн засварын ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн.	40	70
		54. Байгууллага аж ахуй нэгжүүд ажиллагсадын хэрэгцээ шаардлагад нийцсэн нийтийн биеийн тамирын талбай, чийрэгжүүлэх танхим, гүйлт алхалтын зам, талбай байгуулах сэргээн тохижуулах ажлыг дэмжих	Аймгийн ЗДТГазар, БТСГазар, МСҮТөв фитнес клубтэй, БОЭТөвийн чийрэгжүүлэх төвтэй, ЕБ-ын 1, 2-р сургуулиуд гадна сагс, волейбол, тоглоомын талбайтай. Сумын төвийн харьяа орон нутгийн засаг захиргаа, боловсрол, эрүүл мэндийн салбарын 19 байгууллагаас энэ оны дүнгээр байгууллагын дэргэд нийтийн биеийн тамирын талбай, иж бүрэн чийрэгжүүлэх танхимтай байгууллага одоогоор байхгүй хэдий ч 1, 2, 3, 4 дүгээр сургуулиуд шахалтын болон гэдэс таталтын вандан, гар гантель, твистр, г үйлтийн зам зэрэг 6-7 нэр төрлийн төхөөрөмжтэй. 2018 онд Арвайхээр сумын хэмжээнд 1, 9, 12, 2, 7 дугаар багуудад багийн төвтэй спорт зал, хувийн хөрөнгө оруулалтаар багийн нэгдсэн төвийн дэргэд тус тус спорт зал баригдаж ашиглалтанд орсон. Спорт залны гадна пасатны их засварыг улсын төсвийн 34 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар хийж, ашиглалтанд өгсөн. Улсын төсвийн 1 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтаар гадна талдаа сагсан бөмбөг, хөл бөмбөгийн ногоон талбай, тоглоомын талбайтай стандартын Спорт зал баригдаж эхэлсэн бөгөөд 2018-2019 оны хичээлийн жилд ашиглалтанд орно.	100	100
19.	1.3.3 Урлаг, спортын бага наадмыг 2 жил	55. Урлаг, спортын наадмыг 2 жилд нэг	Үнэлэх боломжгүй.	-	-

	<p>тутам зохион байгуулан авьяастнуудыг алдаршуулж, улс бүс, олон улсын уралдаан тэмцээнд оролцогчдод дэмжлэг үзүүлж, нэрэмжит уралдаан тэмцээнийг зохион байгуулна.</p>	<p>удаа зохион байгуулах</p>	<p>2018 онд Арвайхээр сумын ЗДТГазар, “ӨВ-ЗАР” зарын узелтэй хамтран “Нэг өрх-нэг ажлын байр” хөтөлбөрт хамрагдсан иргэдийн дунд 2018 оны 5 дугаарын сарын 13-ны өдөр спортын 3 төрлөөр нийтдээ 70 гаран тамирчид оролцож амжилттай зохион байгуулсан.Тэмцээний зардалд нийтдээ 175000 төгрөг зарцууллаа. Арвайхээр сумын “Хүүхдийн хөгжил хамгаалал” зорилтод жилийн хүрээнд “УНАСАН ГАЗАР УГААСАН УС МИНЬ” адал явдал явган аяллыг 2018 оны 05 дугаар сарын 26 нд зохион байгууллаа тус тэмцээнд 3 сургуулийн 6 баг 60 хүүхэд оролцож амжилттай зохион байгууллаа.Тэмцээний зардалд нийт 553800 төгрөг зарцууллаа. Чөлөөт бөхийн спортын мастер Э.Баттүшигийн нэрэмжит “Бид ирээдүйн аварга”-ууд үндэсний бөхийн өсвөрийн тэмцээнд нийтдээ 74 хүүхэд оролцож амжилттай зохион байгуулсан. Тэмцээний зардалд нийт 150000 төгрөг зарцууллаа. Зорилтот жилийн хүрээнд “Хөгжилийн харандаа” гар зургийн уралдаан зохион байгуулж 33 оролцож амжилттай зохион байгуулла. Тэмцээний зардалд нийтдээ 150000 төгрөг зарцуулсан. Өвөрхангай аймгийн “Шатрын аварга баг” шалгаруулах тэмцээн 2018 оны 04 дүгээр сарын 07-08-ны өдрүүдэд зохион байгуулжнийтдээ 114 тамирчид оролцож тус тэмцээнд нийтдээ 1,000,000 дэмжлэг үзүүллээ. Хагас жилийн байдлаар 5 тэмцээнийг аймаг, баг, төрийн бус байгуулагтай хамтран зохион байгуулж тэмцээнд нийтдээ 570 гаран тамирчид хамрагдаж тэмцээний зардалд нийт 2028800 төгрөг зарцууллаа.Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагдсан “Иргэдийн спортын наадам”-д 416 иргэн оролцсон бөгөөд багийн дүнгээр санай сум 1 дүгээрт байрт шалгарсан. Сумын Засаг даргын 2016 оны а/45 дугаар захирамжаар шинэчлэн батлагдсан “Улс, олон улсын уралдаан тэмцээн, олимпиадад оролцох хүүхэд, баг тамирчдад дэмжлэг үзүүлэх журам”-ын хүрээнд улсын уралдаан тэмцээнд оролцсон 2 баг, спортын 1 арга хэмжээнд 450000 төгрөгийн дэмжлэг үзүүллээ.</p>	<p>100</p>	<p>70</p>
--	--	------------------------------	---	------------	-----------

		57. Орон нутгаас төрөн гарсан спортын алдартнуудын нэрэмжит тэмцээнийг зохион байгуулах	<p>“Уран жиргээ-2017” улсын уралдаанд 2-р цэцэрлэгийн Г.Очирбуян, “Дэгдээхий нас” улсын уралдаанд 6-р цэцэрлэгийн “Өсөх-Ирээдүй” бүжгийн хамтлаг, сувилагчдын Улсын аварга шалгаруулах спортын тэмцээнд оролцох аймгийн Эрүүл мэндийн газрын сувилагчдын багийн бүрэлдэхүүнд тус тус сумын Засаг даргын захирамжаар нийтдээ 340000 төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Олон улсын спортын мастер, аймгийн арслан С.Доржваанчигийн нэрэмжит волейболын тэмцээн 5 дугаар сард болж, нийтдээ 25 багийн 150 тамирчин оролцсон. Чөлөөт бөхийн спортын мастер Д.Буянтогтохын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах өсвөрийн тэмцээн 2 дугаар сард болж, эрэгтэй 11, эмэгтэй 10 жинд 18 сум 7 дэвжээний нийт 428 тамирчин оролцсон. ОУХМастер Д.Амарсанаагийн нэрэмжит намрын тэргүүн шалгаруулах хөнгөн атлетикийн, шатрын спортын мастер Ж.Жанцандоржийн нэрэмжит аймгийн аварга шалгаруулах өсвөрийн тэмцээн 1 дүгээр сард зохион байгуулж нийтдээ 19 сумын 340 гаруй хүүхэд оролцсон. Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат дасгалжуулагч Ч.Насантогтохын нэрэмжит жүдо бөхийн өсвөрийн тэмцээн 10 дугаар сард зохион байгуулагдаж, 15 байгууллагын 200 гаруй тамирчид оролцсон.</p> <p>2018 оны дүнгээр орон нутгаас төрөн гарсан спортын алдартнуудын нэрэмжит 5 удаагийн тэмцээнд давхардсан тоогоор 1100 гаруй тамирчид оролцлоо.</p>	100	70
<b>Салбарын дундаж үнэлгээ</b>			<b>87.1</b>	<b>91.4</b>	
<b>1.4 Хүүхэд, залуучууд гэр бүлийн хөгжил</b>					
20.	1.4.1 “Хүүхдэд ээлтэй аймаг” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүүхдийн хөгжил, эрхэд суурилсан хүртээмжтэй төсөл, хөтөлбөрийн болон иргэний нийгэм, олон улсын байгууллагын хамтын ажиллагааны түншлэлийг бий	58. “Хүүхдэд ээлтэй аймаг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэх	“Хүүхдэд ээлтэй аймаг” хөтөлбөрийн 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 8 зорилт арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөн, ЗДТГазрын даргаар батлуулан ажилласан. Төлөвлөгөөний биелэлт 11 сарын дүнгээр 90.8 хувьтай байна.	100	
		59. Хүүхдийн эрхэд суурилсан төсөл, хөтөлбөр, иргэний нийгмийн байгууллагын	Швейцарийн хөгжлийн агентлаг, Монгол Улсын засгийн газар, БСШУЯамнаас санаачлан зарласан төслийн уралдаанд Мэргэд лаборатори сургуулийн “Цэнхэр сувд” төсөл шилдэг 8-т шалгарч 9.2 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр	100	70

	болгоно.	санал санаачлагыг дэмжин ажиллах	болсон. Төслийн хүрээнд багш, сурагчдад "Ус ба байгаль" сургалт зохион байгууллаа. Сургалтанд 6-9 дүгээр ангийн 450 сурагч, 60 багш хамрагдаж, цэвэр усаа зөв зохистой хэрэглэх, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах талаар мэдлэг эзэмшлээ. "Хотын соёл биднээс эхэлнэ" сэдэвт ЕБС-ийн анги хамт олны дунд сурагчдын бүтээлч үйл ажиллагаа, эерэг хандлагыг дэмжин хүүхэд хүүхэддээ нөлөөлөх зөв төлөвшлийг бий болгох, болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор төслийн уралдааныг зохион байгуулсан. Төслийн уралдаанд ЕБС, МСҮТ-ийн 7 ангийн төсөл ирснээс 2 төслийг тус бүр 150.0 мянган төгрөгийн санхүүжилтээр дэмжин хэрэгжүүлэхээр болж, санхүүжилтийг олгон төслийн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Японы хүүхдийг ивээх сангийн "Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулахыг дэмжих нь" төслийн хүрээнд 4.5 сая төгрөгийн санхүүжилтээр НТБ-ын мэдээлэл, сургалтын танхимыг тохижуулж, сургалтын орчин бүрдүүлэхээр болсон. Дэлхийн зөн олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд "Хүүхэд хөгжлийн танхим"-ыг байгуулсан.		
21.	1.4.2 Хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх, амьдралын зөв дадалд сургах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, мэргэжлийн чиг баримжаатай болгох төрөл бүрийн секц, дугуйлан, сургалт, мэдээллийн олон талт үйл ажиллагааг дэмжиж, "Хүүхэд, залуучуудын хөгжлийн ордон"	60. Хүүхдийн урлагийн их наадмыг 2 жил тутам зохион байгуулах	Сургууль, цэцэрлэг тус бүрт 1 дүгээр шатны шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан 1000 гаруй хүүхэд аймгийн хүүхдийн урлагийн "Аз жаргалтай аялгуу" 5 дугаар их наадамд оролцож, 96 багц медалийн эзэд болж, нийлбэр дүнгээр Арвайхээр сум гуравдугаар байранд шалгарсан амжилтыг үзүүлсэн.	100	100
		61. Хүүхэд, залуучуудад зохистой цахим хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр цахим тоглоомын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих	Цахим тоглоомын газруудад аймаг, сумын ГХУСАЗЗөвлөл, ГБХЗХГазар, МХГазар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газрын холбогдох албан хаагчидтай хамтран 4 удаагийн хяналт шалгалтыг хийхэд 2 газарт орчны эрүүл ахуй стандарт шаардлага хангахгүй зөрчил илэрсэн. Шалгалтаар зөрчилтэй гарсан газруудад зөрчлөө арилгах хугацаатай албан мэдэгдэл хүргүүлэн, холбогдох газарт тайланг хүргүүлэн ажилласан.	100	70
		62. "Хүүхэд залуучуудын хөгжлийн ордон" байгуулах	"Хүүхэд залуучуудын хөгжлийн ордон"-ы барилгын ажлыг "МТ" ХХКомпани хийж, ажлын гүйцэтгэл 90 хувьтай явагдаж байна. 12 дугаар сард багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөн	100	100

	байгуулна.		ажиллаж байна.		
		63. Хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх, чадваржуулах олон талт үйл ажиллагааг дэмжин клуб, секц, дугуйлангийн тоог нэмэгдүүлэх	ЕБС-иудын хичээлээс гадуурх 85 сонгон, секц, дугуйланд 1735 хүүхэд суралцаж байна. Ерөнхий боловсролын 5 сургуулийн хэмжээнд 53 ХӨУБайгууллага үйл ажиллагаа явуулж, түүнд 1962 хүүхэд хамрагдсан байна. ХӨУБ-ыг чадавхжуулах сургалтуудыг сургууль тус бүрт зохион байгуулж, 12 удаагийн сургалтанд 826 ХӨУБ-ын гишүүн хүүхдүүд хамрагдлаа.	100	70
22.	1.4.3 Хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг үнэлэх, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үнэлгээ хийсэн мэдээллийн сан бүрдүүлэн ашиглах, урьдчилан сэргийлэх үе шаттайгаар зохион байгуулна.	64. Хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг үнэлэх ажлыг тогтмолжуулж, мэдээллийн сан бүрдүүлэх	Сумын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 121 хүүхэд байгаагийн 95 нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй, 26 нь олдмол бэрхшээлтэй байна. Нийт ХБХүүхдийн 71 буюу 58 хувь нь байнгын асаргаанд байдаг бол 104 буюу 85 хувь нь боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй улмаас сургууль завсардсан 13 хүүхэд, ар гэрийн болон бусад шалтгаанаар сургууль завсардсан 24 хүүхэд байна. Хөдөлмөр эрхэлдэг 14 хүүхдийн 9 нь буюу 64 хувь нь хөдөө аж ахуйн салбарт мал маллаж байна. Бүтэн өнчин хүүхэд 40, хагас өнчин 308 хүүхдийн статистик судалгаа гарлаа. Эрсдэлт нөхцөлд байгаа 174 хүүхэд, зорилтот бүлгийн 272 гэр бүл байна.	100	70
		65. Хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдэд чиглэсэн нийгмийн халамж, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг цогцоор хүргэх	Тусгай хэрэгцээт 11 дүгээр цэцэрлэг нь 2017-2018 оны хичээлийн жилд үйл ажиллагаагаа эхлүүлж, 2018-2019 оны хичээлийн жилд тус цэцэрлэгийн өргөтгөлийн ажлыг нийт 81,8 сая үүнээс ДЗОУБайгууллага 35,5 сая, орон нутгийн төсвөөс 46,3 сая төгрөгөөр өргөтгөл барьж ашиглалтанд оруулсны үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын үйлчилгээ авах эрх хангагдаж байна. Олон хүүхэдтэй зорилтот бүлгийн 39 гэр бүлд аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5 ханатай иж бүрэн гэр олгосон. “Цагаан залаа” Хүүхэд хөгжлийн зусланд зорилтот бүлгийн 140 хүүхдийг үнэ төлбөргүй амрааж, хүүхдүүдийн хөгжил, оролцоог хангасан.	70	70
		66. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчийг	Байнгын асаргаатай 71 хүүхэд нийгмийн халамжийн үйлчилгээнд бүрэн хамрагдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчдад нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж, асаргаа сувилгааг хэрхэн	100	70

		асаргаа, сувилгааны сургалтанд хамруулах	хийх талаар сургалтыг “Түшиг дөлгөөн” ӨЭМТөв дээр зохион байгуулж, сургалтад асран хамгаалагч 21 иргэн хамрагдсан. 2018 оны 8 дугаар сарын 3-8-ны өдрүүдэд хүүхдийн зуслангийн тусгай ээлжинд хүнд хэлбэрийн байнгын асаргаатай 5 хүүхдийг асран хамгаалагчийн хамт хамрууллаа. Энэхүү үйл ажиллагаа нь хүүхдэд чадамжийн үнэлгээ хийж, цаашлаад хөгжих боломжийг таниулан, асран хамгаалагчдад мэдээлэл өгөх, сэтгэл зүйн болон хувь хүний хөгжлийн сургалтуудыг явуулсан. Тусгай хэрэгцээт 11 дүгээр цэцэрлэгийн 3 бүлэгт 34 хүүхэд суралцаж байна. Цэцэрлэгийн эмч, багш нар эцэг эхчүүдэд өдрийн үйл ажиллагаагаа танилцуулан хүүхдээ хэрхэн асарч сувилах талаар тогтмол зөвлөгөө өгснөөр эцэг эх, багшийн уялдаа холбоо сайжирч, хүүхдүүдийн хөгжилд ахиц гарч байна.		
23.	1.4.4 Гэр бүлийн хүчирхийлэл, дарамтанд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах, нөхөн сэргээх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр “Хамгаалах байр”, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллана.	67. Гэр бүлийн харилцааны үнэт зүйл, ёс зүй, гэр бүл төлөвлөлтийн талаар сургалт сурталчилгааг зохион байгуулж, жил бүр 500-аас доошгүй иргэн хамруулах	Монголын үг урлаачдын нийгэмлэгийн хүмүүнлэгийн лектор Г.Бандицэрэн /chila / багшийн “Амьдралын үнэ цэнэ” сургалтад ерөнхий боловсролын сургуулиудын 250 багш ажилчид, 2450 сурагч, 790 эцэг эх хамрагдлаа. ЕБ-ын 1 дүгээр сургууль “Эртэч монгол аав” өглөөний цайны арга хэмжээг зохион байгуулж, 5-р ангийн 6 бүлгийн 60 аавын төлөөлөл хамрагдлаа. Өглөөний цайны арга хэмжээнд оролцсон аавуудад 5г ангийн багш А.Билэгжаргал “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдэвт сургалт, 5г ангийн аав П.Алтангэрэл “Хүүхэд гэр бүлийн толь” сэдэвт сургалтыг хийж, өөрийн туршлагаасаа хуваалцсан. Гандантэгчинлэнхийдийнхамба лам Д.Чойжамц ЕБ-ын 4 дүгээр сургуулийн нийт багш ажилчид болон 11 дүгээр ангийн 100 гаруй сурагчтай уулзаж ёс зүй, харилцаа хандлага хүмүүжил төлөвшлийн талаар сургаал ном айлдлаа.	100	70
		68. Хүчирхийлэлд өртсөн болон хүчирхийлэл үйлдэгч иргэдийн судалгааг гаргаж, шаардлагатай нийгмийн үйлчилгээг хүргэх	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор сум, багийн хамтарсан багийн бүрэлдэхүүнийг батлуулсан. Баг тус бүрт хамтарсан баг ажиллаж, гэр бүл, хүүхдүүдэд нийгмийн анхдагч үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. 2018 оны байдлаар хамтарсан багууд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой 45 гэр бүлтэй ажиллаж, 57 хүнд сэтгэл зүйн зөвлөгөө, 23 хүнд аюулгүй байдлын хамгааллын, 53 хүнд нийгмийн халамжийн, 35 хүүхдэд хүүхэд хамгааллын	100	70

			үйлчилгээ, 19 хүнд эмнэлэгийн тусламж, 16 хүнд холбон зуучлах үйлчилгээг тус тус үзүүлэн ажиллалаа.		
		69. Багуудын "Хамтарсан баг"-ийг чадавхжуулах сургалтанд хамруулж, үйл ажиллагааг тогтмолжуулах	ГБХЗХГазартай хамтран сум, багийн төвшинд үйл ажиллагаа явуулж байгаа хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг 3 дугаар сард зохион байгуулсан. ХЭҮТөвөөс зохион байгуулсан "Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт 3 өдрийн гэрчилгээтэй сургалтад хамтарсан багийн гишүүдийг хамруулж, чадваржууллаа. 3, 6 дугаар багийн нийгмийн ажилтнуудыг бүсийн сургалтад хамруулж, туршлага судлуулсан. Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнууд Улаанбаатар хотод "Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх арга зүй" сэдэвт сургалтад хамрагдаж, анхан шатны сэтгэл зүйн зөвлөгөө өгөх чадварт суралцсан.	100	70
<b>Салбарын дундаж үнэлгээ</b>				<b>97.5</b>	<b>78.0</b>
<b>1.5 Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал</b>					
24.	1.5.1 Ажлын байр нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээг авч, 3000-аас доошгүй байнгын болон түр ажлын байр бий болгоно.	70. Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хууль тогтоомжийг ажил олгогч аж ахуй нэгж байгууллага болон ажил хайгч иргэдэд сурталчлах	2017 онд "Хөдөлмөрийн тухай" хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудыг сурталчилах зорилгоор 1 удаа сургалт зохион байгууллаа. Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас зарласан "Зохистой хөдөлмөр 2018" аяны хүрээнд Барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж ажиллая" сэдэвт сургалт, Аймгийн ХХҮГазартай хамтран үйлдвэрлэлийн осол гарч болзошгүй аж ахуйн нэгж, байгууллагын ажилчдад "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль"-иар сургалт зохион байгуулж, гарын авлага материал тараасан 2018 онд "Хөдөлмөрийн тухай" хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудыг сурталчилах зорилгоор 2 удаа сургалт зохион байгууллаа. Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас зарласан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй - 2018" аяны хүрээнд аж ахуй нэгж, байгууллагуудад "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж ажиллая" сэдэвт сургалт, аймгийн	100	40



			ХХҮГазартай хамтран үйлдвэрлэлийн осол гарч болзошгүй аж ахуйн нэгж, байгууллагын ажилчдад “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-иар сургалт зохион байгуулж, гарын авлага материал тараасан. Мөн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, бизнесийн орчинг сайжруулах” зорилтын хүрээнд “Ажил олгогчдын зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлэг” арга хэмжээг 9 дүгээр сард зохион байгууллаа. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 01 дүгээр тогтоолоор хэрэгжсэн 6 хөтөлбөрийг Arvaikheer.mn вэб сайтад байршуулан иргэдэд сурталчилсан.		
	71. Хот тохижилт болон бусад тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор нийтийг хамарсан ажлын төсөл боловсруулан батлуулж, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг хамруулан өрхийн орлогыг нэмэгдүүлэх	2017 онд төсөлд тусгагдсан 6 төрлийн төлөвлөгөөт ажлын дагуу нийтийн эзэмшлийн зам талбайд зүлэг, мод тарих, усалгаа арчилгаа хийх, нийтийн эзэмшлийн зам талбайн хайс, хашлагыг засварлаж будах, Дэлгэрэх голын гольдролыг шулуутгах ажилд нийт 490 иргэнийг ажиллуулж 88 сая төгрөгийн цалин олгосон. 2018 онд Нийтийг хамарсан ажлыг зохион байгуулах журмыг үндэслэн орон нутгийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Арвайхээр-Эрүүл, ногоон хот” төслийн хүрээнд нийтийг хамарсанажилд ажиллах хүсэлт гаргасан, 6 сараас дээш хугацаагаар ажил идэвхтэй хайж байгаа зорилтот бүлгийн иргэдтэй гэрээ байгуулан, арга зүйн заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Малын сэг зэм устгаж цэвэрлэх ажилд 20 иргэнийг 10 хоног, дахин 10 иргэнийг 3 хоног, Зүлэгжүүлэлтийн ажилд 10 иргэн 5 хоног, эко хавтан наах ажилд 10 иргэн 5 хоног, төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн засварын ажилд 20 иргэнийг 10 хоног нийт 60 иргэнийг түр ажлын байраар хангаж 14 сая төгрөгийн цалин олголоо.	100	40	
	72. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор	2017 онд 800-аас доошгүй байнгын болон түр ажлын байр бий болгохоор төлөвлөсөн. Аж ахуй нэгж байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалгын дагуу 487 иргэнийг зуучиллаа. Мөн Сум хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, халамжийн санхүүжилтээр хэрэгждэг зээл,	100	70	

	батлагдсан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, ажлын байраар хангах	дэмжлэг, төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнд Арвайхээр суманд нийт 284 ажлын байр бий болсон байна. Байнгын ажлын байранд 444, түр ажлын байранд 667 иргэнийг зуучилж төлөвлөгөөний биелэлт 138 хувьтай хэрэгжлээ. 2018 онд Аж ахуй нэгж, байгууллагуудаас авсан ажлын байрны мэдээгээр нийт 599 ажлын байр, сум хөгжүүлэх сангийн зээлээр 19, Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнд 198 буюу нийт 816 байнгын болон түр ажлын байр бий болж 2018 оны төлөвлөгөөний биелэлт 102 хувьтай хэрэгжлээ. Үүнд: “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд бүлийн зохион байгуулалттай төмс, хүнсний ногоо тариалах арга хэмжээнд 10 бүлийн 41 иргэн 9.4 сая, ажлын байрыг дэмжих төсөлд 69 иргэнд 189 сая, нийтийг хамарсан ажилд 60 иргэн хамрагдаж 16.8 сая төгрөгийн цалин, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 13 иргэнд 33 сая төгрөгийн зээл, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 4 иргэнд 10.5 сая төгрөгийн зээл олгосон, Ахмадын зөвлөх үйлчилгээ үзүүлэх төсөлд 3 ахмад хамрагдаж 840,0 төгрөг, ахмадын санхүүгийн дэмжлэгт 6 ахмад хамрагдаж 15 сая төгрөг, Малжуулах хөтөлбөрт 2 малчин өрх хамрагдаж нийт 9 сая төгрөгийн мал худалдан авч нийт 283.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.		
	73. Зээл, дэмжлэгт хамрагдсан иргэдийн бизнесийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах	2017 онд Сум хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, халамжийн санхүүжилтээр хэрэгждэг зээл, дэмжлэгт хамрагдсан иргэдийн бизнесийн үйл ажиллагаа, зээлийн эргэн төлөлтөнд холбогдох албан хаагчид хяналт тавин ажиллаж байна. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 01 дүгээр тогтоолоор хэрэгжсэн 6 хөтөлбөрийг ХХҮГазар хэрэгжүүлсэн. Журмын хүрээнд төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэнүүд “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-т хамрагдсан 40 иргэний бизнесийн үйл ажиллагаанд хяналт хийж ажилласан байна. 2018 онд Сум хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, халамжийн санхүүжилтээр олгогдсон төсөл, хөтөлбөрийн зээлд хамрагдсан иргэдийн бизнесийн үйл	100	40

			ажиллагаа, зээлийн эргэн төлөлтөнд холбогдох албан хаагчид хяналт тавин ажиллаж байна.		
25.	1.5.2 “Нэг өрх-Нэг ажлын байр” хөтөлбөр, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллана.	74. “Нэг өрх-Нэг ажлын байр” хөтөлбөр, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах	<p>2017 онд “Нэг өрх-Нэг ажлын байр” хөтөлбөрийн хүрээнд байнгын ажлын байранд 36, түр ажлын байранд 68 иргэнийг зуучилж, 17.1 сая төгрөгийн цалин олгуулж өрхийн орлогыг нэмэгдүүллээ. Хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийн амьжиргааны өөрчлөлт, өсөлтөд явцын үнэлгээ хийхэд нийт өрхийн 94.5 хувийг байнгын болон түр ажлын байр, зээл, дэмжлэгт хамруулсан. Сумын ИНХТэргүүлэгчдийн 17 дугаар хуралдаанаар хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнаж 96.5 хувьтай үнэлэгдсэн.</p> <p>2018 онд “Нэг өрх-Нэг ажлын байр” хөтөлбөрт 120 өрхийн 626 иргэнийг хамрууллаа. 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа сар бүрийг зорилтот сар болгон зарлаж, төлөвлөгөөний дагуу холбогдох албан хаагчид сар бүр төлөвлөсөн ажлаа амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа. Хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийн хэрэгцээний судалгааг нарийвчлан гаргаж, холбогдох албан хаагчид дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Байнгын ажлын байранд-30 иргэн, түр ажлын байранд 88 иргэнийг зуучилж төлөвлөгөөний биелэлт 49 хувь, өрхийн орлого нэмэгдүүлэх зээл, дэмжлэгт 7 өрх хамрагдсан, хүнс тэжээлийн үйлчилгээнд 78 өрх 100 хувь хамрагдсан, тусламж дэмжлэг зайлшгүй шаардлагатай 67 өрхийг байгууллагын харъяа төсөвт байгууллагуудад хувиарлан өгч сайн үйлсийн аян өрнүүллээ. Мөн бусад байгууллага, аж ахуй нэгжийн санаачлагаар 117 иргэнд тусламж дэмжлэг үзүүлсэн байна. Хүсэлт гаргасан 56 өрхийн 91 хувь нь өөрийн өмчлөлийн газартай болсон. Цэцэрлэгт 49 хүүхэд хамруулсан, 4 хүүхдийг 12 дугаар цэцэрлэгт хамруулахаар төлөвлөж хамран сургалт 92.4 хувьтай хэрэгжиж байна.</p> <p>24 төрлийн сургалт, лекц, хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 222 иргэнийг хамруулсан. Нийт хамрагдсан өрхүүдийн амьжиргааны түвшинд явцын үнэлгээ нийхэд 114.7 сая төгрөгийн бодит дэмждэг туслалцаа үзүүлсэн байна.</p>	100	40.0

			Сумын ИНХТөлөөлөгчдийн 7 дугаар хуралдаанаар хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнаж 93.5 хувьтай үнэлэгдсэн.		
		75. Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчилан ажиллах	2017, 2018 онд Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа сар бүрийг зорилтот сар болгосон. Үүнд: 1 дүгээр сарыг “Судалгааны”, 2 дугаар сарыг “Эрүүл мэндийн”, 3 дугаар сарыг “Спортын”, 4 дугаар сарыг “Газар тариалангийн”, 5 дүгээр сарыг “Гэр бүлийн”, 6 дугаар сарыг “Эх үрсийн”, 7 дугаар сарыг “ Монгол зан заншлыг сурталчилах”, 9 дүгээр сарыг “Нэг өрх-Нийгмийг хөдөлгөгч хүч”, 10 дугаар сарыг “ хүүхдийг дэмжих”, 11 дүгээр сарыг “Сайн үйлсын аяны”, 12 дугаар сарыг “Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг тооцох сар” болгон зарласан. Төлөвлөгөөний дагуу холбогдох албан хаагчид сар бүр төлөвлөсөн ажил, үйлчилгээгээ амжилттай хэрэгжүүлж Arvaikheer.mn вэб сайтад байршуулж олон нийтэд сурталчилсан.	90	70
26.	1.5.3 Шинээр ажлын байр олноор бий болгосон, тогтвортой үйл ажиллагаа явуулж, ажлын байраа хадгалан сумын эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулж буй аж ахуйн нэгж байгууллагуудыг дэмжих бодлого баримтлана.	76. “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх	2017 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл авч, ажлын байр түрээслэж үйлдвэрлэл, үйлчилгээгээ тогтвортой явуулж байгаа 5 иргэнд ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлсэн байна. “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 4 иргэнд нийт 632000 төгрөг, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 1 иргэнд 87360 төгрөгийн түрээсийн дэмжлэг олгосон байна. 2018 онд “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд ажил олгогчийн дэмжлэгт хамрагдах шалгуур үзүүлэлтийг хангасан 6 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан ажилласан. Ажлын байраа тогтвортой хадгалж, ажилчдынхаа нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлж гэрээний заалтыг бүрэн хэрэгжүүлсэн 6 аж ахуйн нэгжид ажил олгогчийн дэмжлэгийг ХЭДСангаас олгосон. Тус аж ахуйн нэгжүүд 6 иргэнийг байнгын ажлын байраар хангаж нийт 16.8 сая төгрөгийн дэмжлэг авсан.	100	70
		77. Аж ахуй, бичил бизнес болон нөхөрлөл, хоршооны	2017 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 69 иргэн, аж ахуй нэгж, компанид 521.1 сая төгрөгийн зээлийг 24 сарын хугацаатай олгож 150 ажлын байрыг дэмжиж	100	70

	хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэдийг зээлийн бодлогоор дэмжих	ажилласан байна. Үүнд:Голомт банкаар дамжуулан олгож байгаа Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээлэнд 8 аж ахуйн нэгж, 35 иргэнийг хамруулж 448,1 сая төгрөгийн зээл олгож 118 шинэ ажлын байр, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 11 иргэнд 28 сая төгрөгийн зээл олгож 17 ажлын байр, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 15 иргэнд 45 сая төгрөгийн зээл олгож 15 ажлын байр бий болсон. 2018 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийг Хаан болон Төрийн банкаар дамжуулан нийт 123 төслийг шалгаруулж 984.5 сая төгрөгийн зээлийг олгосон байна. Үүнд: Хаан банкаар 53, Төрийн банкаар 70 төсөл дэмжигдсэн байна.		
	78. Бизнес эрхлэгч иргэдийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг иргэдэд сурталчилан таниулах, орлогыг нэмэгдүүлэх зорилгоор үзэсгэлэн худалдаанд оролцуулах ажлыг хэвшүүлэх	"Намрын ногоон өдрүүд-2017" үзэсгэлэн худалдаанд тус сумын 19 иргэн, ААНэгж үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээрээ оролцож 3 өдрийн хугацаанд 10.8 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Ундрах баян ирээдүй хоршоо “Хамгаалагдсан хөрснөөс хамгийн их бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн” хоршоогоор,Бизнесийн шинэ санаа нэвтрүүлэх ТББайгууллага нь шинэ технологи нэвтрүүлсэн ААНэгжээр, Хос хангай фүүд ХХК “хүнсний шилдэг” бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, Ноос ирээдүй ХХК “шилдгийн шилдэг гран при”–аар тус тус шалгарлаа. 2018 онд “Цагаан сар-2018” үзэсгэлэн худалдаанд 16 иргэн, 4 аж ахуйн нэгж, 2 хоршоо нийт 22 иргэн, аж ахуйн нэгж оролцож 4 өдрийн хугацаанд 23.500.000 төгрөгийн борлуулалт хийгдлээ. Багийн нэгдсэн өдөрлөг арга хэмжээтэй хамтатган сумын “Намрын өдрүүд” үзэслгэлэн худалдааг зохион байгуулав. Тус үзэсгэлэн худалдаанд 5 иргэн, аж ахуйн нэгж 12 төрлийн төмс, хүнсний ногоо, даршилсан бүтээгдэхүүнээр оролцож 370.000 төгрөгийн борлуулалт хийсэн. Тус үзэсгэлэн худалдааны “Хамгийн олон нэр төрөл”-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээр 9-р багийн тариаланч С.Ганчиндорж, “Шилдэг сав баглаа боодолтой” бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээр 9-р багийн тариаланч	100	70

			3. Угтахбаяр тус тус шалгарлаа. Өвөрхангай түншлэл-2018 үзэсгэлэн худалдаанд сумын 33 иргэн, ААНэгж үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээрээ оролцож 3 өдрийн хугацаанд 17.162.000 төгрөгийн борлуулалт хийсэн. Монлайн компаний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн шилдэг оёмол бүтээгдэхүүн, 13 дугаар багийн иргэн Уранчимэг шилдэг ноосон эдлэлийн бүтээгдэхүүн, П.Гандолгор шилдэг шүлжмэл бүтээгдэхүүнээр тус тус шалгарсан.		
27.	1.5.4 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх, ажилд зуучлах үйлчилгээнд хөдөлмөр эрхлээгүй иргэд, ЕБС-ийн ахлах ангийн сурагчид зэрэг 3000-аас доошгүй иргэнийг хамруулна.	79. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээнд жилд 300-аас доошгүй ажилгүй иргэнийг хамруулах	2017 онд чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээнд нийт 294 иргэнийг хамруулсанаар төлөвлөгөөний биелэлт 98.9 хувьтай хэрэгжлээ. 2018 онд сумын хөдөлмөрийн нэгжээс ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөөмэдээлэл өгөх үйлчилгээнд 305 иргэнийг хамруулсанаар төлөвлөгөөний биелэлт 101 хувьтай хэрэгжлээ.	100	70.0
		80. Аж ахуйн нэгж, байгууллагуудаас ажлын байрны захиалга авч, ажилд зуучлах үйлчилгээнд жилд 450-аас доошгүй иргэнийг хамруулах	2017 онд Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн ажлын байрны захиалгын дагуу байнгын болон түр ажлын байранд 487 иргэнийг зуучилснаар төлөвлөгөөний биелэлт 108 хувьтай хэрэгжсэн. 2018 онд Аж ахуй нэгж, байгууллагуудаас авсан ажлын байрны мэдээгээр нийт 599 ажлын байр, сум хөгжүүлэх сангийн зээлээр 19, Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнд 198 буюу нийт 816 байнгын болон түр ажлын байр бий болж 2018 оны төлөвлөгөөний биелэлт 102 хувьтай хэрэгжлээ.	100	70.0
28.	1.5.5 Аж ахуйн нэгж байгууллагуудын хөдөлмөрийн харилцаа, ажлын байрны аюулгүй байдал, ажиллах нөхцлийг сайжруулан цалин хөлсийг ажилласан цагаар олгодог тогтолцоог бий болгоно.	81. Аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын байрны аюулгүй байдлыг хангах, ажиллах нөхцлийг сайжруулах, цалин хөлсний тогтолцоог оновчтой, ил тод болгох, ажлын хөлсийг ажилласан цагаар	2017 онд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг зарлаж, тус аяны хүрээнд Арвайхээр сумын Засаг даргын 2017 оны А/44 дугаарын захирамжаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийг байгуулж ажилласан. Аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын байрны аюулгүй байдлыг хангах, ажиллах нөхцлийг сайжруулах, цалин хөлсний тогтолцоог оновчтой, ил тод болгох, ажлын хөлсийг ажилласан цагаар олгох тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Шатахуун түгээх станцуудад хяналт шалгалт хийхэд хөдөлмөрийн гэрээнд	100	70

		<p>олгох тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>цалингийн хэмжээг тусгаагүй зөрчил илэрсэн. Зөрчлийн дагуу зөвлөмж хүргүүлж ажилласнаар ажлын хөлсийг ажилласан цагаар олгох нөхцөл бүрдсэн. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн дагуу ЗДТГазрын 03/107 дугаарын зөвлөмжийг хүргүүлж, төлөвлөгөөний дагуу дахин хяналт хийхэд Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулиуд 91.7 хувийн үнэлгээтэй хэрэгжиж байгаа талаар бодит үр дүн гарч өмнөх үеэс 6.1 хувиар өссөн байна.</p> <p>2018 онд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн 2018 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан.</p> <p>Төлөвлөгөөний дагуу дулаан үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг томоохон 6 аж ахуй нэгжийн 9 уурын зуухыг хамруулсан. Үүнд: “Арвай-Илч” ХХК, “Хөтөлт-Илч” ХХК, “Өв-Илч” ХХК, “Арвай плас” ХХК, “Өв пост” ХХК, “Мөнх-Осго” ХХК зэрэг аж ахуй нэгжүүдэд "Хөдөлмөрийн тухай" хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж, арга зүйн зөвлөгөө өгч, мэдээ мэдээллээр хангаж ажиллахад Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулиуд 73.1 хувийн үнэлгээтэй хэрэгжиж байгаа талаар бодит үр дүн гарлаа. Засаг даргын 01/75 дугаарын зөвлөмжийг хүргүүлж, дахин хяналт хийхэд Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулиуд 85.5 хувийн үнэлгээтэй хэрэгжиж байгаа талаар бодит үр дүн гарч өмнөх үеэс 12.4 хувиар өссөн эерэг үзүүлэлт гарлаа.</p>		
		<p>82. "Хөдөлмөрийн тухай" хууль, "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай" хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж, арга зүйн зөвлөгөө өгч, мэдээ мэдээллээр</p>	<p>2017 онд Тус зөвлөл нь шинээр ашиглалтанд орж үйл ажиллагаа явуулж байгаа Шатахуун түгээх станцуудад "Хөдөлмөрийн тухай" хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>2018 онд Үзлэг шалгалт хийх явцад хөдөлмөрийн гэрээ, дотоод журам, баримт бичгийн боловсруулалт, хөтлөлт хангалтгүй, ХАБЭА-н зааварчилгааг тогтмол өгдөггүй, ХАБЭА-д зарцуулах хөрөнгө төсөвт тусгадаггүй, осол</p>	<p>100</p>	<p>70</p>

		хангаж ажиллах	гэмтэл, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, сургалт зохион байгуулах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зэрэг хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж байсан тул зөвлөгөө мэдээлэл өгч, зөвлөмж хүргүүлж ажилласан.		
29.	1.5.6 Хөдөлмөрийн зах зээлд нийцсэн мэргэжилтэй ажилтанг мэргэжлийн болон давтан сургалтаар 1000-аас доошгүй ажилгүй иргэдийг бэлтгэж, бизнес эрхлэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд нь зориулж хүү багатай, хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна.	83. Мэргэжлийн болон давтан сургалтанд суух иргэдийн судалгааг тодорхойлж, жилд 250-аас доошгүй ажилгүй иргэнийг мэргэжил олгох сургалтанд хамруулах	2017 онд Тариалангийн газрын ашиглалтыг сайжруулах, зах зээлийн эргэлтэнд оруулах, сэргээх, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, бордоог зохистой хэрэглэх зорилт дэвшүүлэн газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх сонирхолтой 140 иргэнийг ногоочны сургалтанд хамруулсан. “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох” хөтөлбөрийн хүрээнд цэцэрлэгийн туслах багш, тогооч, оёдолчны сургалтанд-61 иргэн, “Цогц төгсөлтийн аргачлал төсөл”-ийн хүрээнд үсчин гоо сайхан, мужаан, гутал засварын сургалтанд 35 иргэнийг хамруулж мэргэжлийн үнэмлэх олгосон. Мэргэжил олгох сургалтанд нийт 236 иргэнийг хамруулсанаар төлөвлөгөөний биелэлт 94.4 хувьтай хэрэгжлээ. 2018 онд Газар тариалангийн чиглэлээр 41, Оёдол 20, Барилгын засал чимэглэлээр 18, үсчин 20 мөн аж ахуй эрхлэлтийн сургалтанд 141 иргэн тус тус хамрагдаж төлөвлөгөөний биелэлт 85.2 хувь.	100	70
		84. Сургалтанд хамрагдсан иргэдийн 50-иас доошгүй хувийг байнгын болон түр ажлын байранд зуучлах, МСҮТөвтэй хамтран ажиллах	2017 онд Бүлийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах арга хэмжээнд 36 иргэн хамрагдаж 3,6 га талбайд төмс, хүнсний ногоо тариалсан, ДЗОУБ-ын ӨОНХХөтөлбөрийн санхүүжилтээр 55 иргэн дэлхийн зөнгийн 2,5 га талбайд тариалалт хийж 52,3 тн ургац хураан авсан. Мөн Цогц төгсөлтийн аргачлал төслөөс 35 иргэнд 25 сая төгрөгийн тоног төхөөрөмж олгож нийт 126 иргэнийг ажлын байраар хангаж төлөвлөгөөг 100 хувьтай хэрэгжсэн. 2018 онд Газар тариалангийн чиглэлээр 41, Оёдол 3, үсчин 2 аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамрагдсан иргэдээс 68 иргэн нь төсөл хөтөлбөрт хамрагдаж нийт 114 иргэн ажлын байртай болж төлөвлөгөө 91.2 хувьтай хэрэгжлээ.	100	70



30.	1.5.7 Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд үндэслэн зорилтот бүлгийн өрхүүдийгоновчтой тодорхойлж, тэдэнд үзүүлэх нийгмийн үйлчилгээг чанаржуулж, салбар дундын уялдаа, хамтын ажиллагааг сайжруулна.	85. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд өрх, иргэдийг хамруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг оновчтой хүргэх	"Орлогыг орлуулан тооцох аргачлал"-аар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны ажил 2017 оны 03 дугаар сарын 31-нээс 04 дүгээр сарын 09-нийг дуустал орон даяар зохион байгуулагдсан. Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны өрхөөс мэдээлэл цуглуулах өрхийн жагсаалт бэлтгэх үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Сумын хэмжээнд нийт 6906 өрх судлахаас 6473 өрх буюу нийт өрхийн 93.7 хувь нь судалгаанд хамрагдлаа. Үүнээс 409 өрх судалгаанд хамрагдаагүй, 24 өрх татгалзсан. 11 сарын байдлаар 240.3176 онооноос доогуур оноотой 226 өрхийн 1404 иргэн хүнс тэжээлийн үйлчилгээнд хамрагдаж 156.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон. 2017 онд хүүхдийн мөнгийг амьжиргааны түвшин харгалзахгүйгээр бүх хүүхдэд олгосон. Арвайхээр сумын хэмжээнд өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй нийт 6795 өрх байна. Үүнээс доод түвшин 1241, харьцангуй бага хэрэглээтэй 1907, дундаж бүлгийн 2624, дунджаас дээгүүр 799, илүү өндөр хэрэглээтэй 224 өрх байна. Өрх иргэний өргөдөлийг цаг тухайд нь шийдвэрлэж өрхийн мэдээллийн нэгдсэн санг тогтмол баяжуулж ажиллаж байна.	100	70
31.	1.5.8 Өрхийн мэдээллийн нэгдсэн сан /ӨМНС/-гийн талаар холбогдох төрийн байгууллагуудыг мэдээллээр хангах, олон салбарт ашиглах боломжийг бүрдүүлнэ.	86. Өрхийн мэдээллийн нэгдсэн санг нийгмийн үйлчилгээнд ашиглаж хэвших	2017 онд ӨМНСанд бүртгэлтэй болон өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдсан өрхүүдийг оноогоор нь эрэмбэлэн 360 буюу түүнээс доош оноотой өрхийг амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхөд тооцож шүүхийн шийдвэрийн төлбөр, сурах бичгийн хөнгөлөлт, хүүхдийн мөнгө, хүнс тэжээлийн үйлчилгээ зэргийг үзүүлж хэвшсэн. 2018 онд ӨМНСанд бүртгэлтэй болон өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдсан өрхүүдийг оноогоор нь эрэмбэлэн 409 буюу түүнээс доош оноотой өрхийг амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхөд тооцож шүүхийн шийдвэрийн төлбөр, сурах бичгийн хөнгөлөлт, хүүхдийн мөнгө, хүнс тэжээлийн үйлчилгээ, эрүүл мэндийн даатгал зэргийг үзүүлж хэвшсэн. 2018 оны 11 дүгээр сарын байдлаар	100	70

			амьжиргааны түвшинтэйгээ санал нийлэхгүй мөн огт судалгаанд хамрагдаагүй, өрх тусгаарласан гэх мэт шалтгаанаар дахин үнэлгээнд хамрагдах хүсэлтэй иргэдийг цаг тухайд нь хамруулж өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааг 5 удаа зохион байгуулж 1060 өрхийг судласан байна.		
32.	1.5.9 Залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эрх нь зөрчигдсэн хүүхэд, эмэгтэйчүүд, хорих ангиас суллагдсан болон архины хамааралтай иргэд зэрэг зорилтот бүлгүүдэд чиглэсэн төрөл бүрийн сургалт, мэдээлэл, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулж, олон улсын байгууллага, хувийн хэвшил, иргэд, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтарч ажиллана.	87. Зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд суурилан сургалт, мэдээлэл, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах	Сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөх чиглэлээр зорилтот өрхөөс судалгааг авхад архины хамааралтай хүний тоо 9, гэр орноосоо дайжих зуршилтай хүний тоо 3, гэр бүлийн тайван байдлыг алдагдуулах зуршилтай хүний тоо 6 гэсэн судалгаа гарсан байна. Эдгээр өрхийн иргэдийг Гэр бүл сайн сайхны нийгэмлэг Өвөрхангай аймагдахьсалбар,Оюуны цэнэг гэр бүл хүний хөгжлийн академитай хамтран ХХҮГазраас сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөх чиглэлийн сургалтанд хамруулсан. Зорилтот өрхийн иргэдийн нийгэмд хандах хандлагыг өөрчлөх зорилгоор төрөл бүрийн сургалт арга хэмжээнд өргөн хүрээтэйгээр хамруулж ажиллаа.	70	40
33.		88. Орон нутагт нийгмийн халамжийн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллага, хувийн хэвшил, иргэд, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодыг нэгдсэн арга зүйгээр ханган ажиллах	"Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2018 онд 110 өрхийн 583 иргэн сонгогдсон эдгээр өрхийн иргэдийг өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд бүрэн хамруулсан болно. Зорилтот өрхийн 22 иргэнийг В,С вирусын шинжилгээ болон эхо үзлэг шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулж, бэлгийн замын халдварт өвчин болон гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл зөвлөгөө өгсөн. 2-5 насны 101 хүүхдийн судалгаа гарсан үүнээс СӨБ-д 97 хүүхэд хамрагдаж байна.Транскапитал" банк бус санхүүгийн байгууллагын хандиваар зорилтот өрхийнхөө 30 хүүхдэд нийт 1 сая төгрөгийн иж бүрэн хичээлийн хэрэглэл олгосон. Хүүхдийн хөгжил-хамгаалал"-ын жилийн ажлын хүрээнд Арвайхээр сумын "Молор" худалдааны төв сайн үйлсийн аянд нэгдэж, зорилтот бүлгийн 125 хүүхдүүдэд 1 сая төгрөгийнүнэ бүхий бичиг хэрэг, ариун цэврийн болон хүнсний бүтээгдэхүүний дэмжлэг тусламж үзүүллээ. "Хүүхдийн хөгжил, хамгаалал"-ын жилийн хүрээнд	100	70

			<p>ХХҮГазраас "Дулаан сэтгэл" сайн үйлсийн аяныг сум тус бүрт зохион байгуулж байгаатай холбогдуулан Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулж буй "Сод-ээл" хүнсний дэргүүр, болон "Их-Өшгөг" худалдааны төвтэй хамтран дулаан хувцасны тусламжийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай зорилтот өрхийн 3 хүүдэд нийт 200000 төгрөгийн хувцас олгож тус аянд нэгдсэн. Сургуулиас жил бүр хэрэгжүүлдэг сурах бичгийн хөнгөлөлтөд 55 өрхийн 55 хүүхэд хамрагдсан байна.</p> <p>ОУ-ын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хөтөлбөрт хамрагдсан өрхийн эмэгтэйчүүдийн дунд СҮҮН СЭТГЭЛ өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулж, 11-н багийн 110 ээжийг хамруулан амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээг 300000 /гурван зуун мянга/ төгрөгийг орон нутгийн нөөц хөрөнгөөс санхүүжүүлсэн.</p> <p>Олон улсын гэр бүлийн өдрийг угтан хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийн дунд спортын өдөрлөгийн арга хэмжээ 3-н төрлөөр амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээнд нийт 90 гаран иргэнийг хамруулсан, арга хэмжээг Өв зар-зарын узель250000/хоёр зуун тавин мянга/ төгрөгөөр санхүүжүүлсэн болно.</p>		
34.	1.5.10 "Ахмадын өргөө"-г шинээрбарьж, ахмад настнуудыг нийгмийн амьдралд идэвхитэй оролцуулах, тэдний амьдралын туршлага, мэдлэг, ур чадварыг залуу үеийнхэнд өвлүүлэх ажлыг хэрэгжүүлж, үйлажиллагааг өргөжүүлнэ.	89. Ахмадын өргөөг шинээр барьж, ашиглалтанд оруулах	Тус сумын 5-р багийн нутаг дэвсгэрт зорилтот жилийн хүрээнд орон нутгийн төсвийн 865 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ахмадын өргөөг Ган нэгдэл ХХК барьж, 2017 оны 10 дугаар сард ашиглалтанд орууллаа.	100	100
		90. Мэргэжлийн өндөр ур чадвар, мэдлэг туршлагатай ахмадуудаар үндэсний өв соёл, монгол уламжлал, ёс зан заншлын талаар хүүхэд, залуучуудад сургалт, мэдээллийн ажил зохион байгуулах	ЕБСургууль, МСҮТөвийн сурагчдад эрүүл аж төрөх, байгаль дэлхийгээ хайрлах чиглэлээр 4 удаа сургалт мэдээллийн ажлыг уулзалт ярилцлага хэлбэрээр зохион байгуулж, давхардсан тоогоор 190 хүн хамрагдсан. Сурагчдад Анунгоо эрүүл мэндийн зөвлөгөө өгөх төвийн эмч нар охид хөвгүүд, өсвөр насныханд зориулсан эрүүл мэндийн коктейлээр үйлчилж зөвлөгөө өглөө. <p>Сумын "Ахмадаа дээдлэх" зорилтот жилийн ажлын хүрээнд мэргэжлийн өндөр ур чадвар, мэдлэг туршлагатай ахмадууд болон тэргүүний залуучуудаар монгол</p>	100	70

			уламжлал, зан заншлаас суралцах болон өсвөр насныхны үе тэнгийн манлайлал, ур чадварыг хөгжүүлэх, ахмад залуу үеийн төлөөлөл өөрийн арга туршлагаас хуваалцах чиглэлээр “Удирдагч манлайлагч сурагчдын сургалт”-ыг 10 дугаар сарын 14-ний өдөр багийн Нэгдсэн төвд зохион байгуулж, ЕБ-ны 5 сургуулийн 87 сурагч хамрагдлаа. Сургалтаар үе тэнгийнхний манлайллын тухай ойлголт өгөх, хүүхдийн хөгжил төлөвшилд монгол уламжлал, зан заншил хэрхэн нөлөөлдөг давуу талуудаас суралцах, өөрөө үлгэрлэн манлайлах ур чадваруудад суралцах, охид хөвгүүд эрүүл мэнддээ хэрхэн анхаарах, “Хүүхэд насны галт тэрэг” оролцогчидтой ажил, амьдралын туршлагаа хуваалцах ярилцлага хийж, ахмад багш Д.Отгонбаяр оролцсон.		
<b>Салбарын дундаж үнэлгээ</b>				<b>98.1</b>	<b>64.3</b>
<b>Нэгдүгээр бүлгийн дүн</b>				<b>92.5</b>	<b>78.0</b>
<b>Хоёрдугаар бүлэг. Хүнс хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн бодлого зохицуулалт</b>					
<b>2.1 Жижиг дунд үйлдвэр, хувийн хэвшлийг дэмжих</b>					
35.	2.1.1 Мах боловсруулах үйлдвэрийн менежментийг өөр субъектэд шилжүүлэх замаар ашиглалтанд оруулан түүнийг түшиглэн малын дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулах санал санаачлагыг дэмжинэ.	91. Мах боловсруулах үйлдвэрлэлийн менежментыг өөр субъектэд шилжүүлж байнгын үйл ажиллагаатай болгох	Төрийн банкны барьцаанд байсан мал нядалгааны үйлдвэрийг Засгийн Газраас 3.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн өмчлөлд шилжүүлж, “ӨВ мийт продактс” ОНӨХХК-ийг үүсгэн байгуулсан. Уг үйлдвэр БНХАУ-д мах экспортлох эрх бүхий “Ulangab Izawa trading” компанитай 1500 тн үхрийн мах, 100 тн хонины мах бэлтгэн нийлүүлэх гэрээ байгуулж, энэ онд 666.1 тн мах бэлтгээд байна. Тус үйлдвэрийг түшиглэн дулааны аргаар мах боловсруулах “Дэлхийн хүнс” махны үйлдвэр байгуулагдан тоног төхөөрөмжөө суурилуулж байна. Мөн Арвайхээр суманд “Дээжийн өргөө” ХХК хувийн хөрөнгө оруулалтаар дулааны аргаар мах боловсруулах үйлдвэр байгуулан, үйл ажиллагаа эхлүүлж 20 гаруй иргэнийг ажлын байраар ханган, 8.5 тн мах бэлтгээд байна.	100	100

		92. Боловсруулах үйлдвэрлэлийг түшиглэсэн малын дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулах санал санаачлагыг дэмжих	“ӨВ ЭКО МИЙТ” ХХК-ны мах бэлтгэлийн ажилтай танилцсан. Тус компани нь 2018 онд дэргэдээ дайвар бүтээгдэхүүний цех ажиллуулж, дайвар бүтээгдэхүүнийг нэр төрлөөр нь ангилж 2.5 тн бүтээгдэхүүнийг Улаанбаатар хотод нийлүүлж байна. Малчдад мал сүргийнхээ эр сувай мал болон дундаас доош тарга хүчтэй малынхаа 10-15 хувийг эдийн засгийн эргэлтэнд оруулах саналыг санамж бичигт сануулж “ӨВ ЭКО МИЙТ” мал мах авах үнийг мэдээлж ажиллаа.	100	70
36.	2.1.2 Сүү, сүүн бүтээгдэхүүний томоохон үйлдвэрийг байгуулах, үйл ажиллагаа явуулж байгаа цех, өрхийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	93. Сүү, сүүн бүтээгдэхүүний боловсруулах шинээр үйлдвэр байгуулах боломж, нөхцлийг судлан шийдвэрлэх	2017 онд СХСангаас сүү, цагаан идээний зориулалтаар 2 иргэнд 8 сая төгрөгийн зээл, аймгийн ЖДҮДСангаас 1 аж ахуйн нэгжид 90 сая төгрөгийн зээл олгож үйл ажиллагааг өргөжүүлсэн. 2018 онд сумын хэмжээнд сүү цагаан идээний 7 цех үйл ажиллагаа явуулж, 4 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн бүтээгдэхүүнээ ЕБС, СӨББайгууллагын үдийн цайнд 40.5 тн, хүнсний дэлгүүр, хүнсний захар дамжуулан 25.7 тонныг иргэдэд нийлүүлсэн байна.	100	70
		94. Хэрэгжих боломжтой эдийн засгийн тооцоо судалгаа нь боловсруулагдсан төслүүдийг хөнгөлөлттэй зээлээр дэмжих	Сүү цагаан идээний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор СХСангийн санхүүжилтээр 8 иргэн 42 сая төгрөгийн санхүүжилтэд хамрагдаад байна. ХЭДСангаас 10 иргэнд 34 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна.	100	70
37.	2.1.3 Хүнсний ногоо даршлах, савлах үйлдвэрүүдийг орчин үеийн техник технологид суурилан бий болгож, өрх, иргэдийг ажлын байраар хангана.	95. Хүнсний ногоо даршлах, савлах үйлдвэрүүдийг шинээр байгуулах боломж, нөхцлийг судлах	Бизнесийн шинэ санаа нэвтрүүлэх ТББайгууллага Япон улсын Хоккайдо мужын Такикава хоттой хамтран “Өвсний үндэс” төслийг хэрэгжүүлж ЖАЙКА-ийн 26 сая төгрөгийн санхүүжилтээр “Газар тариалангийн загвар аж ахуйг” байгуулах зорилгоор нарлаг хүлэмж 2, гүний худаг 1-ийг шинээр барин үйл ажиллагаа явуулж байна. Тус төслийн хүрээнд 2 иргэнийг 1 сарын хугацаатай хүнсний ногоо боловсруулах сургалтад хамруулсаны үр дүнд “Өвөрхангай түншлэл-2018” үзэсгэлэн худалдаанд “луувангийн чанамал” бүтээгдэхүүн хийж үзэсгэлэнд оролцсон.	100	70

			<p>Төслийн хүрээнд хүнсний ногоо боловсруулах анхан шатны сургалтуудыг шат дараатай хийж байгаа бөгөөд бүлгийн зохион байгуулалтад орж, хүнсний ногоог хаягдалгүйгээр ашиглах, боловсруулах жижиг цех байгуулан хөдөлмөрөө хорших төлөвлөгөөтэй ажиллаж байна.</p> <p>СХСангийн санхүүжилтээр хүлэмж барих, хүнсний ногоо боловсруулах зориулалтаар 3 аж ахуйн нэгжид 35 сая төгрөгийн зээл олгох шийдвэр гаргаад байна.</p>		
38.	2.1.4 Арьс, шир, ээрмэл, сүлжмэл, нэхмэл, ажлын хувцасны болон төрөл бүрийн оёдлын үйлдвэрлэлийг санаачлагыг дэмжин ажиллана.	96. Арьс, шир, ээрмэл, сүлжмэл, нэхмэл, ажлын хувцасны болон төрөл бүрийн оёдлын үйлдвэрлэлээ өргөжүүлэх болон шинээр байгуулах эдийн засгийн тооцоо судалгаа нь боловсруулагдсан төслүүдийг хөнгөлөлттэй зээлээр дэмжих	<p>2018 онд “Ноос ирээдүй ХХК” нь самнасан ноосоороо хөнжил, гудас, аяны ком, өрх зэрэг цэвэр ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэх оёдлын цех байгуулан, бүтээгдэхүүнээрээ аймаг, бүсийн үзэсгэлэн худалдаанд оролцож “ӨВ-Түншлэл-2017” үзэсгэлэн худалдааны шилдэгийн шилдэг “Гранпри” шагнал, 2018 оны нутгын брэнд бүтээгдэхүүнээр “ноосон эдлэл” тус тус шалгараад байна. Цаашид утас ээрэх, сүлжих үйлдвэр байгуулахаар зураг төсөв боловсруулж байна.</p> <p>Батзүү ХХК-ны хөрөнгө оруулалтаар “Топ зүү” оёдлын үйлдвэр байгуулагдан оёдлын мэргэжилтэй 40 иргэнийг ажлын байраар хангаж 3500 орчим хүүхдийн форум үйлдвэрлэж 190 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.</p> <p>Арвайхээр сумын “Арвин шунхлай” хоршоо нь Австралийн элчин сайдын яамны 36.9 сая төгрөгийн санхүүжилт бүхий “Арьс шир боловсруулах” анхан шатны цех байгуулах төсөлд хамрагдан, сард 700-800 ширхэг арьс, нэхий болон ишиг, хурганы арьс боловсруулах хүчин чадалтай цехийг ашиглалтад орууллаа. Уг цех үйл ажиллагаагаа эхлүүлснээр арьс, нэхийг боловсруулж, нэмүү өртөг шингээн зах зээлд нийлүүлээд байна.</p> <p>“Өв сорхангай” ХХК нь арьс, шир боловсруулах үйлдвэр байгуулахаар ХХААХҮЯамны “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-гаас 700.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлэнд хамрагдаж үйлдвэрийн барилгын ажил 30%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.</p> <p>Мөн СХСангийн санхүүжилтээр 2017-2018 онд “Арьс шир боловсруулах” чиглэлээр 2 иргэнд 10 сая төгрөгийн</p>	100	

			хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэн үйл ажиллагааг өргөжүүлсэн.		
39.	2.1.5 “Арвайхээрт үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг тогтмол зохион байгуулж, нутгийн брэнд бүтээгдэхүүнийг баталгаажуулан жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх, зах зээлд таниулахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.	97. “Арвайхээрт үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулж туршлага солилцох, түншлэх, борлуулалтын сүлжээг нэмэгдүүлэх	<p>2017 онд “Арвайхээрт үйлдвэрлэв” Алтан намар үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, тус сумын 4 хоршоо, 5 иргэн оролцож, 585000 төгрөгийн борлуулалт хийсэн.</p> <p>Нутгийн брэнд бүтээгдэхүүн гаргах, танилцуулах ажлын хүрээнд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч иргэдийн хамруулан “Цагаан сар-2017” үзэсгэлэн худалдааг аймгийн ХАҮТанхимтай хамтран зохион байгуулж, үзэсгэлэн худалдаанд Өвөрхангай аймгийн 13 сум, гадны 5 аймгийн 86 иргэн аж ахуйн нэгж оролцож 3 өдрийн худалдаагаар 63.2 сая төгрөгийн борлуулалт хийлээ.</p> <p>Ахмадаа дэмжих зорилтот жилийн ажлын хүрээнд “Баялаг бүтээгч ахмадуудын хобби” үзэсгэлэн худалдааг зохион байгуулав. Тус арга хэмжээнд 11 багийн 85 ахмад настан 16 төрлийн бүтээлээр оролцсон. “Ахмадуудын хобби үзэсгэлэн худалдаа”-нд орон нутгийн төсвөөс 311.500 төгрөгийн санхүүжилт гаргаж шилдэг бүтээлүүдийг өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагналаа.</p> <p>“Намрын ногоон өдрүүд-2017” үзэсгэлэн худалдаанд тус сумын 19 иргэн, ААНэгж үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээрээ оролцож 3 өдрийн хугацаанд 10.8 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Ундрах баян ирээдүй хоршоо “Хамгаалагдсан хөрснөөс хамгийн их бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн” хоршоогоор, Бизнесийн шинэ санаа нэвтрүүлэх ТББайгууллага нь шинэ технологи нэвтрүүлсэн ААНэгжээр, Хос хангай фүүд ХХК “хүнсний шилдэг” бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, Ноос ирээдүй ХХК “шилдгийн шилдэг гран при”-аар тус тус шалгарлаа.</p> <p>2018 онд Арвайхээр суманд зохион байгуулагдсан “Цагаан сар-2018” үзэсгэлэн худалдаанд ХАҮТанхим, ХХААГазартай хамтран зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд сумаас 16 иргэн, 4 аж ахуйн нэгж, 2 хоршоо нийт 22 иргэн, аж ахуйн нэгж оролцож 4 өдрийн хугацаанд 23.500.000 төгрөгийн борлуулалт хийгдлээ.</p> <p>Багийн нэгдсэн өдөрлөг арга хэмжээтэй хамтатган сумын “Намрын өдрүүд” үзэсгэлэн худалдааг зохион байгуулав.</p>	100	70

			<p>Тус үзэсгэлэн худалдаанд 5 иргэн, аж ахуйн нэгж 12 төрлийн төмс, хүнсний ногоо, даршилсан бүтээгдэхүүнээр оролцож 370.000 төгрөгийн борлуулалт хийсэн. Тус үзэсгэлэн худалдааны “Хамгийн олон нэр төрөл”-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээр 9-р багийн тариаланч С.Ганчиндорж, “Шилдэг сав баглаа боодолтой” бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээр 9-р багийн тариаланч З.Угтахбаяр тус тус шалгарлаа.</p> <p>Өвөрхангай түншлэл-2018 үзэсгэлэн худалдаанд сумын 33 иргэн, ААНэгж үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээрээ оролцож 3 өдрийн хугацаанд 17.162.000 төгрөгийн борлуулалт хийсэн. Монлайн компаний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн шилдэг оёмол бүтээгдэхүүн, 13 дугаар багийн иргэн Уранчимэг шилдэг ноосон эдлэлийн бүтээгдэхүүн, П.Гандолгор шилдэг шүлжмэл бүтээгдэхүүнээр тус тус шалгарлаа.</p>		
		98. Нутгийн брэнд бүтээгдэхүүнийг баталгаажуулах ажлыг зохион байгуулж, зах зээлд таниулахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх	Аймгийн засаг даргын 2018 оны А/481 дугаар захирамжаар “Нутгын брэнд” бүтээгдэхүүн шалгаруулах удирдамжын дагуу нийт 12 иргэн, ААНэгжийн материалыг бүрдүүлэн хүргүүлснээс Дэлгэрэх хүнс ХХК-ны бэлгийн багц, Хосхангай фүүд ХХК-ны үйлдвэрлэсэн “давхар утлагт” хиам, Өв санаа ХХК-ны “еэвэнгийн багц”, Одод цехийн үйлдвэрлэсэн “одод ааруул”, Ноос ирээдүй ХХК-ны үйлдвэрлэсэн “ноосон эдлэл”, Л.Батсүхийн үйлдвэрлэсэн эмээлийн “гөлөм”, н.Гантулгын үйлдвэрлэсэн “сийлбэртэй гар урлал”, н.Ууганбаатарын үйлдвэрлэсэн “чулуун гар урлал” зэрэг 8 нэр төрлийн бүтээгдэхүүн “Аймгийн брэнд” бүтээгдэхүүнээр шалгараад байна.	100	70
		99. Худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан үзэсгэлэнгийн павилонтой болох	“Намрын ногоон өдрүүд”, “Үзэсгэлэн худалдаа” болон бусад арга хэмжээнүүдийг зохион байгуулж, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг бага түрээстэйгээр борлуулахад нь ХАУТанхим, ХХААГазраас 30 ширхэг асарыг тухай бүр авч хэрэглүүлэн үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдийн ажиллах нөхцөлийг сайжруулсан.	100	70
40.	2.1.6 Ашиглагдахгүй байгаа барилга объектуудыг бизнес	100. Ашиглагдахгүй байгаа барилга объектын судалгааг	2017 онд Нарны дөш, Түшиг дөлгөөн, Уян сэтгэл, Энхийн хүрд өрхийн эрүүл мэндийн төвүүд шинэ байртай болсноос үүдэн хуучин байрууд ашиглагдахгүй байгааг аймгийн	100	70



	хөгжлийн төвийн байр болгож төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эдийн засгийн эргэлтэнд оруулахыг судлан шийдвэрлүүлнэ.	гаргах	ИТХурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор “Энхийн хүрд” ӨЭМТөвийн байрыг 3-р багийн төв, “Уян сэтгэл” ӨЭМТөвийн байрыг 3-р цэцэрлэгт тус тус шилжүүлж, “Түшиг дөлгөөн” ӨЭМТөвийн байрыг 4-р баг, “Нарны дөш” ӨЭМТөвийн байрыг 5-р багт хариуцуулан гэрээгээр ашиглуулахаар тус тус шийдвэрлэсэн.		
		101. Судалгаанд үндэслэн бизнес хөгжлийн төвийн байр болгож, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эдийн засгийн эргэлтэнд оруулах	2018 онд Хоршоодын үйл ажиллагааг дэмжих, үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулан зуучлах төв байгуулах зорилгоор 5-р багийн нутаг дэвсгэрт байрлах ХАА-н хоршоодын холбооны байрыг ашиглалтанд оруулан Монгол ногоо хөтөлбөртэй хамтран хүнсний ногооны үр борлуулах шууд худалдааны цэг мөн “Өрхийн тариалан бизнес хөгжил” төрийн бус байгууллагын салбар оффис байрлан төсөлд хамрагдсан хоршоодыг чадавхижуулан ажиллаж байна. Өрхийн эмнэлгийн хуучин барилгыг ноосон болон оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн чиглэлээр ажиллуулахаар засварлаж байна.	100	70
41.	2.1.7 Тус суманд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эд, барилгын материалын агуулахын болон бөөний худалдааны төв байгуулна.	102. Хотын баруун хэсэгт байршилтай түүхий эдийн захын зориулалтаар олгосон газруудын үйл ажиллагааг тогтмолжуулах	Мал болон малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг аймгийн төвөөс гаргаж, нэг цэгт төвлөрүүлэх ажлыг 2016 оноос эхэлж, газрыг олгосон байгаа. Энэ ажил тодорхой үр дүнд хүрсэн. Одоогийн байдлаар мал, амьтны гаралтай түүхий эдийн худалдаа эрхлэх тогтоосон бүсэд 42 аж ахуй нэгж, иргэн газар өмчлөх хүсэлт тавин газар авч худалдаа эрхлэх нөхцөл байдал хангагдан тохижиж үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн амьд малын зах болон бойны газар ажиллаж байна	100	70
		103. Стандартын шаардлагад нийцсэн худалдааны төвийн төслийн санаачлага гаргасан аж ахуй нэгж, байгууллагыг дэмжих замаар шийдвэрлэх	Тус сумын 5-р багийн нутаг дэвсгэрт MSC групп 450 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бөөний худалдаа, бүтээгдэхүүний агуулах баригдан ашиглалтад орсон үйл ажиллагаа явуулж байна. 2018 онд Арвин худалдааны төв нь бүрэн автоматжсан хүнсний ногооны төрөлжсөн зоорь, хүнсний ногооны бөөний худалдааны төв байгуулах зорилгоор ХХААХҮЯамны ЖДҮйлдвэрийг дэмжих сангийн 690 сая төгрөгийн зээлд хамрагдан хүнсний ногооны бөөний төв болон 300 тн-ны багтаамжтай төмс, хүнсний ногооны зоорь	100	70

			байгуулан ашиглалтанд ороод байна. “Номин” сүлжээ дэлгүүр байгуулах санал, санаачилгыг дэмжин инженерийн шугам, сүлжээнд холбогдох боломжтой газрын асуудлыг шийдвэрлэсэн. “Сансар худалдааны төв” байгуулах санал ирээд дэмжиж шийдвэрлэлтийн шатандаа байна.		
<b>Салбарын дундаж үнэлгээ</b>				<b>100</b>	<b>72,3</b>
<b>2.2 Хүнс, хөдөө аж ахуй</b>					
42.	2.2.1 Мал, амьтны гаралтай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээг дэмжин, үйлчилгээний чанарыг сайжруулах замаар мал, амьтны гоц халдварт өвчингүй тайван байдлаа хадгална.	104. Мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилганд бүрэн хамруулах, хяналт тавих	<p>Сумын Засаг даргын 2017 оны А/46 дугаар захирамжийн дагуу 4-10 дугаар сард мал сүрэгт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга вакцинцуулалтын ажлыг ДС Дөхөм, Баян сүргийн буян, Арвайн талын буян, Үржин дэвших зэрэг хувийн мал эмнэлэг хийж гүйцэтгэсэн.</p> <p>2018 онд Мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулах, мал эмнэлэг, ариун цэвэр халдваргүйжүүлэлтийн сарын аяны ажлыг зохион байгуулах тухай 2018 оны 4 дүгээр сарын А/65 дугаар захирамжаар мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулах арга хэмжээг 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын 20-нд, мал эмнэлэг ариун цэвэр халдваргүйжүүлэлтийн сарын аяны ажлыг 2018 оны 5 дугаар сарын 01-ны өдрөөс 6 дугаар сарын 01-ны хооронд зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 79.3 мянган толгой малд 10 нэр төрлийн 501.5 литер эм бодис, вакциныг төлөвлөгөөний дагуу 79.3 мянган толгой малыг бүрэн хамруулж тарилга, тулгалтын ажлыг 100 хувь хийж гүйцэтгэсэн. Хувийн хэвшлийн 4 мал эмнэлгүүд улсын төсвөөс нийт 19.9 сая төгрөгийн санхүүжилт авч ажилласан.</p> <p>Энэ жил тус сумын Дэлгэрэхийн 3 дугаар багийн “Түгий овооны ар”, Өлзийтийн 4 дүгээр багийн 36 дугаар гудамж, Олон худгийн энгэр, Талын худаг гэдэг газруудад 11 малчин өрхийн малд мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин илэрч Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторийн 2018 оны 3 дугаар сарын 10-542, 18-575, 15-</p>	100	70

			59 тоот шинжилгээний дүнгээр тогтоогдсон тул Арвайхээр сумын Засаг даргын 2018 оны а/30 “Хорио цээрийн дэглэм тогтоог тухай” дугаар захирамж гарган, голомт болон сэжигтэй бүсэд Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2014 оны а/93 тоот тушаалын дагуу мал, амьтны шүлхий өвчинтэй тэмцэх зааврыг хангаж ажилласны үр дүнд мал, амьтанд өвчний шинж тэмдэг илрээгүй тул сумын Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн а/61 дугаарт захирамжаар хорио цээрийг цуцлан ажиллаа.		
		105. Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулж, 2 багийн дунд 1 малын эмч ажиллуулах	Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулах, мал эмнэлэг, ариун цэвэр халдваргүйжүүлэлтийн ажлуудыг ДС Дөхөм, Баян сүргийн буян, Арвайн талын буян, Үржин дэвших зэрэг хувийн мал эмнэлгүүдтэй гэрээ хийн ажиллаж байна. Мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 79.4 мянган мал хамруулахаас бүрэн хамруулж гүйцэтгэл нь 100 хувьтай. Улсын төсвөөс 18 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаа явуулсан. Энэ онд тус суманд мал, амьтны гоц халдварт өвчингүй тайван байдлаа хадгалсан.	100	70
		106. Мал эмнэлгүүдийг стандартын шаардлага хангасан ажлын байртай болгох	Хувийн хэвшлийн 4 мал эмнэлгээс ДСДөхөм, Үржин дэвших ББНөхөрлөл өөрийн хөрөнгөөр ажлын байр бий болгон үйл ажиллагаа эрхэлж байна.	100	70
		107. Мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулахад зөөврийн 4 хашаа, Онгийн голийн хуучин гүүрийн зүүн талын мал угаах ванн засварлах	“Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангуулах, бог малыг гадна шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх мөн мал эмнэлгийн ажил үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 11 сая төгрөгийн үнэтэй мал угаалгын зөөврийн тоног төхөөрөмжийг ХХААХҮ-ийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/132 дугаар тушаалын дагуу хувиарлагдсан. Үржин дэвших хоршоо хувийн хэвшлийн мал эмнэлэг нь өөрийн зардлаар 5 сая төгрөгийн зөөврийн угаалгын хашаа авч малд угаалга хийж байна.	100	70

43.	2.2.2 Фермүүдийг хөгжүүлэхтэй холбогдуулан тэжээл үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөнгөвчлөхөд чиглэсэн бага оврын техник технологи нэвтрүүлэх, өвс, тэжээлийн нөөцийн сан, тэжээлийн цех байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	108. Мал хамгаалах санд байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд өвс тэжээлийн нөөц санд жил бүр 3.0саяаас доошгүй төгрөгийн нөөц бүрдүүлэх	Сумын дүнгээр 2017 онд малчид 1014 тн байгалийн хадлан, гар тэжээл 252 тн, хужир 99 тн-ийг тус тус бэлтгэсэн.Сумын нөөцөд өвс тэжээл нэмж бэлтгэх зорилгоор сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон ААНэгж байгууллагын ажилтан бүрээс 3000 төгрөгөөр тооцож, Мал хамгаалах санд 12.4 сая төгрөг нэмж төвлөрүүлсэн. Мөн малчдаас 1000 боодол өвсний захиалга авч, хөнгөлөлттэй үнээр Сүхбаатар аймгийн Асгат сумаас өвс татаж, малчдад хүргэх ажлыг зохион байгууллаа. Мөн иргэд хувийн хэвшлийн 2 аж ахуйн нэгж 30 тн өвс татан авч худалдаалж байна. 2018 онд сумын хэмжээнд байгалийн хадлан 1380 тн, гар тэжээл 660 тн, хужир шүү 320 тн, сумын аюулгүй нөөцөд 1600 боодол өвс тус тус бэлтгэсэн.	100	70
		109. Тэжээл үйлдвэрлэлд шинэ техник технологи нэвтрүүлэхэд зуучлах	ХХААХҮЯамнаас “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Дунд оврын трактор” техник дундын үйлчилгээний зориулалтаар олгосныг П.Ганбаатартай эзэмшүүлэх гэрээ байгуулан 55 өрхийн 80 га-д ургац хураалтад ажилсан байна. Малчдын хашаа саравч барих угсрах ажлыг хөнгөвчилөх үүднээс 2017 онд сум хөгжүүлэх сангаас иргэн Х.Дамбадаржаагийн “Угсармал хашаа” төсөлд 4 сая төгрөгийн зээл олгож дэмжлэг үзүүллээ.2018-2019 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд малчид 660 тн гар тэжээл бэлтгэсэн.	70	40
44.	2.2.3 Мах, сүүний үйлдвэрийн үйл ажиллагааг эрчимжүүлж, өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн болон туслах аж ахуй байгуулах санал санаачилгыг дэмжиж, дотоодын хэрэгцээний 90 хувийг хангана.	110. Өндөр ашиг шимт мах сүүний аж ахуйг дэмжин хөгжүүлж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх	2017 онд 52 иргэн аж ахуйн 1.2 мянган эрчимжсэн болон хагас эрчимжсэн үхэр өсгөн үржүүлж 427 тугал бойжуулж, 14.0 мянган литр сүү сааж, дотоодын хэрэгцээний 80 хувийг хангалаа. 2017 оны мал тооллогын дүнгээр цэвэр үүлдрийн, эрлийз үхэр 960 /алатау, хар тарлан, казакын цагаан толгойт, Сэлэнгэ, семминталь/ тооллогдсон нь малчид малынхаа ашиг шимд сүү-махны гарцад анхааран мал сүргээ өсгөн үржүүлж байна. 2018 онд үхрийн эрчимжсэн аж ахуйг дэмжих зорилгоор сум хөгжүүлэх сангаас 6 иргэн 35 сая төгрөг зээл олгосон. Цаашдаа үхэр сүргийн эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх өндөр ашиг шимтэй хосломол чиглэлийн	100	70

			үхрийн аж ахуй хөгжүүлэх бодлого баримтлаж байна.		
		111. Туслах аж ахуй байгуулах санал санаачилгыг бүх талаар дэмжих	Сумаас туслах аж ахуйг хөгжүүлэх ажлыг бодлогоор дэмжиж 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийт 4 га газрыг олгохоор баталсан. 2017 оны 5 дугаар сараас эхлэн 6 дугаар багийн иргэн Ц.Төмөрбаатар 205 өндөглөгч авчран өсгөн үржүүлж, 15.0 мянга гаруй өндөг үйлдвэрлэсэн. 2018 онд 2000 өндөглөгчтэй тахианы аж ахуй байгуулахад зориулан Дайргын голд 1 га газар олгож, “Сум хөгжүүлэх сан”-гаас 15.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлж тахианы байр баригдаж дуусаад байна.	100	70
45.	2.2.4 Цөөн малтай, мал маллах сонирхолтой малчин өрх, залуу гэр бүлүүдийг төсөл хөтөлбөрт хамруулан малчдын залуу халааг бэлтгэх зорилгоор Малчдын чуулга уулзалтыг 2 жил тутам зохион байгуулж, малчдыг нийгмийн болон эрүүл мэндийн сайн дурын даатгалд хамруулна.	112. Залуу малчдыг малжуулах төсөлд хамруулах	2017 онд малжуулах төсөлд 7 малчинд 134 бог мал олгов. Үүнийг 2012 оны сүүлийн, 2013 оны 2 дахь, 2014 оны эхний төлөлтөөс эргүүлэн төлсөн малаас олгосон. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2018 онд 2 залуу малчин өрхийг хамруулан 9 сая төгрөгийн мал олгосон.	100	70
		113. Сумын Залуу малчдын чуулга уулзалтыг 2 жил тутамд зохион байгуулах	2018 оны 10 дугаар сарын 03-04ны өдрүүдэд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээнээс зохион байгуулсан залуу малчдын туршлага судлах уулзалт, зөвлөгөөнд 4 залуу малчдыг гэр бүлийн хамт оролцуулав. “ЧИ-ТА” төсөлтэй хамтран Арвайхээр сумын малчдын зөвлөгөөнийг хамтран зохион байгуулахаар төлөвлөж байна.	100	70
		114. Малчдыг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамруулах	2017-2018 онд 366 малчин нийгмийн даатгалд хамрагдсан, 902 малчин эрүүл мэндийн даатгалд хамрагдсан. Аймаг, сумын аварга малчин шалгааруулах болзолд нийгмийн даатгалд хамрагдсан байдлыг харгалзан үздэг болсноор малчид нийгмийн сайн дурын даатгалд даатгуулах малчдын тоо жилээс жилд өссөн үзүүлэтэй байна.	100	70
46.	2.2.5 Хотын төвийн А зэрэглэлийн бүсэд мал болон туслах аж ахуй эрхлэж буй иргэдийг тусгай бүсэд шилжүүлэн хүн амыг	115. Мал болон туслах аж ахуй эрхлэх зөвшөөрсөн ба хориглосон бүсийг нарийвчлан тогтоох	Сумын ИТХурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 34 дүгээр тогтоолоор мал болон малын гаралтай түүхий эдийн худалдаа эрхлэгчдийг тодорхой бүс заан байршуулахаар шийдвэрлэсэн. Энэ хүрээнд малчид, туслах аж ахуй эрхлэгчдийг Түгийн овооны ард болон Цагаан хаалганы	100	100

	эрүүл, аюулгүй орчин амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.	асуудлыг 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган сумын ИТХурлаар батлуулах	хойно, шувууны аж ахуй эрхлэгчдийг Дайргын голд төвлөрүүлэхээр газрын төлөвлөлтийг баталсан.		
		116. Мал болон туслах аж ахуй эрхлэж буй иргэд, түүхий эдийн худалдаа эрхлэгчдийг зөвшөөрөгдсөн бүсэд аж ахуйгаа эрхлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах, хяналт тавих	Мал болон малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг аймгийн төвөөс гаргаж, нэг цэгт төвлөрүүлэх ажлыг 2016 оноос эхэлж, газрыг олгосон байгаа. Энэ ажил тодорхой үр дүнд хүрсэн. Одоогийн байдлаар мал, амьтны гаралтай түүхий эдийн худалдаа эрхлэх тогтоосон бүсэд 42 аж ахуй нэгж, иргэн газар өмчлөх хүсэлт тавин газар авч худалдаа эрхлэх нөхцөл байдал хангагдан тохижиж үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн амьд малын зах болон бойны газар ажиллаж байна. Арвайхээр хотын төвөөс малтай айл өрхүүдийг, мал амьтны гаралтай түүхий эд, өвс тэжээлийн худалдаа эрхлэгчдийг тогтоосон бүсэд нүүлгэн шилжүүлэх асуудлаар малчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулснаар малчдын хороололыг байгуулж, дэд бүтцээр хангахаар шийдвэрлэсэн. Үүний дагуу малчны хороололын тог цахилгааны асуудлыг аймгийн төсвөөс 40 сая төгрөг, улсын төсвөөс худагны асуудлыг шийдэхээр болсон.	70	40
47.	2.2.6 Хөдөө аж ахуйн нөхөрлөл, хоршоо байгуулах санал санаачлагыг дэмжин бүтээгдэхүүн борлуулах-зуучлах үйлчилгээг үзүүлж, ашигтай ажиллах нөхцлийг бүрдүүлж, хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдийг гадаад, дотоодод давтансургах, туршлага судлуулах ажлыг хэрэгжүүлнэ.	117. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн нөхөрлөл, хоршоо байгуулах санал санаачлагыг дэмжин бүтээгдэхүүн борлуулах-зуучлах үйлчилгээг үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх	Өрхийн тариалан бизнес хөгжил ТББайгууллага төсөлд хамрагдсан Бүтээлч дэвшил, Ундрах баян ирээдүй, Арвин шунхлай, Нартын гүнд гэсэн 4 хоршоо үйл ажиллагаа явуулж, 2017 онд 5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар төмс, хүнсний ногоо, хүлэмжийн тариалалт хийж ургацаа хураасан. Өрх толгойлсон 25 өрх болох Бүтээлч дэвшил хоршоонд Австралийн Засгийн газрын 20 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын дэмжлэгт хамруулсан. Мөн "Нартын гүнд" хоршоо Улаан загалмайн байгууллагын 4.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хүлэмжийн үйл ажиллагаагаа өргөжүүлсэн. "Намрын ногоон өдрүүд-2017,2018" үзэсгэлэн худалдаануудад тус сумын 5 хоршоог үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээр нь оролцуулж 3 өдөрт 11054000 төгрөгийн борлуулалт хийсэн. Ундрах баян ирээдүй хоршоо	100	70

			<p>“Хамгаалагдсан хөрснөөс хамгийн их бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн” хоршоогоор шалгарсан.</p> <p>2018 онд Бүтээлч дэвшил хоршоо нь газар тариалангийн үйл ажиллагаа явуулах газар хүссэнийг сумаас бодлогоор дэмжиж 3 га газрыг эзэмших шийдвэр гаргасан. Мөн шинээр байгуулагдсан Ариундөлгөөн хоршооны үйл ажиллагааг дэмжих зорилгоор ХХААГазраас тариалангийн газрыг, сумаас үрийн асуудлыг шийдвэрлэн өгч тариалалтыг хийлгэсэн. Хүнсний ногооны борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжих бодлогын хүрээнд Арвин шунхлай хоршоо оролцож сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүнсний ногоог тендрээр нийлүүлж байна.</p>		
		118. Хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдийг гадаад, дотоодод давтансургах, туршлага судлуулах ажлыг хэрэгжүүлэх	<p>2017 онд сумын ЗДТГазрын МЭҮТасгийн МЭХХХ-ын улсын байцаагчийг Япон улсын төрийн албан хаагчийн солилцооны хөтөлбөрөөр мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр 6 сарын сургалтанд хамруулав. Мөн Үржин дэвших хоршооны мал зүйч Д.Бадамхандыг ХХААХҮЯамны удмын сангийн газарт “Зохиомол хээлтүүлэг”-ийн сургалт мөн Япон улсад мал эмнэлгийн туршлага судлах ажилд, Япон улсын “Өвсний үндэс” төслийн хүрээнд Жайкагийн хөрөнгө оруулалтаар 1 тариаланчийг 2 сарын хугацаатайгаар бөөрөнхий сонгино тариалах сургалтанд тус тус хамрууллаа.</p> <p>2018 онд Япон улсын Хоккайдо мужийн Такикава хотын захиргаа болон Гадаад харилцааны нийгэмлэгтэй хамтран “Газар тариалан эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн агробизнесийг хөгжүүлэх төсөл”-ийг олон улсын “Жайка” байгууллагын санхүүжилтээр суманд хэрэгжүүлж байна. Тус төслийн хүрээнд аймгийн ХХААГазрын мэргэжилтэн Д.Нансалмаа, тариаланч В.Ганцэцэг нар 1 сарын хугацаатай хүнсний ногоо боловсруулах сургалтад хамруулав.</p>	100	70
48.	2.2.7 Усалгаатай тариалан, хөрс хамгаалах, техник технологийн дэвшил, гагаас авах ургацын хэмжээг	119. Усалгаатай тариалан, хөрс хамгаалах, техник технологийн дэвшил,	Тариалангийн газрын хөрсний төлөв байдал, чанарын үзүүлэлтийг 4 жилд нэг удаа тогтоох хөрсний агрохими, агрофизикийн шинжилгээнд 7 иргэн хөрснөөс дээж авч мэргэжлийн байгууллагаар шинжлгээнд хамруулав.	100	70

	нэмэгдүүлэх замаар төмсний 90, хүнсний ногоо 35, жимс жимсгэнэ 0.5 хувийн хэрэгцээг дотоодоос хангах нөхцлийг бүрдүүлнэ.	га-гаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх замаар импортын төмс, хүнсний ногооны хэрэглээг бууруулах	Сумын хэмжээнд төмс 67.3 га-д тариалж 978.3 тн, хүнсний ногоо 30.6 га-д тариалж 345.4 тн, жимс жимсгэнэ 0.5 га-д, тэжээлийн ургамал 0,3 га-д тариалж 40 тн ургац тус тус хураан авсан байна. Тус мэдээгээр өмнөх оноос төмс 6.9 га буюу 9%, хүнсний ногоо 4.8 га буюу 8.6 % -р тус тус буурсан ч нэгжийн ургац төмс 29 цн, хүнсний ногоо 15 цн-ээр өссөн дүнтэй байна. “Жимс жимсгэнэ” хөтөлбөрийн хүрээнд 2 иргэн 400 ш үхрийн нүд, 1500 ш чацарганы суулгацын хөнгөлттэй зээлд хамрагдаж тариалалтаа хийгээд байна. Мөн иргэд өөрийн хөрөнгө оруулалтаар чацаргана 112 ш, үхрийн нүд 47 ш, нохойн хошуу 10 ш, монос 3 ш, чавга 2 ш тус тус тариалсан байна.		
		120. Дотоодын үйлдвэрлэлээр сумын хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ хангалтыг нэмэгдүүлэхэд мэргэжил арга зүй болон хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжих	Сумын төмс, хүнсний ногоо тариалсан 5 аж ахуйн нэгж, 25 иргэний талбайд ургац тогтоолт хийж, хөрсний рН-ийг тодорхойлсон. Мөн "Органик хүнсний тухай" хуулийн сургалтыг 1 удаа, сумын тариаланч эмэгтэйчүүдэд төмс, хүнсний ногоо боловсруулах, хадгалах технологийн сургалт 2 удаа нийт 65 тариаланчид зохион байгуулсан. ХЭДСангийн “Ногооны бүл”-ийн төслөөр 10 бүл хамрагдаж 42 ажлын байр, ахмадын зөвлөх үйлчилгээнд 2 иргэн хамрагдаж 2 ажлын байр, хүлэмжийн аж чиглэлээр 4 ажлын байр, тариалалт, хураалтын ажилд 15 иргэн хамрагдаж нийт 63 ажлын байр бий болсон байна. СХСангийн санхүүжилтээр хүлэмж барих, хүнсний ногоо боловсруулах зориулалтаар 3 аж ахуйн нэгжид 35 сая төгрөгийн зээл олгох шийдвэр гаргаад байна.	100	70
49.	2.2.8 Газар тариалангийн салбарт орчин үеийн өндөр хүчин чадалтай техник, технологи нэвтрүүлж, Дайргын голын хойд хэсгийн услалтын системийн хөрөнгийн эх үүсвэрийг судланорганик бордооны цех, хүнсний ногооны төрөлжсөн зоорь /энгийн болон автомажсан,	121. Газар тариалангийн салбарт орчин үеийн өндөр хүчин чадалтай техник, технологи нэвтрүүлэх боломж, нөхцлийг судлах	2018 онд Арвин худалдааны төв нь бүрэн автоматжсан хүнсний ногооны төрөлжсөн зоорь, хүнсний ногооны бөөний худалдааны төв байгуулах зорилгоор ХХААХҮЯамны ЖДҮйлдвэрийг дэмжих сангийн 690 сая төгрөгийн зээлд хамрагдан хүнсний ногооны бөөний төв болон 300 тн-ны багтаамжтай төмс, хүнсний ногооны зоорь байгуулан ашиглалтанд ороод байна. ХХААХҮЯамнаас “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Дунд оврын трактор” техник дундын үйлчилгээний зориулалтаар олгосныг П.Ганбаатартай эзэмшүүлэх гэрээ байгуулан 55 өрхийн 80 га-д ургац хураалтад ажилсан	100	70



	механикжсан/ байгуулж, өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ.		байна.		
		122. Дайргын голын хойд хэсгийн услалтын систем, үерийн далан байгуулах хөрөнгийн эх үүсвэрийг судлах	Дайргын голын хойд хэсгийн усалгаа байгалийн голдирлоороо урсдаг тул усалгаа хийхэд ус нь хөрсөндөө шингэлт ихтэй удаан ирдэг учир усалгааны сувгийг шулуутгах ажилд ОНХСанд 1 сая төгрөг тусган шуудуу татах бэлтгэл ажил хангагдаад байна.	70	40
		123. Органик бордооны цех, хүнсний ногооны төрөлжсөн зоорь /энгийн болон автомажсан, механикжсан/ байгуулж, өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх	“Эко нүүрс” төрийн бус байгууллагын “Био нүүрс” үйлдвэрлэх сургалтанд сууж тоног төхөөрөмжийн дэмжлэгт 5 иргэн 4 хоршооны төлөөлөл хамрагдаж, энэ жил өөрсдийн хэрэгцээний 0.8 тн био нүүрсэн бордоо, 0.5 тн био ялзмаган бордоо үйлдвэрлээд байна.Нартын гүнд хоршоо нь хог хаягдал дахин боловсруулах, бордоо үйлдвэрлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэн яс, цусаар бордоо хийн туршилтын шатандаа байна. Аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас 9.8 сая төгрөгийн санхүүжилтээр "Арвайхээр тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГазарт 20x8 харьцаатай хүлэмжийг аж ахуйн аргаар барин ашиглаж байна. Арвин худалдааны төв нь бүрэн автоматжсан хүнсний ногооны төрөлжсөн зоорь, хүнсний ногооны бөөний худалдааны төв байгуулах зорилгоор ХХААХҮЯамны ЖДҮйлдвэрийг дэмжих сангийн 690 сая төгрөгийн зээлд хамрагдан хүнсний ногооны бөөний төв болон 300 тн-ны багтаамжтай төмс, хүнсний ногооны зоорь байгуулан ашиглалтанд ороод байна.	70	40
50.	2.2.9 Газар тариалангийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санг боловсронгуй болгож, санг үйл ажиллагааны хэрэглээ болгоно.	124. Тариалан эрхлэгчдийн бүртгэл судалгааг нарийвчлан гаргах, статистикийн ХАА программд бүрэн оруулж, үйл ажиллагааны хэрэглээ болгох	Тариалангийн талбайн эзэмшилт ашиглалтын судалгааг нарийвчлан гаргаж тариалангийн үйл ажиллагаа тогтмол эрхэлдэг 15 иргэнийг баталгааны тэмдэгтэй болгон төмс хүнсний ногоогоо зарж борлуулсан 24 иргэн, ААНэгжид ургамал түүний гарал үүслийг тодорхойлох бичгийг хийсэн. Статистикийн ХАА программд тариалалт болон ургац хураалтын мэдээг иргэн, ААНэгжээр нь хугацаанд шивүүлсэн, мэдээллийн санг өдөр тутмын үйл ажиллагааны хэрэглээ болгосон.	100	70
51.	2.2.10 Чацаргана бусад жимс жимсгэнэ, хүнсний	125. Жимс, жимсгэний тариалангийн бүтцэд	2018 онд “Жимс жимсгэнэ” хөтөлбөрийн хүрээнд 2 иргэн 400 ш үхрийн нүд, 1500 ш чацарганы суулгацын	100	70

	<p>болон эмчилгээний ач холбогдол бүхий ховор ургамал, эрт ургацын хүнсний ногооны тариалалтыг хөгжүүлнэ.</p>	<p>чацарганаас гадна алим, үхрийн нүд, бөөрөлзгөнө зэрэг жимс жимсгэнийг тариалуулах, үр суулгацыг олж нийлүүлэх, арга зүйгээр хангах</p>	<p>хөнгөллтэй зээлд хамрагдаж тариалалтаа хийгээд байна. Мөн иргэд өөрийн хөрөнгө оруулалтаар чацаргана 112 ш, үхрийн нүд 47 ш, нохойн хошуу 10 ш, монос 3 ш, чавга 2 ш тус тус тариалсан нь өмнөх оноос байна.</p>		
	<p>126. Эмчилгээний зориулалт бүхий ховор ургамал болох артишок, эрт болцын навчит ногоо тариалах санал санаачлагыг дэмжих</p>		<p>Эмчилгээний ач холбогдол бүхий артишок ургамлыг 5 иргэн хүлэмжинд тариалан хатааж “Намрын ногоон 2018” өдрүүд үзэсгэлэн худалдаагаар иргэдэд хүргээд байна.Сумын хэмжээнд 4.3 га талбайд хүрэн манжин тариалж 44.3 тн ургац хураан авч эмчилгээний хүнсний зориулалтаар хэрэглэж байна.</p> <p>Эрт ургацын хүнсний ногоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд 11 дүгээр багийн иргэн Ц.Адъяа ХХААХҮЯамны харъяа ТЭДСангийн хөнгөлөлттэй зээлээр 3 хүлэмж, ХХААГазарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ирсэн нэг хүлэмжийг аймгийн цагдаагийн газар олгож нийт 600м2 бүхий 5 хүлэмж байгуулагдан хүнсний ногооний тариалалт хийгээд байна.</p> <p>Япон улсын Хаккойда мужийн Такикава хотын Гадаад харилцааны хэлтэстэй хамтран газар тариалангийн чиглэлээр “Агро-бизнесийг хөгжүүлэх” төсөл хэрэгжүүлж үрслэгээр бөөрөнхий сонгино ургуулах туршилт хэрэгжүүлэх ажлын хүрээнд Такикава клубын гишүүд болон тариаланчид нийт Япон, ОХУ-ын 5 сортын 108840 ширхэг үрсэлгээг талбайд тариалж 4.2 тн ургац хураан авсан.</p> <p>Каритас монгол, Өрхийн тариалан бизнес хөгжил төслийн хүрээнд байгуулагдсан 3 улирлын нарлаг хүлэмжүүд нь эрт ургацын навчит ногоо, өргөст хэмх, улаан лооль зэргийг тариалан томоохон гал тогоо бүхий газрууд Арвайхээр палас, Гэрэл ресторануудад гэрээгээр нийлүүлж байна.</p>	<p>100</p>	<p>70</p>
	<b>Салбарын дундаж үнэлгээ</b>			<b>95</b>	<b>67.3</b>
	<b>Хоёрдугаар бүлгийн дүн</b>			<b>95.0</b>	<b>69.8</b>

Гуравдугаар бүлэг. Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, хөгжлийн бодлого зохицуулалт					
3.1 Байгаль орчин, газар зохион байгуулалт					
52.	3.1.1 Хотын ногоон байгууламжийн хэмжээг жил бүр 3-аас доошгүй га талбайгаар нэмэгдүүлэн, өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх замаар нэг наст ба олон наст цэцгийн суулгацын шинэ сортыг нутагшуулна.	127.Т.Намнансүрэнгийн нэрэмжит гудамжийг тохижуулах	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 57.830.0 сая төгрөгийн санхүүжилтээр Т.Намнансүрэнгийн нэрэмжит гудамжинд 2017 онд 2400м <sup>2</sup> , 2018 онд 2700 м <sup>2</sup> талбайг эко хавтанжуулж зүлэгжүүлэх ажлыг Арвайхээр тохижилт үйлчилгээ-ОНӨААТҮГазар хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Энэ онд хотын хэмжээнд 6242 ш мод бут, 1950 м <sup>2</sup> зүлэгжүүлэлт, 750 м <sup>2</sup> талбайд цэцгийн мандал байгуулах зэрэг ажлууд хийгдсэн бөгөөд Байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах зардалаас-27.260.0 мянган төгрөг зарцуулагдаж ногоон байгууламжийн хэмжээ 3.1 га-аар нэмэгдэж 51.4га-д хүрлээ.	100	100
		128. Д.Пүрэвдоржийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнг тохижуулах	2017 онд Бүх нийтээр мод тарих өдрийн хүрээнд Арвайхээр сумын ерөнхий боловсролын 1-р сургуулийн 3р ангийн багш, сурагчид эцэг эхийн зөвлөл хамтран өөрсдийн санаачлагаар гоёл чимэглэлийн 280 ш мод бутыг тарьсан бөгөөд амьдралтын хувь 82 байна. 2019 онд тус цэцэрлэгт хүрээлэнд Өвөрхангай аймгийн 19 сумын онцлогийг харуулсан танилцуулах самбар, байгалын өвөрмөц тогтоцыг харуулсан модель бүхий амрах талбайг байгуулахаар ажлын зураг хийгдэж байна.	40	
		129. Инженерийн шугам сүлжээ хийгдсэн авто болон явган замуудад ургамлан хашлага бий болгох	2017 онд Т.Намнансүрэнгийн нэрэмжит гудамжинд 211 уртааш метрт 3000 ширхэг хайлаас модыг ургамлан хашлагаар тарьж, амьдралтын хувь 95 байсан бөгөөд 2018 онд авто замын хашлагаар зурвас байгуулан 238 ш улиас тариалсан.Эдгээр объектуудын усалгаа арчилгааг Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГазар хариуцан ажиллаж байгаа бөгөөд амьдралтын хувь 98 байна. Мөн ирэх онд 3-р багийн авто зам дагуу тариалахаар төлөвлөж байна.	100	70
		130. Нийтийн эзэмшлийн зам	Жил бүр аймгийн ХХҮГазрын нийтийг хамарсан ажлын санхүүжилтээр нийтийн эзэмшлийн зам талбайн 5.2-7 га	100	70

		талбайн хог ургамлыг үе шаттайгаар түүж устган, цэвэрлэсэн талбайг зүлэгжүүлж, хөрсийг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах	талбайн хог ургамлыг түүж устган цэвэрлэх ажлыг зохион байгуулдаг бөгөөд өөрийн эзэмшлийн газартай 56 байгууллага аж ахуй нэгжүүд рүү гадна талбайн хог ургамлыг технологийн шатанд нь түүж устгах зөвлөмж бүхий албан тоотыг хүргүүлж, 89 тн хог ургамлыг зориулалтын хогийн цэгт зөөж тээвэрлэсэн байна. Энэ онд нийтийн эзэмшлийн зам талбайн хог ургамлыг түүж устгах ажлыг Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГ, Арвайхээр тохижилт үйлчилгээ-ОНӨААТҮГ газрууд 7,8,9 дүгээр саруудад хариуцан зохион байгуулсан бөгөөд Т.Намнансүрэнгийн нэрэмжит гудамжинд буюу Арвайхээр палас буудлын орчимд 1950 м <sup>2</sup> талбайд зүлэгжүүлэлтийн ажил хийж гүйцэтгэсэн байна.		
		131. Байгууллага аж ахуй нэгжүүдийн гадна талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлж, нэрэмжит гудамж бүрийн онцлог шинж чанарт тохирсон гоёл чимэглэлийн мод бут тариалах ажлыг зохион байгуулах	Арвайхээр хот үүсэн байгуулагдсаны 290 жилийн хүрээнд тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх болзолт уралдаан зарлагдаж хотын хэмжээнд нийт 13 байгууллага, 1023 ш чимэглэлийн мод бут тарих болон бусад тохижилтыг сайжруулах ажилд 161 сая төгрөгийн зардал гарган хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлсэн байна. 2018 онд Нэрэмжит гудамж бүрийн онцлогийг харуулсан тохижилтын ажлын зураг шинээр хийгдэж байгаатай холбогдуулан тохижилт ногоон байгууламжийн гэрээг шинэчлэн боловсруулж, одоогийн байдлаар 23 аж ахуй нэгжтэй байгуулсан бөгөөд гэрээний хэрэгжилтэнд тогтмол хяналт тавин ажиллаж байна.	40	40
		132. Арвайхээр тохижилт үйлчилгээ-ОНӨААТҮГ газарт туршилт судалгааны өвлийн хүлэмж байгуулах	БОАЖГазрын байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлаас 26 сая төгрөгийн санхүүжилтээр Арвайхээр цэцэрлэгжилт-ОНӨААТҮГ газарт 20x7 харьцаатай хүлэмжийг аж ахуйн аргаар барихаар шийдвэрлэсэн бөгөөд тендерийн баримт бичиг боловсруулах ажил хийгдэж байна.	40	40
53.	3.1.2 "Дэлгэрэх гол" төслийг үргэлжлүүлж, орчны тохижилт, ногоон	133. Бизнес эрхлэгчдийн цэцэрлэгт хүрээлэнгийн хайс	БОАЖГазрын байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлаас 9 сая төгрөгийн санхүүжилтээр Дүүрэн хорол ХХК тус цэцэрлэгт хүрээлэнгийн 260 у/м хайс хашлагыг	100	100

байгууламжийн ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, стандартад нийцсэн мод үржүүлгийн газар байгуулах иргэдийн санал санаачлагыг дэмжинэ.	хашлагыг шинэчлэж, мод бут тарих	шинэчилж хүлээлгэн өгсөн бөгөөд “Төгсөгч бүр төгөл мод ургууль” уриан дор ЕБСургуулийн төгсөх ангийн 500 гаруй багш сурагчид 620 ширхэг улиас, хайлаас зэрэг мод бутыг тариалж, усалгаа арчилгааг Арвайхээр тохижилт үйлчилгээ-ОНӨААТҮГазар тогтмол гүйцэтгэж амьдралтын хувь 84,6 байна.		
	134. Гульдралыг тэгшитгэсэн газруудад түргэн ургалттай мод бут тарих ажлыг зохион байгуулах	ЕБ 4 дүгээр сургуулийн 8 а,б ангийн сурагчидтай хамтран энэ оны намрын тарилтаар Барилгачдын гудамж буюу Дэлгэрэх гол орчимд 120 ш улиас тариаллаа.	70	40
	135. "Дэлгэрэх гол" төслийг үргэлжлүүлэх	2017 онд ӨВ-А33А ТӨХК Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 60 сая төгрөгийн санхүүжилтээр 2,7 дугаар багийн гүүрнээс Дэлгэрэхийн гүүр хүртлэх 340 у/м гульдралыг тэгшитгэх ажлыг хийж гүйцэтгэсэн бол энэ онд 500 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дэлгэрэхийн гүүрнээс ШУТИС хүртлэх520 м газарт гольдролыг тэгшитгэх, авто зам тавих, гэрэлт гүүр тавих зэрэг ажлуудыг Өндөр сант хайрхан ХХК хийж гүйцэтгэлээ.	100	70
	136. Стандартын шаардлагад нийцсэн мод үржүүлгийн талбайг шинээр байгуулж, иргэд аж ахуй нэгж байгууллагуудыг нутагшсан суулгацаар хангах	Арвайхээр тохижилт үйлчилгээ-ОНӨААТҮГазрын ногоон байгууламжийн албыг өөрчлөн шинэчилж, Арвайхээр ногоон байгууламж-ОНӨААТҮГазар болгож байгаатай холбогдуулан 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Дайргын голд 0.4 га талбайд мод үржүүлгийн газар байгуулахаар төлөвлөж сумын ИТХурлаар батлуулаад байна. 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 2.5 га талбайд шинээр мод үржүүлгийн талбай байгуулахаар сумын ИТХурлаар батлуулсан бөгөөд энэ онд Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГазрын дэргэд наадмын талбайд байрлах 0.2 га талбай бүхийн мод үржүүлгийн талбайд 2019 оны хаврын тарилтанд гарах 5000 ш шар хуайсыг үрээр хүлэмжинд тариалсан. Ирэх онд гоёл чимэглэлийн мод бутны суулгац үржүүлэх төлөвлөгөөтэй байна.	70	40

54.	3.1.3 Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх хэсэгчилсэн төлөвлөгөөнд тусгагдсан газруудад иргэдийн амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх модлог ургамлын төгөл бүхий бичил цэцэрлэгт хүрээлэнгүүдийг байгуулж, мөнгөн хуримтлалын бүлүүдийн санал санаачилгыг дэмжих замаар гэр хорооллын стандартын дагуу тохижуулсан Ногоон өрх-Ногоон гудамжуудыг бий болгоно.	137. Баг тус бүрд иргэдийн амралт чөлөөт цагийг өнгөрүүлэх бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах	2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 1,3,4,6,8,9,10,11 дүгээр багуудад иргэд амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх тоглоомын талбай барих газрыг шийдвэрлэсэн. Үүнээс орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 49,5 сая төгрөгөөр 4,11-р багт иргэд амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх бичил тоглоомын талбай байгуулах ажлыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу харьцуулалтын аргаар цахимаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж “Даншиг өргөө” ХХК гүйцэтгэсэн. Цаашид санхүүжилтийг шийдвэрлэж бусад багуудад тоглоомын талбай байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.	100	40
		138. Баг тус бүрд гэр хорооллын стандартын дагуу тохижуулсан жишиг өрх, жишиг гудамж бий болгох	Баг тус бүрт сонгогдсон гудамжийг тохижуулах ажлууд үе шаттайгаар хийгдэх бөгөөд энэ онд 11 багийн 185 өрхөд 1250 ш түргэн ургалттай, 3 настай навчит мод буюу улиасыг үнэ төлбөргүй тарааж тариалсан. Улаанбаатар хотын “Шинэ тосгон” хөдөлгөөний багш сургагчдыг Арвайхээр хотод урьж иргэдэд сургалт, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд 4-р улиралд багтаан зохион байгуулагдана. Мөн хашаагаа жишиг тохижуулсан иргэдийн санал санаачлагыг дэмжих зорилгоор Ноёны 10-р багийн иргэн Б.Батмөнхийн гэр бүлийг орон нутгийн телевизээр нэвтрүүлэгт оролцуулж сурталчилан ажиллаж байна.	40	40
		139. Гэр хорооллын үерийн урсац ирдэг, жалга гууны эвдрэл ихтэй газруудад түргэн ургалттай навчит мод бутаар хөшиг үүсгэн тариалж, хөрсний элэгдэл эвдрэлээс хамгаалах	Арвайхээр сумын 13 багийн нутаг дэвсгэрт гэр хорооллын дундах үерийн ус урсдаг болон гудамж хоорондын ус ихээр тогтдог газрын рельефийг тэгшлэхэд 200 м <sup>3</sup> шороо асгаж тэгшлэх ажлыг багийн иргэдтэй хамтран зохион байгууллаа. Ирэх хаврын тарилтаар мод бут тарих ажлыг зохион байгуулна.	70	40
55.	3.1.4 Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг	140. Хотын соёлч иргэн, Хотын дүрэм сэдэвт хичээлүүдийг	Хотын дүрэм, Хотын соёлч иргэн, Байгаль орчинд ээлтэй амьдрах зэрэг сэдвүүдийн хүрээнд Арвайхээр сумын ерөнхий боловсролын 1, 4 дүгээр сургуулийн ахлах	100	70

	тогтмолжуулж, ногоон хөгжил, ногоон амьдралын хэв маягыг тусган мөрдүүлэх замаар хотын соёлч иргэн байх зөв дадал хэвшлийг төлөвшүүлнэ.	ерөнхий боловсролын сургуулиуд болон зорилтот бүлгүүдэд үе шаттайгаар зохион байгуулах	ангийн сурагчдад сэдэлжүүлэх сургалтыг 2 удаа зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 215 хүүхэд хамрагдсан байна. Сургалтын үр дүнд тус сургуулийн хүүхдүүд Дэлгэрэх голын гульдралыг цэвэрлэх, сургуулийн орчмын мод бутыг услах арчлах, нөхөн тарих зэрэг олон үйл ажиллагааг өөрсдийн санаачлагаар хийж гүйцэтгэсэн болно. Унасан газар-Угаасан ус минь” сэдэвт явган аялал, сургалтыг 2018 оны 10 дугаар сарын 14-ны өдөр ерөнхий боловсролын 4 сургуулийн 9-11 ангийн 80 сурагчийг хамруулан зохион байгууллаа.Тус сургалт аялалаар эрүүл амьдралын зан үйл, хотын соёлч иргэний хэвшүүлэх зөв дадал хэвшил, байгаль орчныг хайрлан хамгаалах талаар мэдлэг мэдээллийг хүүхдүүдэд хүргэлээ.		
		141. Иргэд олон нийтэд зориулсан байгаль орчны чиглэлийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг төрийн болон төрийн бус байгууллага, төсөл хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлэх	2017 онд Аймгийн БОАЖГ, ЭМГазартай хамтран жил бүрийн 5-р сард байгаль орчинд нөлөөгүй амьдрах, хог ургамлыг устгаж, зүлэгжүүлэх, мод бут тарьж арчлах зэрэг сэдвүүдээр сургалт мэдээллийг тогтмол зохион байгуулсан бөгөөд энэ онд давхардсан тоогоор 156 иргэн хамрагдсан байна. 2018 онд Аймгийн БОАЖГазартай хамтран Монголын цэцэрлэгчдийн холбооны тэргүүн С.Бямбасүрэн, Ногоон харш ХХК-ны захирал Ц.Баяр, Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэлийн ногоон байгууламжийн албаны ахлах мэргэжилтэн Д.Батцэцэг зэрэг сургагч багш нарыг авчран “Ногоон байгууламж, мод бут сөөг тарих арга зүй” сэдэвт сургалтыг сумдын Засаг дарга, байгаль орчны байцаагчид, Арвайхээр тохижилт үйлчилгээ-ОНӨААТҮГазар болон Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГазрын ажилтан албан хаагчид болон мод тарих сонирхолтой иргэдийг хамруулан зохион байгууллаа. Сургалтанд нийт 152 иргэн хамрагдав.	100	70
56.	3.1.5 Түгийн овооны төвлөрсөн хогийн цэгийн үерийн усны хамгаалалтыг сайжруулж, ландфиллын	142. Хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр стандартын дагуу	Гэр хорооллын айл өрхийн хог тээвэрлэлтийн эргэлтийг сайжруулах зорилгоор “Арвайхээр ТҮ” ОНӨААТҮГазрын хог хаягдал ачиж тээвэрлэх хуваарийг 2017 онд шинэчилэн үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллаж	100	70

<p>аргаар дарж хөрсжүүлэх ажлыг тогтмолжуулан хог хаягдлыг дахин боловсруулах жижиг үйлдвэрцех байгуулах ажлыг олон улсын төсөл, хөтөлбөрийн байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.</p>	<p>цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа явуулах, гэр хорооллын хог татан авалтын хуваарийг шинэчлэх, хэрэгжилтэнд хяналт тавих</p>	<p>байна. 2017 онд нийт 3 удаагын бүх нийтийн их цэвэрлэгээ, нийтийг хамарсан ажилд давтагдсан тоогоор 6032 иргэн оролцож, хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 10300орчим гаталбайн 1465,9тн хог хаягдлыг цэвэрлэсэн байна. 2018 ондАрвайхээр хотын Захирагчийн “Нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай А/09 дүгээр захирамжийн хэрэгжилтийн хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран “Эерэг хандлага-эрүүл цэвэр орчин” уриалгатай зохион байгуулсан. Тус цэвэрлэгээний хүрээнд төв зах, орд техникийн захуудад худалдаа эрхлэгч нийт 130 гаруй иргэн, мөн гэр хорооллын 11 багийн нутаг дэвсгэрт зохион байгуулсан нийтийн их цэвэрлэгээнд хүнсний талонд хамрагддаг нийт 528 иргэн оролцож, 39рэйс буюу 234м<sup>3</sup> хог хаягдлыг цэвэрлэн “Арвайхээр тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГазрын 6 авто машин хогийн цэгрүү ачиж тээвэрлэх ажлыг гүйцэтгэж 210000 /Хоёр зуун арван мянга/ төгрөгийн шатахуун зарцуулсан байна.</p>		
	<p>143. Түгийн овооны төвлөрсөн хогийн цэгийн үерийн усны гольдролыг өөрчлөх, хамгаалалтын далан босгох</p>	<p>Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 89,5 сая төгрөгөөр “Түгий овооны нэгдсэн хогийн цэгийн техникийн нөхөн сэргээлт хийх, хогийн цэгийн хамрах талбайг багасгах ажлыг Улаанбаатар хотын “Элемент ХХК” 38,1 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 06 дугаар сарын 25-аас 8дугаар сарын 15-ны хүртэлх хугацаанд 100 хувь хийж гүйцэтгэн ашиглагч байгууллага Арвайхээр тохижилт үйлчилгээ орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт хүлээлгэн өгсөн.</p>	100	100
	<p>144. Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоотой хамтран ажиллах боломжийг судлан хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр экопарк</p>	<p>Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын дэмжлэг дор "Эрүүл хот хөтөлбөрийг чадавхижуулах төв" -с үндэсний түвшний эрүүл хотуудын сүлжээний үйл ажиллагааг чадавхижуулах зорилгоорэрүүл хотын үүсгэл санаачилгыг дэмжин ажиллаж байгаа хотуудын туршлага судлах уулзалт семинарт аймаг, сумын удирдлагын төлөөлөл оролцож, эрүүл хотын чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулж, цаашид Олон Улсын Эрүүл хотуудын Холбооны</p>	70	40



		байгуулах ажлын эхлэлийг тавих	гишүүнээр элсэх зорилт тавин ажиллаж байна.		
57.	3.1.6 Гэрийн тэжээвэр амьтдын бүртгэл мэдээллийн сан бүрдүүлж, арьс түүхий эдээр үйлдвэрлэл явуулах иргэдийн санал санаачлагыг дэмжих замаар эдийн засгийн эргэлтэнд оруулах нөхцлийг бүрдүүлнэ.	145. Нохой, муурны бүртгэл, мэдээллийн сантай болж гэрийн тэжээвэр амьтны журам боловсруулан хэрэгжүүлж, татвар, хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж хэвшүүлэх	2017.11.18-22-ны өдрүүдэд Улаанбаатар хотын “Мөнхбуян” ХХК-ны нохой устгалын багтай хамтран нохой устгах ажлыг зохион байгуулж 324 нохой устгуулж 2017 оны 11 сарын байдлаар нийт 984 золбин нохой устгасан байна. Нохойны татвар хураамжийн орлогыг 11 дүгээр сарын байдлаар 1,0 сая төгрөг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна. Багийн Засаг дарга нарын ажлын албатай хамтран гэрийн тэжээвэр нохойны судалгааг 2017 оны 10 дугаар сард шинэчлэн гаргасан. 2018 оны байдлаар 1-р баг 135, 2-р баг 120, 3-р баг 118, 4-р баг 111, 5-р баг 78, 6-р баг 120, 7-р баг 130, 8-р баг 143, 9-р баг 148, 10-р баг 110, 11-р баг 66, 12-р баг 55, 13-р баг 48буюу нийт 1382 эзэнтэй нохой байна. 2018 оны орлогын төлөвлөгөөнд нохойн татвар хураамжийг 8.5 сая төгрөгөөр баталсан бөгөөд орлогын гүйцэтгэлийн хангах ажлын хүрээнд багийн Засаг дарга нарын үр дүнгийн гэрээнд тусган орлого төвлөрүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Арвайхээр ТҮ ОНӨААТҮГазар нь 2018 оны 11 сарын байдлаар 1100 золбин нохой устгах ажлыг зохион байгуулж, 13,497,0мян төгрөгийг нохой устгалын багийн цалин,шатахуун, сум зэрэг зардалд зарцуулсан байна.	70	70
		146. Нохойны арьс боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар санаачлага гаргасан иргэдэд дэд бүтэц, санхүүгийн дэмжлэг үзүүлэх	“ӨВ АРВАЙ” шилмэл үүлдрийн нохой үржлийн алба байгуулагдаж нохой устгал, нохойн арьсаар бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлэх төсөл ирүүлсэн боловч санхүүгийн нөөц боломжоос шалтгаалан хэрэгжих боломжгүй байна.  Үнэлэх боломжгүй	-	-
58.	3.1.7 Нийтийн эзэмшлийн зам талбайн шаардлагатай газруудад орчин үеийн	147. П.Гэндэнгийн нэрэмжит гудамж, БОЭТөвийн дэргэд	П.Гэндэн, Т.Намансүрэнгийн нэрэмжит гудамжид 2 байршлыг сонгон нийтийн бие засах газар байгуулах зураг, төсвийг боловсруулан 2019 оны сумын нийгэм,	-	-

	чанар стандартад нийцсэн нийтийн бие засах газруудыг байгуулж, төв захын жижиг худалдааны төвүүдийг нэгдсэн шугам сүлжээнд холбоно.	орчин үеийн чанар стандартад нийцсэн нийтийн бие засах газруудыг байгуулах	эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган сумын орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх бүтээнбайгуулалтын ажилд санал оруулан ажиллаж байна.  Үнэлэх боломжгүй		
		148. Төв захад үйл ажиллагаа эрхэлж буй худалдааны төвүүдийг нэгдсэн дулаан, бохирын шугам сүлжээнд холбох	Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд Байгаль орчны сайдын багцаас 25 сая төгрөгийн санхүүжилтээр 2018 онд Төв захад үйл ажиллагаа эрхэлж буй “Элбэг, Халуун ус, Марко/шинэ төв/, Эрдэнэ, Хайрхан, Хүүхдийн ертөнц, Арвай, Хангамж” гэсэн 8 худалдааны төвийг Арвайхээр сумын 5-р дугаар цэцэрлэгийн дулааны зууханд холбох ажлыг “Хангамж өргөө”ХХК хийж гүйцэтгэсэн. Нийт 82 метр дулааны шугам холбосон.	100	70
59.	3.1.8 Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулан байгальд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар шинэ санал санаачлага гаргасан иргэн, аж ахуй нэгж, байгууллагыг "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сурталчилж, урамшуулал олгох журам"-ын дагуу шалгаруулж, тэргүүн туршлагыг нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.	149. Хог хаягдлыг бууруулахад чиглэсэн бүтээлч, байгальд ээлтэй үйл ажиллагаа эрхэлсэн иргэн, аж ахуй нэгж байгууллагыг шалгаруулж, сурталчилан, урамшуулал олгох	Арвайхээр хот үүсэн байгуулагдсаны 290 жилийн ойн хүрээнд хотын төвд үйл ажиллагаа явуулж буй байгууллага аж ахуй нэгжийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, нийгмийн хариуцлагыг өндөрсгөх, тохижилт бүтээн байгуулалт, хог хаягдал, цэвэрлэгээний менежментийг сайжруулах, хотын өнгө үзэмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллага, аж ахуй нэгжүүдийн дунд “Шилдэг тохижилттой бүтээлч байгууллага” шалгаруулах 5,0 сая төгрөгийн шагналын сантай болзолт уралдааныг 2017 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс 07 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд зарласан. Тус уралдааныг байгууллагаас гарч буй хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын уут саванд түр хадгалах байдлаар хог тээвэрлэгч компанид хүлээлгэн өгч хэвших, байгууллагын дотор болон гадна талбайд хогийн савыг байршуулсан байх, хог тээврийн гэрээ байгуулах, гадна тохижилтыг сайжруулсан байх зэрэг 13 шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж “9 дүгээр цэцэрлэг”, “Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв” гэсэн 2 байгууллага тэргүүн байр эзэлж бусдад үлгэр жишээ болж манлайлж оролцсон. Үүний үр дүнд цаашид хотын өнгө үзэмж сайжрах, эрүүл, ая тухтай орчинд ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг иргэд өөрсдөө бүрдүүлэх, иргэд, аж ахуй нэгж байгууллагын оролцоог нэмэгдүүлэх ач	70	70

			<p>холбогдолтой ажил болсон.</p> <p>2018 онд “Хог хаягдлын эко шийдэл” хог хаягдлыг ашиглан бүтээл хийх уралдааныг 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс 05 дугаар сарын 07-ны өдөр хүртэлх хугацаанд 3 үе шаттайгаар зохион байгуулж, уралдаанд 2 сургуулийн 11 баг бүтээлээ ирүүлсэн. 2018.05.09-ны өдөр Аюуш баатарын төв талбайд уралдаанд оролцсон бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж, шагналыг гардуулах арга хэмжээ зохион байгуулагдсан. Үүнд: ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 6в ангийн Тэмүүлэл баг 1-р байр, Мэргэд сургуулийн 6б ангийн Эко-Монгол баг 2-р байр, ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 8е ангийн Акулуд баг 3-р байр эзэлж медаль, мөнгөн шагналаар шагнаж, бусад идэвхитэй оролцсон багуудад Хүүхдийн паркт тоглох эрхийн бичгээр урамшуулж, мөн олон баг, олон хүүхдийн оролцоог хангаж ажилласан ЕБ-ын 1 дүгээр сургуулийг Бүтээлч сургуулиар шалгаруулж батламж, мөнгөн шагналаар шагнасан. Уралдааны гол ач холбогдол нь сурагчдад хог хаягдлын талаар экологийн боловсрол олгож, тэдний шинэ санал санаачлагыг идэвхжүүлсэн чухал үйл ажиллагаа болсон.</p>		
		<p>150. Хог хаягдлыг бууруулах чиглэлээр шинээр санаачлага гаргасан сайн дурын идэвхтэн, ЕБ-ын сургуулийн эко клубын үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, дэмжих</p>	<p>Хог хаягдлыг бууруулах, хоёрдогч түүхий эдийг дахин боловсруулах чиглэлээр аймгийн Засаг даргын дэргэдэх төслийн багтай хамтран Канадын элчин сайдын яамнаас зарласан Орон нутгийн санаачлага хөтөлбөрт “Нийтийн эзэмшлийн хогийн савны тоог нэмэгдүүлэх” төсөл хүргүүлсэн. Мөн аймгийн БОЭТөвийн аюултай хог хаягдлыг устгах зуухыг шинэчлэх ажлыг Чех улсын элчин сайдын яамны тусламжтай хэрэгжүүлэх саналыг уламжилсан бөгөөд орон нутгийн засаг захиргааны байгууллагын зүгээс орон нутгийн төсвийн хөрөнгөөр барилгын ажлыг хийж гүйцэтгэхээр зураг, төсвийг хийж гүйцэтгэсэн. Мөн Арвайхээр сумын “Нартын гүнд” хоршоо нь Канадын сангийн төсөл хөтөлбөрийн хүрээнд “Хог хаягдлын менежмент” төслийг ЕБ-ын сургуулиудад хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын хогийн сав байрлуулсан.</p>	100	70

	<p>нийгмийн асуудлыг дэс дараатай шийдвэрлэнэ.</p>	<p>хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх</p>	<p>онд “Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийн хүрээнд ЗДТГазар, Багийн ажлын алба болон Хотын захирагчийн албанд нийт 12 нөүтбүүк, 3 суурин компьютер, 10 ширээ, 6 шүүгээ, 4 принтер, 5 сандал, 1 ус буцалгагчийг ус шүүгчийн хамт худалдан авч нийт 36325250 төгрөг зарцуулж, компьютер, ширээ сандал, техник тоног төхөөрөмжийг нэмэгдүүллээ. Улсын төсвийн 60.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ЗДТГазрын барилгад дээвэр, гадна пасад, зарим өрөөний засвар, гэрэлтүүлгийн хамт хийсэн. Аймгийн төсвийн 400.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1,2,7,9,12 дугаар багийн төвийг, спортын заалтын хамт ашиглалтад оруулж, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 5.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3 дугаар багийн төвийн барилгыг засварт оруулснаар нийт албан хаагчдын ажиллах орчин нөхцөл сайжирсан</p>	<p>100</p>	<p>70</p>
		<p>215. Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавжуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулах</p>	<p>2017-2018 онд Төрийн албан хаагчдыг чадваржуулах, мэргэшүүлэх ажлын хүрээнд сумын ЗДТГазраас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг зорилтот сургалтыг төрийн албан хаагчдын дунд зохион байгуулж, давхардсан тоогоор 620 албан хаагчийг хамруулан 2 мэргэжилтнийг Япон, БНХАУ-д улсад мэргэшүүлэх сургалтанд тус тус хамруулж чадваржууллаа. ОНЗЗ-ны байгууллага, харъяа төсөвт байгууллагын холбогдох албан хаагчдад 2017 онд шинээр батлагдсан болон шинэчлэн найруулсан хуулиуд, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын танилцуулга, сургалт мэдээллийг хийж, арга зүйгээр хангаж ажиллалаа. ДЗОУБ-ын Өвөрхангай ОНХХ-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр ОНЗЗ-ны байгууллагын албан хаагчдад Улаанбаатар хотын МУХАкадемийнЛектор Л.Найдангийн “Хувь хүний манлайлал”, “Амжилтын хөтөч” сэдвээр 10 цагийн сургалтыг зохион байгуулж, 79 албан хаагчийг</p>	<p>100</p>	<p>70</p>



			хамруулж, ажлын хариуцлага, ур чадварыг нь нэмэгдүүлээ.		
87.	5.1.3 Төрийн албан хаагчдын цалин, нэмэгдлийг ажлын бүтээмж, иргэдэд үзүүлсэн үйлчилгээний чанар, бүтээмжтэй уялдуулж олгодог зарчмыг баримтлан төрийн үйлчилгээг иргэдээр үнэлүүлэх, үнэлгээний дүнг үйл ажиллагаанд ашиглана.	216. Төрийн албан хаагч бүрийн цалинг ажлын цаг, бүтээмж, үүргийн биелэлт, үйлчилгээний чанартай нь уялдуулан шатлал, зэрэг дэв, ур чадварын нэмэгдлийг тооцож олгодог зарчимд шилжүүлэх	<p>2017 оны 1 дүгээр сард албан хаагчдын 2016 оны үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээг үнэлж дүгнэсэн дүнг хэлэлцэж, ажлын үр дүнгээр 2017 оны цалинг шинэчлэн тогтоолоо.</p> <p>2016 оны үр дүнгийн гэрээг А, В үнэлгээтэй дүгнүүлсэн сумын ЗДТГазар, багийн Засаг дарга нарын албаны төрийн жинхэнэ албан хаагч 20 хүнд Төрийн албаны зөвлөлийн (2012 он) 137 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин (үр дүнгийн гэрээний биелэлт)-г үнэлэх журам”-ыг үндэслэн үр дүнгийн 2.2 сая төгрөгийн урамшуулал олгохоор, мөн төрийн жинхэнэ 2 албан хаагчийн албан тушаалын цалингийн шатлалыг ахиулахаар, төрийн үйлчилгээний 5 албан хаагчид, (1995 он) 96 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын дагуу ур чадварын нэмэгдлийг тус тус олгохоор шийдвэрлэв.</p> <p>Засгийн газар, Сангийн яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу энэ оны 12 дугаар сард сумын дүнгээр 793 төрийн албан хаагчид 237.9 сая төгрөгийн нөхөн олговор олгов. 2018 онд Өмнөх оны үйл ажиллагааны үр дүнгээр хангалттай сайн үнэлгээ авсан, үүрэг даалгаврыг гүйцэтгэл сайтай биелүүлж байгаа 35 албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж, Итгэлт хамба, Улан-Үүд хотоор аялах эрхийн бичгээр шагнаж, урамшуулсан. Дээрх ажилд Төсвийн урамшууллын зардлаас 8500000 /найман сая таван зуун мянга/ төгрөгийг зарцуулсан. 2017 оны төсөв санхүүгийн сахилга бат, хариуцлага, санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг үндэслэн Засаг даргыг 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгосон.</p>	100	70

		217. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг хөндлөнгийн байгууллага болон иргэд, үйлчлүүлэгчдээр үнэлүүлэх, үр дүнг тооцох	2017-2018 онд Хэрэглэгчийн үнэлгээг хөндлөнгийн байгууллага болох "Оновчтой хөгжил" ТББ-р гүйцэтгүүлж, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал: Төрийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, иргэд, олон нийтийг мэдээ мэдээллээр хангах зорилгоор шинээр веб сайт ажиллуулж, сонин сэтгүүл гарган ажиллаж байна.	100	70
88.	5.1.4 Төрийн үйлчилгээний нэгдсэн төв байгуулж, үйлчилгээний төрлүүдийг нэмэгдүүлэн төрийн үйлчилгээнд ахиц гаргаж, орон нутгийн засаг захиргааны болон харьяа төсөвт байгууллагын угтах үйлчилгээг тогтмолжуулан иргэдийг зөвлөгөө, мэдээллээр хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, нээлттэй ил тод болгоно.	218. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд банк, нотариатын салбарыг байршуулан ажиллуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах	2017 онд Өвөрхангай аймгийн Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийг 2016 онд албан ёсоор байгуулж, үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Уг төвийг тус сумын ЗДТГазрын Нэг цонхны үйлчилгээний төвийг түшиглэн байгуулсан. 2017 оны эхний 11 сарын дүнгээр ТҮНТөвд өссөн дүнгээр нийт 18342 иргэндүйлчилсэн байна. 2018 онд Арвайхээр хотод олон жил ашиглагдаагүй байсан хуучин барилга болох 100 хүний гуанзны барилгыг шинэчлэн засварлаж, нэг давхарт нь төрийн үйлчилгээний нэгдсэн төвийг байгуулсан. Энэхүү ажлыг аймгийн орон нутгийн төсвийн 250.0 сая төгрөгийн эх үүсвэрээр засварлаж бүрэн ашиглалтад оруулснаар иргэд нэг цэгээс Төрийн үйлчилгээг түргэн шуурхай авч байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд Төрийн банк, Нотариат, Төрийн болон бусад нийт 20 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. ТҮНТөвд 11 сарын байдлаар хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлаар нийт 1448, нийгмийн халамж 2366, иргэний бүртгэл 9392, газрын харилцаа 2744, мэдээлэл зөвлөмж, угтах үйлчилгээ 1890, каноны үйлчилгээ 437 иргэнд тус тус үйлчилгээ үзүүлж, өссөн дүнгээр нийт 18277 иргэндүйлчилгээ үзүүлж ажилласан байна.	100	100
		219. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд төрийн нэг албан хаагчтай харьцах замаар иргэдийн тавьсан асуудлыг шийдвэрлэх, бүрдүүлэх бичиг баримтын нэр	Иргэдийг зөвлөгөө, мэдээллээр хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, нээлттэй ил тод болгох ажлын хүрээнд "Төрийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг зохион байгуулан 2000 гаруй иргэд оролцож, мэдээ мэдээлэл, зөвлөгөө авч, Төрийн 23 байгууллага нэгэн зэрэг нээлттэй ажиллаж, төрийн төлбөртэй үйлчилгээг төлбөргүй болон хөнгөлөлттэй үнээр иргэдэд үйлчилсэн. Тус сумын ЗДТГазар нь	100	100

	<p>төрлийг цөөтгөж, хялбаршуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх</p>	<p>www.arvaikheer.gov.mn цахим хуудсыг шинээр үүсгэн байгуулж, албан хаагчдын танилцуулга, утас, захирамж, тогтоол шийдвэр, тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материал, төлбөртэй үйлчилгээний жагсаалт, төсөв санхүү болон бусад мэдээ мэдээллийг ил тод, нээлттэй байршуулсан.</p>		
	<p>220. Орон нутгийн засаг захиргааны болон харьяа төсөвт байгууллагын угтах үйлчилгээг тогтмолжуулан иргэдийг зөвлөгөө, мэдээллээр хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, нээлттэй ил тод болгох</p>	<p>Өвөрхангай аймгийн Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийг Засгийн газрын “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 141 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2016 оны а/239 дүгээр захирамжийн дагуу нээлтийг 2016 оны 6 дугаар сард хийж, албан ёсоор үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Сумын “Угтах үдэх үйлчилгээний нийтлэг журам”-ын хүрээнд угтах, үдэх үйлчилгээний соёлыг бий болгон сургууль, цэцэрлэгүүд хэрэгжүүлж хэвшсэн. Сургуулийн орчинд сурагчдыг өглөө ирэхэд нь угтаж аван мэндлэх, үдэх, эцэг эх, иргэдийг угтан авч, сургуулийн орчинд соёлтой үйлчлэх зорилгоор ахлах ангийн сурагчид “Хөтөч сурагч”-аар ажиллан угтах үдэх үйлчилгээг үзүүлж байна. Сургуулийн жижүүрүүдэд тогтмол харилцаа хандлага, хүүхэдтэй хэрхэн харилцах талаар яриа таниулгыг хийж, хувцаслалтад нь анхаарч, энгэрийн тэмдэгтэй болгосон.СӨББайгууллага бие даасан жижүүртэй 2 цэцэрлэг байгаа ба бусад 7 цэцэрлэг нь жижүүр багшийг ажиллуулан өглөө, орой угтах үдэх үйл ажиллагааг зохион байгуулж, тайланг улирал бүр ТҮНТөвийн угтах үйлчилгээний ажилтанд хүргүүлж хэвшлээ.</p> <p>2018 онд Төрийн үйлчилгээний нэгдсэн төв ашиглалтад орж, Төрийн банк, Нотариат, Төрийн болон бусад нийт 20 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. ТҮНТөвд 11 сарын байдлаар хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлаар нийт 1448, нийгмийн халамж 2366, иргэний бүртгэл 9392, газрын харилцаа 2744, мэдээлэл зөвлөмж, угтах үйлчилгээ 1890, каноны үйлчилгээ 437 иргэнд тус тус үйлчилгээ үзүүлж, өссөн дүнгээр нийт 18277 иргэндүйлчилгээ үзүүлж ажилласан байна.</p>	100	70

89.	5.1.5 “Иргэний танхим”-ын үйл ажиллагааг тогтмолжуулж, нийгмийн өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхдээ иргэдийн дуу хоолойг сонсч, саналыг хүндэтгэн шийдвэртээ тусгадаг, тайлагнадаг тогтолцоог бүрдүүлнэ.	221. Сумын ИТХурлын дэргэдэх “Иргэний танхим”-ын үйл ажиллагааг тогтмолжуулж, шуурхай удирдлагын орон тооны бус зөвлөлийг ажиллуулах	Сумын ИТХурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 2 дугаар тогтоолоор “Иргэний танхим”-ын ажиллах журмыг шинэчлэн баталж, журмын дагуу үйл ажиллагаа явагдаж байна. Төрийн байгууллагын бодлого шийдвэрт иргэдийн саналыг тусгах зорилгоор нийгэмд тулгамдсан асуудлуудаар хэлэлцүүлгийг зохион байгуулж иргэдээс гарсан санал санаачлагыг холбогдох шийдвэрүүдэд тусган, санал, зөвлөмж, тогтоолыг холбогдох журмын дагуу хяналтанд авч хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр сумын ИТХТэргүүлэгчдийн хуралдаанд тайлагнан ажиллаж, үйл ажиллагаа нь тогтмолжсон. "Хэрэглэгчийн зөвлөлийг" шуурхай удирдлагын орон тооны бус хэлбэрээр ажиллуулж, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна.	100	70
		222. “Иргэний танхим”-д тулгамдсан асуудлуудаар хэлэлцүүлэг зохион байгуулан иргэдийн дуу хоолойг сонсч, саналыг хүндэтгэн шийдвэртээ тусгах, зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж, тайлагнадаг тогтолцоог бүрдүүлэх	“Иргэний танхим”-д 2018 онд зохион байгуулагдах ажлын төлөвлөгөөний дагуухэлэлцүүлэг2, БИНХуралдаан 6, байгууллагын албан хаагчдын шуурхай хуралдаан 19, ИТХурал, ЗДТГазар, ХЗАлбаны албан хаагчид, харьяа төсвийн байгууллага, зорилтот бүлгүүдийг хамарсан сургалт, ажлын хэсгийн хурал 32удаа зохион байгуулагдаж, нийт 50 гаруй арга хэмжээнд давхардсан тоогоор 3000 гаруй иргэн хамрагдсан. Төрийн байгууллагын бодлого шийдвэрт иргэдийн саналыг тусгах зорилгоор нийгэмд тулгамдсан асуудлуудаар хэлэлцүүлэгийг зохион байгуулж иргэдээс гарсан санал санаачлагыг холбогдох шийдвэрүүдэд тусган, санал, зөвлөмж, тогтоолыг холбогдох журмын дагуу хяналтанд авч байна. Иргэний танхимд зохион байгуулагдаж байгаа ажлууд Арвайхээрийн мэдээ пэйсбүүк групп, Arvaikheer.uv.gov.mn сайтуудад байрлуулан олон нийтэд мэдээллэсэн.	100	70
90.	5.1.6 Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, үйлчилгээний чанар хүртээмж, үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор	223. Засагзахиргааныанханш атнынэгжбагийнтоогнэм эгдүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлэх,	Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, үйлчилгээний чанар хүртээмж, үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор Аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2017 оны 63 дугаар тогтоолын дагуу Зүлэгтийн 12, Онгийн 13 дугаар багуудыг шинээр байгуулж, хаягийн зураг, үл хөдлөх эд	100	100

	засаг захиргааны анхан шатны нэгж багийн тоог нэмэгдүүлж, багийн Нэгдсэн төвийг шинээр барина.	зохионбайгуулалтынарга хэмжээгавах	хөрөнгө, гэр хорооллын хаягийн жагсаалтуудыг шинээр батлуулсан. Дээрх багуудын БИНХурлыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулаад байна.		
		224. Төрийн үйлчилгээний чанар хүртээмж, үр дүнг дээшлүүлэх зорилгоор хэсгийн ахлагч нарыг урамшуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлэх	Үнэлэх боломжгүй		
91.	5.1.7 Хувийн хэвшил, мэргэжлийн холбоодын саналыг орон нутгийн бодлого шийдвэрт тусгаж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөтгөн төрийн зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллага, хувийн хэвслээр гүйцэтгүүлнэ.	225. Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх төрийн ажил үйлчилгээний ажлын жагсаалтыг жил бүр баталж, хэрэгжүүлэх	Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх төрийн ажил үйлчилгээний жагсаалтыг жил бүр баталж, хэрэгжүүлж байна. Төрийн ажлыг олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, тэдний санал хүсэлтийг авч, цаашдын бодлого шийдвэрт тусгах зорилгоор Өвөрхангайн толь сонин, Ноён Уул FM радио, Хас телевиз, www.arvaikheer.gov.mn (www.arvaikheer.mn цахим хуудсыг шинэчилсэн) зэрэг газруудтай гэрээ байгуулан ажиллаж, нийт 7,0 сая төгрөг зарцуулсан. Төв захын захын ойр орчмын машины зогсоол, хууль бус худалдаа эрхлэлт зэрэг иргэдээс байнгын гардаг санал, гомдлыг шийдвэрлэх зорилгоор "Арвайхээр тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГазрын зарим чиг үүргийг "Хас заан" ХХК-д шилжүүлж, мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна.	100	70
		226. Төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэн, ТББ-ын хяналт тавих боломжийг өргөтгөж, тэдний санал санаачлагыг цаашдын бодлого зорилт, шийдвэр, үйл	2017-2018 онд Аймгийн Засаг даргын 2017 оны А/552 дугаар захирамжийн дагуу захиргааны байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгааг Төрийн бус байгууллагаар үнэлүүлэх ажлыг зохион байгуулж, "Оновчтой хөгжил" ТББ-тай гэрээ байгуулж ажиллаж, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ онд Төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авах ажиллагааны үнэлгээний хороо, сум хөгжүүлэх сангийн	100	70

		ажиллагаанд тусган хэрэгжүүлэх	төсөл сонгон шалгаруулалтанд давхардсан тоогоор 54 иргэн, Төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж, шийдвэр гаргах үйл ажиллагаанд тэдний саналыг тусгасан.		
92.	5.1.8 Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын дотоод хяналт шалгалтын нэгжийн үйл ажиллагааг тогтмолжуулж, үйлчилгээ болон менежментийг сайжруулна.	227. ОН33-ны байгууллага, “Арвайхээр-тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГазар, төсөвт байгууллагуудын дотоод хяналт шалгалтын нэгжүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагааг тогтмолжуулах	Орон нутгийн Засаг захиргааны байгууллагын Дотоод хяналт шалгалтын нэгжийг Засаг даргын 2017 оны а/136 дугаар захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулсан. 2017 онд харьяа төсөвт байгууллагад түүврийн аргаар 5 байгууллагыг сонгон удирдлагын тушаал шийдвэрийн эрх зүйн үндэслэл, архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, дотоод хяналт шалгалтын нэгжийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, арга зүйгээр хангаж ажиллалаа. Шалгалтын дүнг нэгтгэн зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Сумын ИТХурал, ЗДТГазар, ХЗАлба, БЗДНАлбаны нийт 45 албан хаагчаас 2018 онд зохион байгуулах хяналт шалгалтын саналыг авч, 5 ажлыг зохион байгуулахаар төлөвлөж, 3 удаагийн хяналт шалгалтыг Засаг дарга, ЗДТГазрын даргаар батлуулсан удирдамжийн дагуу зохион байгуулж, тайлагнав. Энэ онд Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар нь бүтэц орон тоо салж шинээр Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГазар байгуулагдсан тул Дотоод хяналтын нэгжийг байгуулах талаар заавар, зөвлөгөө өгч байгууллагын даргын 2018 оны 08 сарын 24-ний өдрийн А/11 тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй нэгж байгуулагдан ажиллаж байна.	100	70
		228. Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрт дотоод аудит хийх замаар эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, зөвлөн туслах үйл ажиллагааг чанаржуулах	Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа Төсөл арга хэмжээнд сумын ИТХурлын төлөөлөгчид хяналт тавьж, эрчимжүүлж, үр ашгийг нэмэгдүүлж ажилласан.	70	40

93.	5.1.9 Төрийн байгууллагын үйл ажиллагааг тогтмол сурталчилахад зориулан хөрөнгө төлөвлөж, телевизийн нэвтрүүлэг, улирал тутмын сонин, сэтгүүлийг бэлтгэж, иргэдийг цахим мэдээллээр хангах үйл ажиллагааг сайжруулна.	229. Сумын ЗДТГазрын хэвлэл мэдээллийн техник хэрэгслийг шинэчлэн сайжруулах	Сумын ЗДТГазрын хэвлэл мэдээллийн техник хэрэгслийг шинэчлэн, Компьютер i7-4100, Дэлгэц Asus VA249, Сервер i7-8700k, Hard ssd-120gb, Dell keyboard, YN560 маркын гэрэл зургийн аппаратны гэрэл, VCT-690 маркийн гэрэл зургийн аппаратын хөл гэх мэт техник хэрэгслийг шинэчлэлийг хийж өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна.	100	100
		230. Төрийн байгууллагын үйл ажиллагааг тогтмол сурталчилахад зориулж, орон нутгийн төсөвт жил бүр зардлыг тусган хэрэгжүүлэх	Хас телевиз, Ноён-Уул” FM радио, Өвөрхангайн толь, www.arvaikheer.gov.mn цахим хуудас, зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нийт 9.0 сая төгрөгний гэрээ байгуулж хамтарч ажилласан.	100	70
		231. ОНЗЗ-ны байгууллагаас улирал тутмын сонин, сэтгүүлийг бэлтгэн гаргах, телевизийн нэвтрүүлэг, сайт, цахим мэдээллийг шинэлэг хэлбэрээр иргэдэд шуурхай хүргэх	2018 онд ОНЗЗ-ны байгууллагаас гарах өдөр тутмын хэвлэлийн эх бэлтгэл болох сумын Засаг дарга, ИТХурлын “Жуух бичиг”, Өргөмжлөл, Дурсамж, Эрхийн бичиг, Тусгай зөвшөөрөл, энгэрийн тэмдэг, нүүр, тасалбар, урилга, хаягийн эх бэлтгэлийг хийж хэвлэн гаргаж байна. <a href="http://www.arvaikheer.uv.gov.mn">www.arvaikheer.uv.gov.mn</a> вэб сайтыг шинээр байгуулж, 7 хоногт 3-аас доошгүй мэдээлэл нийтэлж, албан хаагчид өөрийн ажил үйлчилгээтэй холбоотой мэдээллийг сард 2-оос доошгүй удаа нийтлэн мэдээллэж байна. Мөн +5000 гишүүнтэй “Арвайхээрийн Мэдээ” фэйсбүүк хаягийг ажиллуулж нэг удаагийн цаг үеийн шинжтэй мэдээ өдөрт давхардсан тоогоор 20.000 хүнд нэгэн зэрэг хүргэж байна. “Ноён-Уул” FM, “ХАС” ТВ-тэй цаг үеийн холбогдолтой ярилцлага нэвтрүүлэг, зар, мэдээ, мэдээллийг тогтмол график, цагийн хуваарийн дагуу хүргэж хамтран ажилласан.	100	70
94.	5.1.10 Нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлыг иргэд, олон нийтийн	232. ОНЗЗ-ны байгууллага болон төсөвт байгууллагуудад	“Иргэний боловсрол” хөтөлбөрийн хүрээнд сургалт, мэдээллийн нэгдсэн төлөвлөгөөг 3 зорилт, 19 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр батлуулж, 16 сургалт	100	70

	<p>эрэлт хэрэгцээнд нийцүүлэн зохион байгуулж, эрүүл мэндийн боловсролын түвшин, хууль зүйн туслалцааны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.</p>	<p>“Эрх зүйн сургалт сурталчилгааны хөтөлбөр” хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх</p>	<p>мэдээллийн ажлыг зохион байгуулж, давхардсан тоогоор 2061 иргэн хамрагдан эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн. 2017 онд төрийн албан хаагчдын дунд 2 зорилтын хүрээнд 8 удаагийн арга зүйн сургалтыг төлөвлөж, 7 сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулж, давхардсан тоогоор 428 албан хаагчийг хамруулан чадваржууллаа. Тухайлбал: 3, 4 дүгээр сард ОНЗЗ-ны байгууллага, харьяа төсөвт байгууллагын холбогдох албан хаагчдад 2017 онд шинээр батлагдсан болон шинэчлэн найруулсан хуулиудын танилцуулга сургалт, мэдээллийг хийсэн бол 11 дүгээр сард төсөвт байгууллагуудын холбогдох албан хаагчдад хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх чиглэлээр 6 цагийн сургалт зохион байгуулсан бол 2018 онд шинээр батлагдсан хуулиуд болон төрийн албан хаагчийн зайлшгүй мэдвэл зохих 30 хуулиар сургалтын материал бэлтгэж, Орон нутгийн захиргааны байгууллагын 86 албан хаагчдад 50 цагийн арга зүйн сургалт зохион байгуулсан.</p>		
		<p>233. Нийгмийн зорилтот бүлэгт чиглэсэн эрх зүйн сургалт сурталчилгааг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын хамтын үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулж, үр дүнг тооцох</p>	<p>Сумын хууль, тогтоомжийн лавлагаа, мэдээллийн санг 2010 оноос хойш огноо, дугаараар ялгаж, мэдээлэл авахад ойлгомжтой байдлаар товъёог хийн цэгцэлсэн. Төрийн мэдээлэл сэтгүүлийн товъёогийг хөтөлж, хууль, тогтоомжийн лавлагаа, мэдээллийн сангаас албан хаагч нарт хэрэгцээт мэдээллийг өгч хэвшсэн. 2018 оны байдлаар ОНЗЗ-ны байгууллагын давхардсан тоогоор 255 албан хаагч, харьяа төсөвт 16 байгууллагад эрх зүйн мэдээлэл, зөвлөмжийг өгч ажилласан. Жил бүр багуудад хэрэгжүүлэн ажиллах үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрүүдийн жагсаалтыг нэгдүгээр улиралд багтаан баталж, үүрэг чиглэл өгснөөр багуудад “Иргэний боловсрол” хөтөлбөрийн хүрээнд эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлсэн. 13 багийн дүнгээр 2018 оны байдлаар төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зорилтот бүлгүүдэд чиглэсэн 64 удаагийн сургалт, мэдээллийг</p>	100	70



			<p>зохион байгуулж, 4553 гаруй иргэнийг хамруулсан байна.</p> <p>ЕБ-ын сургуулийн захирал, СӨББ-ын эрхлэгч, ӨЭМТөвийн дарга нартай сумын Засаг дарга үр дүнгийн гэрээг боловсруулахдаа төрийн албаны стандарт, архив, албан хэрэг хөтлөлт, тогтоол, шийдвэрийн биелэлт, эрх зүйн сургалт, сурталчилгааны биелэлтийг хангах, бусад цаг үеийн ажлын чиглэлийн ажлыг тусгаж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцож хэвшсэн.</p>		
		<p>234. Эрүүл мэнд, хууль эрх зүйн чиглэлээр чадавхжсан, мэргэшсэн сургалтын багийг байгуулж, сургалт сурталчилгааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлж ажиллах</p>	<p>Засаг захиргааны анхан шатны нэгж багийн Нийгмийн ажилтнуудыг эрүүл мэнд, хууль эрх зүйн чиглэлээр жил бүр төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулдаг сургалтанд хамруулж, сургагч багшаар чадваржуулж байна. Сургалтын чанар, үр дүнг сайжруулах үүднээс сумын Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/280 захирамжаар “Сургалтын баг”-ийн гишүүдийг баталж, ТЗАХариуцсан түшмэлээр ахлуулсан “Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах”, НБАХариуцсан түшмэлээр ахлуулсан “Эрүүл мэндийг боловсролыг дээшлүүлэх, эрүүл аж төрөх арга ухаанд суралцуулах”, НТБ-ын арга зүйчээр ахлуулсан “Амьдрах ухаанд суралцуулан харилцааны үнэт чанаруудыг эзэмшүүлэх” чиглэлээр тус тус сургалтын дэд баг байгуулан, 3 зорилтын хүрээнд 9 ажил арга хэмжээ төлөвлөж, 100 хувь хэрэгжилттэй байна. Түүний дотор шинээр батлагдсан хуулиуд болон төрийн албан хаагчийн зайлшгүй мэдвэл зохих 30 хуулиар сургалтын материал бэлтгэж, Орон нутгийн захиргааны байгууллагын 86 албан хаагчдад 50 цагийн арга зүйн сургалт зохион байгуулсан.</p>	100	70
95.	<p>5.1.11 Төрийн болон төсөвт байгууллагын албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагааг стандартад нийцүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж,</p>	<p>235. ОНЗЗ-ны байгууллага, харьяа төсөвт байгууллагуудын архивын баримтыг цахим санд бүрэн шилжүүлэх</p>	<p>Тус сумын ЗДТГазарт 2017-2018 онд ирсэн бичиг 831, үүнээс хугацаатай /хариутай/ 165, Засаг даргын явуулсан бичиг 1415, ЗДТГазрын явуулсан бичиг 509, өргөдөл, гомдол 510 ирсэн бөгөөд архив, албан хэрэг хөтлөлтийн програмд бүртгэл, шийдвэрлэлтийг оруулсан. Мөн удирдлагын баримт бичиг буюу Засаг</p>	100	70

	цахим санд бүрэн шилжүүлнэ.		даргын захирамж үндсэн үйл ажиллагааны буюу А-464, боловсон хүчний буюу б-33, ЗДТГазрын даргын тушаал үндсэн үйл ажиллагааны буюу А-50, боловсон хүчний буюу б-70-ыг тус тус цахим хэлбэрт оруулсан.		
		236. Байгууллагын архивын өрөө тасалгааг өргөтгөн тохижуулж, стандартад нийцүүлэх	Улсын төсвийн 60.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ЗДТГазрын барилгад дээвэр, гадна пасад болон зарим өрөөнүүдийн засварыг гэрэлтүүлгийн хамт хийгдсэн. Тус ажлыг "Чусан" ХХК хийж гүйцэтгэсэн бөгөөд архивын өрөөний байршлыг өөрчилж, засвар хийж хүлээлгэн өгсөн.	100	100
		237. ОНЗЗ-ны байгууллага, төсөвт байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудыг үе шаттай сургалтанд хамруулж, чадавжуулах, сургагч багш бэлтгэх	Аймгийн Архивын тасаг, мөн сумын ЗДТГазрын сургалтын хуваарийн дагуу харьяа байгууллагуудын архив бичиг хэргийн ажилтан, хавсран гүйцэтгэдэг ажилтан албан хаагчдыг тогтмол сургалтад хамруулж, 2017-2018 оны байдлаар Архивын ерөнхий газрын захиалгат мэргэшүүлэх болон анхан шатны сургалтуудад цэцэрлэг, сургуулийн нийт 12 албан хаагч мэргэшүүлэх сургалтад хамруулав.	100	70
96.	5.1.12 Хүний эрхийг хангах, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, захиргааны шийдвэр гаргах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	238. Авлигын эсрэг сумын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, зардлыг орон нутгийн төсөвт жил бүр тусган хэрэгжүүлэх	Авилга, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг аймгийн 2016-2018 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг 2018 оны 9 дүгээр сарын дүнгээр нэгтгэн тооцоход 13 үйл ажиллагаа бүрэн хэрэгжсэн 100 хувь, 7 үйл ажиллагаа хэрэгжих шатанд 90 хувь, 1 үйл ажиллагаа хэрэгжих шатанд 30 хувь, 1 үйл ажиллагааг үнэлэх боломжгүй үнэлгээний дундаж 93.3 хувьтай. 2017-2018 онд нийт 9,0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгаж, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.	100	70
		239. Орон нутгийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, авлига, хүнд суртлыг бий болгоход нөлөөлж буй холбогдох дүрэм, журмыг хялбарчлах,	Иргэдийн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, орон нутгийг хөгжүүлэх чиглэлээр гарч байгаа шийдвэрт иргэдийн санал бодлыг тусгах чиглэлээр багийн ИНХ-аар иргэдээс гарсан санал болон ОНХСан зэрэг бүтээн байгуулалтын ажлыг иргэдийн саналд үндэслэх зэргээр шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангаж ажиллаж байна. Төрийн үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг хангах	100	70

		хүчингүй болгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх	<p>чиглэлээр ОНЗЗ-ын байгууллагын угтах үйлчилгээний орчинд санал хүсэлтийн хайрцгийн нэмэгдүүлж, “Санал хүсэлтийн хайрцаг ажиллуулах заавар”-ыг батлуулан мөрдөн ажиллахаас гадна албан хаагчдын авилга, хүнд сурталтай холбогдох мэдээллийг <a href="http://www.arvaikheer.gov.mn">www.arvaikheer.gov.mn</a> цахим хуудсаар ил тод нээлттэй хүлээн авч байна. байна.</p> <p>Тус байгууллагын хууль эрх зүйн нэгдсэн санд бүртгэлтэй, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Захиргааны хэм хэмжээ тогтоосон 8 шийдвэрийн судалгаагаймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсээр уламжлан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулахаар хүргүүлсэн. Энэ онд хэм хэмжээ тогтоосон сумын ИТХурлын 2 тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу материалыг бүрдүүлж Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлээд байна.</p>		
		240. Хүний эрхтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хөндлөнгийн хяналт тавих ажлыг төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	Үнэлэх боломжгүй		
97.	5.1.13 Төрийн үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээний шуурхай байдлыг дээшлүүлэх зорилгоор хаягжуулалтыг цэгцлэн иргэний бүртгэлийн зарим үйлчилгээг хүргэнэ.	<p>241. Иргэдийн хаягийн шинэчилсэн бүртгэлийг бүрэн хийж, хаягийн стандартад нийцүүлэх</p> <p>242. Иргэний бүртгэлийн зарим үйлчилгээг цахимаар хүргэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх</p>	<p>Сумын дүнгээр иргэдийн хаягийн шинэчилсэн бүртгэл 12 сарын байдлаар 98 хувьтай байна.</p> <p>2018 онд Иргэний бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, <a href="http://www.burtgel.mn">www.burtgel.mn</a> цахим хуудсаар дамжуулан цахимаар иргэний бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх нөхцөл бүрдсэн. Тухайлбал: Цахим үнэмлэхийн лавлагаа, Оршин суугаа хаягийн лавлагаа, гэрлэсэн эсэх лавлагаа, төрсний бүртгэлийн лавлагаа зэрэг нийт 20 гаруй үйлчилгээг</p>	100	100
				100	70

			цахимаар шууд авах боломж бүрдсэн.		
98.	5.1.14 Арвайхээр суманд Цагдаагийн тасаг байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, нийгмийн хэв журмыг хангах ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтанд оруулна.	243. Арвайхээр сумын Цагдаагийн тасгийг байгуулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх 244. Сумын ГХУСАЗСЗөвлөлийн үйл ажиллагааг хамтарсан багаар хэрэгжүүлж, Иргэн-Олон нийтийн зөвлөл, хэсгийн ахлагч нарын урамшууллын асуудлыг судалж, шийдвэрлүүлэх	цахимаар шууд авах боломж бүрдсэн. Үнэлэх боломжгүй “Олон нийт-цагдаа хамтын ажиллагаа” хөтөлбөрийн хүрээнд 13 багт хэсгийн цагдаа 4, Олон нийтийн цагдаа 5, Иргэн-Олон нийтийн зөвлөлийн 15 гишүүн ажиллаж байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хамгаалах ажлын хүрээнд Иргэн-олон нийтийн зөвлөлийн урамшуулалт эргүүл, хэсгийн ахлагч нарыг Цагдаагийн газартай хамтран удирдлага, арга зүйгээр ханган, зөвлөгөө өгч ажиллаж байна. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 16 дугаар тогтоолоор Нийгмийн хэв журам, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд төвлөрүүлэх мөнгөн дүнг улиралд 20000 /хорин мянга/, жилд 80000 /наян мянга/ төгрөгөөр тогтоож, уг зардлыг суманд үйл ажиллагаа явуулж байгаа албан байгууллага, аж ахуй нэгжүүдээс төвлөрүүлэхээр жагсаалтаар баталсаны дагуу хөрөнгийн төвлөрөлт 10 хувьтай байна. Цагдаагийн газраас ирүүлсэн тайлангын дагуу Иргэн-Олон нийтийн зөвлөлийн гишүүдийн 1, 2 дугаар улиралын урамшуулалд 840.000 төгрөг олгосон, 3, 4 дүгээр улиралын урамшууллыг Цагдаагийн газраас ирүүлэх тайланг харгалзан 12 дугаар сард багтаан олгохоор төлөвлөсөн.	100	70
99.	5.1.15 Олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах ажлын хүрээнд “Хөршийн холбоо”, “Аддиктологийн баг”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулж, олон	245. Сумын “Аддиктологийн баг”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулж, зорилтот бүлэгт чиглэсэн бүлэг, иргэний нийгмийн байгууллагыг дэмжин хамтран ажиллах	Сумын Аддиктологийн баг нь 2016 оноос 27 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж, зорилтот бүлэгт хандсан нийгмийн ажлуудыг БОЭТөвийн Наркологимансуурлын эсрэг төв,АА-ын бүлэг, Цагдаагийн газартай хамтран зохион байгуулж ирсэн. Баг тус бүр архины хамааралтай иргэдийн судалгааг гаргаж харъяа ӨЭМТөвтэйгээ хамтран иргэддээ чиглэсэн арга хэмжээ, сургалт сурталчилгаа төлөвлөн	100	70

нийтийн зөвлөл, нөхөрлөл, бүлгэмийн үйл ажиллагааг бүх талаар дэмжин "Архидалтгүй Өвөрхангай" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ		ажиллаж хэвшсэн. Дээрх ажлуудын хүрээнд 2018 оны байдлаар БОЭТөвийн Сэтгэц-Наркологийн тасагт архины гүн хордлогод орсон архины хамааралтай 111 иргэнийг хэвтүүлэн хордлого засал тайлах болон сэтгэл заслын эмчилгээ хийлгэсэн бол сайн дурын архигүй нөхөрлөлийн 6 бүлэг БОЭТөвд 7 хоног бүрийн Баасан гарагт батжуулах эмчилгээг хийж хэвшлээ. Архины хамааралтай иргэдийн сэтгэл зүй, амьдрах итгэл үнэмшлийн тухай нийгэмшүүлэх сургалтанд 156 хамруулсан байна. Мөн АА-ын нээлттэй үйл ажиллагаанд шинээр 10 иргэнийг хамруулж архинаас татгалзаад байна. Монголын АА-ын бүлгийн тэргүүн болон орон нутаг дахь АА-ын бүлгийн ахлагч нар сумын удирдлагууд болон холбогдох мэргэжилтэн, багийн ЗДАА, ӨЭМТөвийн нийгмийн ажилтнууд нийт 40 ажилтныг оролцуулан ажил хэргийн уулзалтыг хийж хамтран ажиллах талаар санал солилцож хамтын ажиллагаагаа бэхжүүллээ.		
	246. Баг бүрт хөршийн холбоог байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагааг тогтмолжуулах	Аймгийн Цагдаагийн газраас санаачлан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах, төрийн байгууллага, албан тушаалтан, иргэдийн хамтын ажиллагааг өрнүүлэх зорилгоор сумын хэмжээнд "Хөршийн холбоо байгуулах, ажиллуулах, үр дүнг тооцох журам"-ыг сумын ИТХурлын 2015 оны 26 дугаар тогтоолоор батлуулсан. "Айл хүний амь нэг, саахалт айлын санаа нэг" гэсэн сэтгэл зүйг иргэдийн дунд төлөвшүүлэх, төрийн байгууллага, албан тушаалтан, иргэдийн хамтын ажиллагааг өрнүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулж, иргэний үүргийн биелэлтийг хангуулах зорилгоор 10-15 хашаа бүхий гудамжны айл өрхүүдийг хамруулж нэг хөршийн холбоог байгуулж, 5-аас багагүй хөршийн холбоодын дунд нэг "Төрийн алба хаагчдын баг" ажиллах юм. Иргэд, хөршийн холбоодын үйл ажиллагаанд, хөршийн ахлагч, төрийн алба хаагчдын баг харилцан, төрийн алба	100	70

			<p>хаагчдын багийн үйл ажиллагаанд сумын ГХУСАЗСЗөвлөл тус тус хяналт тавьж ажиллахаар журмалсан. Баг тус бүрд “Хөршийн холбоо” байгуулан ажиллах талаар БИНХурлууд, багийн иргэдэд тогтмол танилцуулан сурталчилж, одоогоор Арвайхээр сумын 4, 6, 7, 8, 11 дүгээр багуудад “Хөршийн холбоо”-г байгуулан цагдаагийн газраас мэргэжил арга зүйгээр ханган, урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөгөөг өгсөнөөр ажлын үр нөлөө дээшилж, үйл ажилгаа тогтмолжсон. Хөршийн холбоо байгуулан ажилсанаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оршин суугчид, иргэний нийгмийн байгууллагууд тэр дундаа сууц өмчлөгчдийн холбоо, сайн дурын иргэдийн хүч дэмжлэгийг авах, нутгийн захиргааны болон цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны уялдаа холбоог нэмэгдүүлэх төдийгүй гэр, ахуйн хүрээнд үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэр дундаа гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, иргэдийн оролцоо, эрх бүхий байгууллага, албан тушаалтны дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа нэтгэн зохион байгуулж ахуйн хүрээнд үйлдэгдэж буй хууль бус үйлдлүүдийг саармагжуулах, бууруулах ажилд ахиц гарах явдал юм.</p>		
		<p>247. “Архидалтгүй Өвөрхангай” хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг тооцож, хорт зуршлын эсрэг хөдөлгөөн, аян зохион байгуулах</p>	<p>Архидалгүй Өвөрхангай хөтөлбөр 2014-2017 онд хэрэгжиж зохих үр дүнгээ өгч хөтөлбөрийн биелэлт аймгийн хяналт шинжилгээ үнэлгээгээр 94 хувьтай үнэлэгдсэн. Уг хөтөлбөрийг 2018-2020 хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-аас шийдвэр гарч шинээр хувийн хэрэг нээн үр дүнг тооцон ажиллаж байна. Энэ онд хорт зуршлын эсрэг хөдөлгөөн, аян зохион байгуулах хүрээнд байгууллагын албан хаагчид ажлын цагаар согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, шөнийн болон ажлын бус цагаар хэсэг бүлгээрээ архидан согтуурахгүй байх талаар албан хаагч нэг бүрээс баталгаа гаргуулж авсан.</p>	100	70
100.	5.1.16 Сумын болзошгүй цагийн байдлын үед	248. Гарч болзошгүй гамшиг ослын үед	<p>2017, 2018 оны Сумын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, шинэчилсэн.</p>	100	70

	хэрэглэх нөөц хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, Гамшгаас хамгаалах хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх, мэргэжлийн ангиуд, албадын сургалт дадлагыг тогтмолжуулан бэлэн байдлыг хангана.	гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг шинэчлэн хэрэгжүүлэх			
		249. Мэргэжлийн ангиуд, албадын сургалт дадлагыг тогтмолжуулан, бэлэн байдлыг хангах, сургууль зохион байгуулах	Сумын онцгой комиссын гишүүд, мэргэжлийн ангиудын бүрэлдэхүүнийг сумын Засаг даргын 2018 оны 287, 288 дугаар захирамжаар тус тус шинэчлэн байгуулж, байнгын бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Арвайхээр сумын Дэлгэрэхийн 3 дугаар багийн “Түгий овооны ар”, Өлзийтийн 4 дүгээр багийн 36 дугаар гудамж, Олон худгийн энгэр, Талын худаг гэдэг газруудад 11 малчин өрхийн малд мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин илэрч Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторийн шинжилгээний дүнгээр тогтоогдсон тул Арвайхээр сумын Засаг даргын 2018 оны а/30 “Хорио цээрийн дэглэм тогтоох тухай” дугаар захирамж гарган, голомт болон сэжигтэй бүсэд мал, амьтны шүлхий өвчинтэй тэмцэх зааврыг хангаж ажилласны үр дүнд мал, амьтанд шүлхий өвчний шинж тэмдэг дахин илрээгүй тул хорио цээрийг цуцлан ажилласан. Устгалын комисс 6 хүн, хяналтын комисс 3 хүн нийт 9 албан хаагчид бэлэн байдлын үзлэгт хамрагдан томилогдож, 2018 оны 3 дугаарын 09-нөөс 3 дугаар сарын 17-ний өдрүүдэд мал, амьтныг зориудаар устгал хийх ажлыг зохион байгуулж нийт 11 өрхийн 72 үхэр, 94 гахайг зориудаар устгаж акт үйлдэн мэдээ тайланг зохих газарт хүргүүлсэн байна.	100	70
		250. Сумын болзошгүй цагийн байдлын үед хэрэглэх нөөц хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх	Энэ онд шүлхий гарсантай холбогдуулж, Голомтод 7 малын эмч, 21 постод 87 хүн, 21 хөдөлгөөнт эргүүл хяналт тавьж, нийт 44 техник, мэргэжлийн ангиудын болон бусад нийт 144 албан хаагчид онцгой байдлын газраас тухай бүр сургалт, мэргэжлийн зөвлөгөө авч ажилласан. Дээрх ажилд сумын орон нутгийн төсвөөс 30100000 төгрөг зарцуулсан.	100	70
101.	5.1.17 Батлан хамгаалах хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэн,	251. Цэргийн шинэчилсэн тоо бүртгэл, цэрэг татлагын ажлыг	Жил бүр сумын Засаг даргын захирамжаар цэргийн шинэчилсэн тоо бүртгэл болон цэрэг татлагын ажлыг зохион байгуулах сумын комиссыг багийн Засаг дарга,	100	70

	<p>цэргийн алба, түүнтэй холбогдох бүртгэл судалгааг сайжруулан цэргийн насны залуучуудын боловсрол, эрүүл мэндийн үзүүлэлтийг дээшлүүлж, хяналтын тоог хангана.</p>	<p>хуулийн хугацаанд чанартай зохион байгуулж, хугацаат болон гэрээт цэргийн хяналтын тоог биелүүлэх</p>	<p>Зохион байгуулагч нарыг оролцуулан шинэчлэн байгуулдаг. 2017 оны тоо бүртгэлд сумын дүнгээр статистик мэдээгээр 18-60 насны 8675 хүн бүртгэлд орохоос 1-р зэргийн бэлтгэл үүрэгтэн 2532, 2-р зэргийн бэлтгэл үүрэгтэн 5401, тайван цагт цэргийн албанд үл тэнцэгч 311, бэлтгэл офицер 81, бэлтгэл ахлагч 10, бүгд орон нутагтаа байгаа офицер ахлагч 475 бүгд 8499 хүн бүртгэлд орж, хамрагдалт 97.9 хувьтай хамрагдсан бол 2018 тоо бүртгэлд сумын дүнгээр статистик мэдээгээр 18-60 насны 8706 хүн бүртгэлд хамрагдахаас 1-р зэргийн бэлтгэл үүрэгтэн 2427, 2-р зэргийн бэлтгэл үүрэгтэн 5313, тайван цагт цэргийн албанд үл тэнцэгч 311, бэлтгэл офицер 116, бэлтгэл ахлагч 18, бүгд орон нутагтаа байгаа офицер ахлагч 410 бүгд 8284 хүн бүртгэлд орж, 95.1 хувьтай хамрагдсан. 2017 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг татлагад сумын дүнгээр 18-25 насны 707 иргэн хамрагдахаас 688 буюу 98.8 хувь хамрагдаж, 85 иргэн хугацаат цэргийн алба хааж, хяналтын тоог бүрэн биелүүлсэн бол 2018 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг татлагад сумын дүнгээр 18-25 насны 873 иргэн хамрагдахаас 857 буюу 98.2 хувь хамрагдаж, 85 иргэн хугацаат цэргийн алба хааж, хяналтын тоог бүрэн биелүүлсэн.</p>		
		<p><b>252.</b> Цэргийн насны бичиг үсэг мэдэхгүй болон эрүүл мэндийн өвчлөлттэй залуучуудыг эмчлэн эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах</p>	<p>2018 онд сургалт мэдээллийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан бичиг үсгийн боловсрол олгох, түвшинг ахиулах чиглэлээр 4 удаагийн сургалтыг танхимд зохион байгуулж, нийт 17-24 насны 19 иргэн хамруулсан. Сургалтанд хамрагдсан залуучууд танхимын хичээлээс гадна гэрийн даалгавар өгөх, бие даан суралцах гарын авлага болон богино хугацааны эргэн цугларалт зэргийг өөрсдийн санал дээр үндэслэн гэрээ байгуулж ажилласан. Сумын хэмжээнд 18-25 насны 1200 залуучуудын боловсролын түвшингийн судалгаанд хамруулж, баг тус бүрийн мэдээллийн санд баяжилт хөдөлгөөн хийж, мэдээллийн санг шинэчилсэн. 2018 оны ээлжит цэрэг татлагын үзлэгт орох боломжтой</p>	100	70



			<p>цэргийн насны 759 залуучуудын нэрсийг гаргаснаас 609 буюу 80.3 хувь нь ямар нэгэн мэргэжил эзэмшсэн дээд болон мэргэжлийн боловсролтой, 150 нь буюу 16.3 хувь нь бага боловсролтой, 20 нь буюу 2.7 хувь нь хөгжлийн бэрхшээлийн улмаас сурах чадваргүй өвчний давхар оноштой, 4 нь буюу 0.05 хувь нь бичиг үсэг үл мэдэгч байна. Цэрэг татлагын комиссын үзлэгийн үед тогтоогдсон бичиг үсэг үл мэдэгч залуучуудыг судлан үзэхэд цэргийн анкет болон багийн мэдээлэлд худлаа мэдээлдэг, цэрэг татлагын комиссын үзлэгээс өмнө нь шилжин ирсэн шалтгаан байгааг тодруулж, сургалтанд хамрагдах шаардлагатай 4 залууг бичиг үсгийн түвшин тогтоох тестээр шалган 2 залууг танхимын сургалтанд 14-21 хоног хамруулсан бол, 2 заалууд нь хугацаатай гэрийн даалгавар өгсөний үр дүнд анхан шатны түвшинд суралцлаа.</p> <p>2018 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагат хамрагдсан цэргийн насны залуучуудын 78 буюу 24 хувь нь эрүүл мэндээр тэнцэж, 247 буюу 76 хувь нь тэнцээгүй. Эрүүл мэндээр тэнцээгүй 247 цэргийн насны залуучуудын эмчлэгдэх боломжтой оноштой 141 буюу 57 хувь, эмчлэгдэх боломжгүй оноштой 106 буюу 53 хувийг эзэлж байна. Эмчлэгдэх боломжтой оноштой залуучуудыг эрүүлжүүлэх ажлын төлөвлөгөөг Өрхийн эрүүл мэндийн төв тус бүр гаргаж ажиллаж байна.</p> <p><u>2 дугаар ээлжийн 7-13 багийн дүнгээр</u> эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдаж эрүүлжвэл зохих 96 залуугаас 60 буюу 62,5 .5 хувь нь хамрагдаж, 27 буюу 0,45 хувь нь эрүүлжсэн. Эдгэрэлтийн хувь бага байгаа нь хүүхэд насанд үүссэн өвчлөлүүдийг бүрэн эмчлэн эрүүлжүүлээгүйгээс үүдэлтэй төдийгүй, өвчлөлийн байдлыг дүгнэхэд нүдний эмгэг 20 хувь, зүрх судасны эрхтэн тогтолцооны эмгэг 18 хувь, гэмтэл 11 хувь, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг 10 хувийг голчлон эзэлж байгаа нь өвчний эдгэрэлтэд ахиц гарахгүй байгаагийн гол шалтгаан болж байна. Бэлгийн замаар дамжих халдварт өвчин ялангуяа тэмбүүгээр өвчилсөн</p>		
--	--	--	---	--	--

			залуучуудыг харъяа ӨЭМТөвүүд хяналтандаа авч, БОЭТөвийн ДОХ, БЗДХалдварын тасагтай хамтран эрүүлжүүлэх ажлыг 100 хувь хийсэн. Цэргийн насны залуучууд өөр аймаг, хотод ажил хөдөлмөр эрхэлж байгаа шалтгаанаар үзлэг, шинжилгээ, эрүүлжүүлэлтэнд хамрагддаггүй, дараагийн шатлалын эмнэлэгт онош тодруулахаар явуулахад үзүүлэхгүй, хяналтын хугацаандаа ирэхгүй байгаа нь эрүүлжүүлэлтийн хувь бага байгаад нөлөөлж байна.		
		253. ЕБС-ийн сурагчдын дунд эх оронч хүмүүжил төлөвшүүлэх, төрийн болон төрийн бус байгууллага, ААН, иргэдийн дунд Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах ажлуудыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх	2018 оны байдлаар 1, 2 дугаар ээлжийн цэрэг татлагын зарыг орон нутгийн 2 телевизийн сувгаар 10 удаагийн давтамжтайгаар 10 удаа, сумын цахим хуудас болон facebook /+5000/ хаягаар, 13 багийн 18-25 насны 1580 иргэнд биеэр зарлан дуудах хүргэж, мөн давтамжтайгаар цэргийн тоо бүртгэлийн зарыг 16783 иргэнд хүргэж, Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлан ажиллалаа. Аймгийн Цэргийн штабтай хамтран цэргийн албанд тэнцсэн 167 иргэнд орон нутгийн танилцуулга бүхий багш мэдээллийг агуулсан гарын авлага болон хилийн цэрэг, зэвсэгт хүчний анги салбаруудын мэдээллийг хүргэлээ.	100	70
102.	5.1.18 Хотын гадаад харилцаа хамтынажиллагааг өргөжүүлэн, дэд бүтцийн чиглэлээр тодорхой муж, улстай хамтран ажиллах эхлэлийг тавина.	254. Дэд бүтцийн чиглэлээр тодорхой муж, улстай гэрээ байгуулан хамтран ажиллах	Үнэлэх боломжгүй.	-	-
		255. Орон нутгийн хөгжилд дотоод, гадаадын хөрөнгө оруулалт татах, үр ашигтай хэрэгжилтийг хангуулах	Аймгийн Засаг даргын дэргэдэх төсөл хөтөлбөрийн багтай хамтран БНХАУ-ын ӨМӨЗО-ны Алшаа аймгийн Эзнээ хошуутай хамтран ажиллах санамж бичгийг байгуулж, харилцаа тогтоох тохиролцоонд хүрсэн.	70	40
<b>Тавдугаар бүлгийн дүн</b>				<b>94.2</b>	<b>73.0</b>
<b>Хөтөлбөрийн нэгдсэн дүн /5 бүлэг, 102 зорилт, 255 арга хэмжээ/</b>				<b>93.4</b>	<b>70.1</b>

АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР

